



АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

EITI
Extractive Industries
Transparency Initiative

UHY GROWTH FINANCE
GROWTH FINANCE AUDIT LLC



МОНГОЛ УЛСЫН АРВАН ЕСДҮГЭЭР БУЮУ 2024 ОНЫ **НЭГТГЭЛ ТАЙЛАН**

Олборлох үйлдвэрлэлийн ил тод
байдлын санаачилга



МОНГОЛ УЛСЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН **АРВАН** **ЕСДҮГЭЭР** БУЮУ 2024 ОНЫ НЭГТГЭЛ ТАЙЛАН

ЗАХИАЛАГЧ

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Монголын ОУИТБС-ын
Ажлын алба

 +976 7011 0525

 7011 0155

 www.eitimongolia.mn

 Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын
санаачилга

ГҮЙЦЭТГЭГЧ

“Эс Ай Си Эй” ХХК, “Гроут Финанс аудит” ХХК

 +976 7012-6009

 information@sica.mn

 www.sica.mn

 Sica Mongolia

 +976 7014-4341

 info@growthfinance.mn

 www.growthfinance.mn

 Growth Finance Audit

Тайланг олон нийт ажлын хэрэгцээнд зориулан бүтэн болон хэсэгчлэн авч ашиглах нь нээлттэй тул ашигласан тохиолдолд эх сурвалж нь Монгол Улсын ОУИТБС-ын 19 дүгээр буюу 2024 оны нэгтгэл тайлан болохыг дурдана уу.

Цаасны хэмжээ: 210 x 297 мм

Хэвлэлийн хуудас: 19.5 хх

ХХК-д хэвлэв.

МОНГОЛ УЛСЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН **АРВАН** **ЕСДҮГЭЭР** БУЮУ 2024 ОНЫ НЭГТГЭЛ ТАЙЛАН



**ЭНЭХҮҮ ТАЙЛАН БОЛОН ХАВСРАЛТУУДЫГ
МОНГОЛЫН ОУИТБС-ЫГ МОНГОЛ УЛСАД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН АЛБАНЫ
ХҮСЭЛТЭЭР, ОУИТБС-ЫН ЗОРИЛГЫН ҮҮДНЭЭС
МОНГОЛЫН ОУИТБС-ЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ,
ОЛОН ТАЛТ АЖЛЫН ХЭСЭГ БОЛОН ОЛОН
НИЙТЭД ЗОРИУЛСАН БОЛНО.**

ОУИТБС-ын шаардлага болон ажлын даалгаврын дагуу ил тод болох шаардлагатай мэдээллүүдийг хавсралтаар харуулсан. Зарим хавсралт их хэмжээний мэдээлэл агуулсан тул энэхүү тайланд иж бүрнээр оруулахад хүндрэлтэй байсан тул хураангуйлж оруулсан. Дэлгэрэнгүй хавсралтуудыг ашиглахад хялбар байх үүднээс ОУИТБС-ын ажлын албаны цахим хуудаст Ms Excel форматаар ил тод болгосон.

ГҮЙЦЭТГЭГЧ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

БАГИЙН АХЛАГЧ

- *Г.Эрдэнэ, Эс Ай Си Эй ХХК-ийн Дэд захирал*

ТАЙЛАНГИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- *Т.Түмэнчимэг, Эс Ай Си Эй ХХК-ийн Судалгааны хэлтсийн захирал*
- *Б.Удвал, Эс Ай Си Эй ХХК-ийн Судалгааны хэлтсийн менежер*
- *О.Энхзул, Эс Ай Си Эй ХХК-ийн Судалгааны хэлтсийн менежер*

АУДИТ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- *Б.Бямба, Гроут Финанс аудит ХХК-ийн Аудитор, мэргэшсэн нягтлан бодогч*
- *Т. Ганбат, Гроут Финанс аудит ХХК-ийн Аудитор, нягтлан бодогч*

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	7
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	10
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	10
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	11
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТАНИЛЦУУЛГА	15
1.1 ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ	16
1.2 ХАРААТ БУС ХЯНАГЧ-НЭГТГЭГЧИЙН ҮҮРЭГ	17
1.3 ОРОЛЦОГЧИД	18
1.4 ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ	18
1.5 ТАЛАРХАЛ	19
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОХИРУУЛГЫН АРГАЧЛАЛ БА МЭДЭЭЛЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ	21
2.1 МЭДЭЭЛЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ	21
2.1.1. Эхлэлийн тайлангийн үйл явц	22
2.1.2. Төлбөр, орлогын бодит байдал (Материаллаг байдал)	22
2.1.3. Тайланд хамруулах компаниудын сонголт.....	23
2.2 МЭДЭЭЛЛИЙН ЦУГЛУУЛАЛТЫН АРГАЧЛАЛ	24
2.2.1. 2024 оны нэгтгэлд ашигласан маягтууд.....	25
2.2.2. Задаргааны түвшин.....	26
2.3 БАТАЛГААЖУУЛАЛТ	26
2.3.1. Монгол Улсын аудит, баталгаажуулалтын орчин нөхцөл	26
2.3.2. ОУИТБС-ын тайлангийн баталгаажуулах явц.....	27
2.4 МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВ БАЙДАЛ	28
2.4.1. Тайлан тушаалт, хариу ирүүлсэн байдал.....	28
2.4.2. Төрийн оролцооны ил тод байдлын шаардлага	30
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТОХИРУУЛГЫН ҮР ДҮН	34
3.1 ТОХИРУУЛГЫН ЦАР ХҮРЭЭ	34
3.2 ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ОРЛОГО	35
3.2.1. Нийт олборлох үйлдвэрлэлийн салбараас 2024 онд Засгийн газрын хүлээн авсан орлого.....	35
3.2.2. Засгийн газрын тайлагнасан орлогын тохируулга	36
3.2.3. Засгийн газар ба компанийн урсгалуудын харьцуулалт, тохируулгын дараах байдлаар36	
3.2.4. Олборлох салбарын орлогын хураангуй.....	37
3.3 АНХЛАН ТАЙЛАГНАСАН УРСГАЛУУДЫН ХУРААНГУЙ	38
3.4 АНХНЫ ТОХИРУУЛААГҮЙ ЗӨРҮҮ БОЛОН ТАЙЛАГНААГҮЙ КОМПАНИУД	39

3.5	ТОХИРУУЛААГҮЙ ҮЛДСЭН ЗӨРҮҮ	40
3.6	НЭГТГЭЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ҮР ДҮН	43
	ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛЫН ОЛБОРЛОХ САЛБАРЫН ТОЙМ	50
4.1	ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО, ТӨСВИЙН БОДЛОГЫН ТОЙМ (шаардлага 2.1)	50
4.1.1	Эрх зүйн хүрээнд орсон өөрчлөлтийн тойм	50
4.1.2	Төсвийн бодлого, төсвийн хууль тогтоомж	55
4.2	ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛӨЛ (Шаардлага 3.1 болон шаардлага 6.3)	57
4.2.1	Төвлөрүүлсэн орлого (Шаардлага 4.1)	58
4.2.2	Экспортын орлого (Шаардлага 3.3)	59
4.2.3	Үйлдвэрлэл (Шаардлага 3.2)	63
4.3	АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ, АШИГЛАЛТ БА ЛИЦЕНЗИЙН БОДЛОГО	66
4.3.1	Ураны тухай тойм мэдээлэл	66
4.3.2	Стратегийн ач холбогдол бүхий ордууд	68
4.3.3	Бичил уул уурхай буюу гар аргаар ашигт малтмал олборлох	72
4.3.4	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа (шаардлага 2.2, шаардлага 2.3)	74
4.4	ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРЫН ТОЙМ	84
4.4.1	Газрын тосны нөөц ба төрийн оролцоо	84
4.4.2	Газрын тосны хайгуул болон тусгай зөвшөөрөл (Шаардлага 2.2.а)	85
4.4.3	Бүтээгдэхүүн хуваах гэрээ (Шаардлага 2.4)	87
4.4.4	Газрын тосны үйлдвэрлэл, эдийн засгийн үзүүлэлт	87
4.4.5	Байгалийн хийн тойм	90
4.5	ОЛБОРЛОХ САЛБАР ДАХЬ ТӨРИЙН ОРОЛЦОО (шаардлага 2.6, 4.5, 6.2)	90
4.5.1	ЗГ болон ТӨААН-ийн олборлох салбарын компаниуд дахь эзэмшил, эзэмшилд гарсан өөрчлөлтийн шилжүүлгийн нөхцөл	91
4.5.2	Засгийн газар болон ТӨААН-ийн санхүүгийн харилцаа, гүйлгээ (Шаардлага 2.6, 4.2, 4.5)	93
4.5.3	ТӨААН-д санхүүгийн тайлангаа олон нийтэд ил тод болгосон байдал (Шаардлага 2.6.б)	94
4.5.4	ТӨААН-ийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалт, худалдан авалт болон засаглалын зохицуулалт (ОУИТБС Шаардлага 2.6.с)	96
4.5.5	Төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөрүүд	100
4.6	ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ БОЛОН ОРЛОГЫН ХУВААРИЛАЛТ	100
4.6.1	Орлогын хуваарилалт	100
4.6.2	Орон нутгийн төлбөрүүд болон төсөвт төвлөрүүлж бүртгээгүй тохиолдол (Шаардлага 4.6 болон шаардлага 5.1)	102

4.6.3 Орлогын менежмент ба зарцуулалт (Шаардлага 4.1 болон шаардлага 4.7)
103

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД АСУУДАЛ	107
5.1 ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧ, ТҮҮНИЙ ИЛ ТОД БАЙДАЛ (шаардлага 2.5).....	107
5.2 ГЭРЭЭНИЙ ИЛ ТОД БАЙДАЛ	109
5.3 ДЭД БҮТЦЭД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ БА БАРТЕРЫН СОЛИЛЦОО (шаардлага 4.3) 112	
5.4 ТЭЭВЭРЛЭЛТИЙН ОРЛОГО (шаардлага 4.4).....	112
5.5 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ (шаардлага 6.4)	114
5.6 ЦАХИМ ТАЙЛАГНАЛЫН СИСТЕМ	118
5.7 АШИГЛАСАН УСНЫ МЭДЭЭЛЭЛ	120
5.8 ХОГ ХАЯГДЛЫН МЭДЭЭЛЭЛ.....	120
5.9 ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРУУЛАЛТ БА ТӨСЛИЙН ЗАРДАЛ (шаардлага 3.4 болон шаардлага 4.10)	121
5.9.1 Оюутолгой ГХО ХХК-ийн хүлэмжийн хийн ялгаруулалтын тухай	121
5.9.2 Оюутолгой ГХО ХХК-ийн төслийн зардал	123
5.9.3 Бадрах энерги ХХК-ийн төслийн зардал.....	124
ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	127
6.1 ӨМНӨХ ЖИЛҮҮДИЙН НЭГТГЭЛ ТАЙЛАНГААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ.....	127
6.2 2022 ОНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ТАЙЛАНГААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН МӨРӨӨР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	135
6.3 ОУИТБС-ЫН ТАЙЛАГНАЛ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ.....	142
ХАВСРАЛТ	145

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ТОВЧЛОЛ	МОНГОЛ ТАЙЛБАР	АНГЛИ ТАЙЛБАР
ААН	Аж ахуйн нэгж	Entity
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	Corporate Income Tax
Ам.доллар	Америкийн нэгдсэн улсын мөнгөн тэмдэгт (доллар)	United States Dollars
АМГТГ	Ашигт малтмал газрын тосны газар	Mineral Resources and Petroleum Authority
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	License fee for exploitation and exploration of mineral resources
АНУ	Америкийн нэгдсэн улс	United States of America
АНЭУ	Арабын Нэгдсэн Эмират Улс	United Arab Emirates
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт	International Standards on Auditing
АҮЭБЯ	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	Ministry of Mining and Heavy Industry
БНУ	Бүгд Найрамдах Улс	Republic
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос улс	Republic of Korea
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	Republic of China
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ	Production Sharing Agreement
БО	Байгаль орчин	Environment
БОНХАЖЯ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам	Ministry of Environment, Green Development and Tourism
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	Ministry of Environment and Tourism
БОХТ	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Environmental protection plan
БУУ	Бичил уул уурхай	Micro mining
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ	Product Sharing Agreement
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Ministry of Family, labour and social protection
ГЕГ	Гаалийн ерөнхий газар	Customs General Administration
ГТГ	Газрын тосны газар	Petroleum Authority
ГТХ	Газрын тосны хайгуул	Oil exploration
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн	Gross Domestic Product
ДЦС	Дулааны цахилгаан станц	Thermal Power
ЖГҮ	Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ	Annual Performance Evaluation
ЗГ	Засгийн газар	Government
ЗДТГ	Засаг даргын тамгын газар	Governor's office
ИБУИНВУ	Их Британи болон Хойд Ирландын Нэгдсэн Вант Улс	United Kingdom of Great Britain and Northern Ireland
МОУИТБС	Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга	Mongolia Extractive Industry Transparency Initiative
МУ	Монгол улс	Mongolia
МУУА	Монголын уул уурхайн үндэсний ассоциаци	Mongolian National Mining Association
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	State Professional Inspection Agency

ТОВЧЛОЛ	МОНГОЛ ТАЙЛБАР	АНГЛИ ТАЙЛБАР
Мян.тн	Мянган тонн	Thousand tonnes
НББ	Нягтлан бодох бүртгэл	Accounting
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт	International Accounting Standards
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар	General Department of Social Insurance
НДС	Нийгмийн даатгалын сан	Social Insurance Fund
ННФ	Нээлттэй нийгэм форум	Open Society Forum
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар	Value Added Tax
НУ	Нутгийн удирдлага	Local governance
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан	Local Development Consolidated Fund
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан	Local Development Fund
ОТАХ	Олон талт оролцогчдын ажлын хэсэг	Multi-Stakeholder Working Group
ОУ	Олон улс	International
ОУИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга	Extractive Industry Transparency Initiative
ОХУ	Оросын холбооны улс	Russia Federation
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт	International Standards on Financial Reporting
СЯ	Сангийн яам	Ministry of Finance
ТАН	Төлсөн Авснаа Нийтэл	Publsih What You Pay
ТББ	Төрийн бус байгууллага	Non-governmental Organization
ТБУ	Тогтвортой бичил уурхай	Sustainable artisanal mining
ТЕГ	Татварын ерөнхий газар	General Department of taxation
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч	General budget governor
ТЕХ	Татварын ерөнхий хууль	General Law of Mongolia on taxation
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж	State-Owned Entities
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	Government agency for policy coordination on state property
ТӨК	Төрийн өмчит компани	State-Owned Companies
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани	State-Owned Joint Stock Company
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл	Board of Directors
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл	Technical and Economic Feasibility Study
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар	General Authority for State Registration
УБТЗ ХНН	Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэг	Ulaanbaatar Railway Joint Stock Company
УИХ	Улсын их хурал	Parliament of Mongolia
УТНЭ	Улс төр, нам эвсэл	Politics, political parties and coalitions
ҮАГ	Үндэсний аудитын газар	Mogolian National Audit office
ҮАУТ	Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө	National action plan
ҮСХ	Үндэсний статистикийн хороо	National statistics of Mongolia
ХАЗ	Хайгуулын ажлын зардал	Exploration Expenditure Cost

ТОВЧЛОЛ	МОНГОЛ ТАЙЛБАР	АНГЛИ ТАЙЛБАР
ХБ	Хөрөнгийн бирж	Stock Exchange
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам	Ministry of Justice and Home Affairs
ХК	Хувьцаат компани	Joint Stock Company
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	Limited Liability Company
ЦТС	Цахим тайлангийн систем	Electronic reporting system
ЭБМЗ	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл	Mineral Professional Council
ЭӨ	Эцсийн өмчлөгч	Beneficial owner

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Засгийн газрын байгууллагуудын хүлээн авсан төлбөр, орлого, сая төгрөгөөр..	23
График 2. ДНБ, Уул уурхайн салбарын дүн, эзлэх хувь, (оны үнээр), 2020-2024 он, тэрбум төгрөг	58
График 3. Эрдэс баялгийн салбарын төвлөрүүлсэн орлого, 2020-2024 он, тэрбум төгрөг .	58
График 4. Эрдэс баялгийн салбарын төвлөрүүлсэн орлого, салбараар, 2023-2024 он, тэрбум төгрөг	59
График 5. Эрдэс бүтээгдэхүүний экспортын биелэлт, голлох бүтээгдэхүүнээр, 2024 он	60
График 6. Эрдэс баялгийн салбарын экспортын үнэлгээ (сая ам.доллар), хэмжээ, 2024 он	61
График 7. Монгол банкны худалдан авсан алтны хэмжээ, 2020-2024 (кг).....	72
График 8. Монгол банкны худалдан авсан алтны хэмжээ, 2024 он, сараар (кг)	73
График 9. Ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо, талбайн хэмжээ (мянган га), 2020-2024 он.....	74
График 10. Газрын тосны бүтээгдэхүүний үлдэгдэл нөөц төрлөөр (тонн), 2023-2024 он	85
График 11. Газрын тосны олборлолт (мянган баррель), 2021-2024 он.....	89
График 12. Газрын тосны экспорт (мянган баррель), 2021-2024 он	89
График 13. Мэдээллийн санд байршуулсан гэрээний тоо.....	111
График 14. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны үлдэгдэл.....	116
График 15. ОУИТБС-ын Цахим тайлангийн системийн гарын авлага	119
График 16. Зөвлөмжийн хэрэгжилт, оноор, төлөвөөр	127

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хараат бус хянагч-нэгтгэгчийн үүргийн дүрслэлтэй процесс	18
Зураг 2. Нэгтгэл тайланд хамруулсан компаниудын үйл ажиллагааны чиглэл.....	23
Зураг 3. Цахим тайлангийн систем дэх талуудын оролцоо.....	25
Зураг 4. ОУИТБС-ын тайлангийн баталгаажуулах явц.....	27
Зураг 5. Газрын тосны эрэл, хайгуулын байршил.....	86
Зураг 6. Газрын тосны экспортын төлөвлөгөө, гүйцэтгэл 2024 он	88
Зураг 7. Улсын төсөв, аудитын үйл ажиллагааны нээлттэй мэдээлэл	105
Зураг 8. БОТБҮ хийх үйл явц.....	117
Зураг 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үе шат	118
Зураг 10. Цахим тайлагналын системийг боловсруулахдаа баримталсан зарчмууд	119
Зураг 11. 2024 оны хүлэмжийн хийн 1, 2-р хүрээний ялгарал.....	122

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Засгийн газрын тайлагнасан орлого болон компанийн тоо, тэрбум төгрөгөөр	22
Хүснэгт 2. ТББ-аас санал болгон сонгогдсон 45 компани	23
Хүснэгт 3. Компаниудаас ирсэн мэдээлэл	28
Хүснэгт 4. Сонгогдсон байгууллагуудын маягт бөглөсөн байдал	29
Хүснэгт 5. Тайланд хамрагдахаас татгалзсан ААН байгууллагууд	31
Хүснэгт 6. Цахим тайлангийн системд бүртгэлгүй ААН-ийн жагсаалт	35
Хүснэгт 7. Засгийн газрын хүлээн авсан орлого, байгууллагаар, сая төгрөгөөр	35
Хүснэгт 8. Засгийн газрын тайлагнасан орлогын тохируулга, сая төгрөгөөр	36
Хүснэгт 9. Засгийн газар, компанийн орлогын урсгалын тохируулга, сая төгрөгөөр	36
Хүснэгт 10. Нэгтгэл тайлангийн үр дүн, ТОП 5 татвар төлөгч байгууллага, 2020-2024 он, сая төгрөгөөр	37
Хүснэгт 11. Нэгтгэлд хамрагдсан 110 компаниас хамгийн их татвар төлсөн топ 20 компани, сая төгрөгөөр, хувиар	37
Хүснэгт 12. Нэгтгэлд хамрагдсан 110 компаниас хамгийн бага татвар төлсөн 20 компани, сая төгрөгөөр, хувиар	38
Хүснэгт 13. ОУИТБС-ын нэгтгэл тайланд хамрагдсан 110 компаниас 2024 онд татвар төлсөн нь баталгаажуулаагүй компаниуд	38
Хүснэгт 14. Анхны тайлагнасан төлбөр, орлогын урсгал ба тохируулга, сая төгрөгөөр	39
Хүснэгт 15. Анхны тайлагнасан төлбөр, орлогын урсгал ба тохируулга, сая төгрөгөөр	39
Хүснэгт 16. Тохируулаагүй зөрүү, сая төгрөгөөр	39
Хүснэгт 17. Тохируулаагүй үлдсэн зөрүү, орлогын урсгалаар, сая төгрөгөөр	40
Хүснэгт 18. Тохируулаагүй үлдсэн зөрүү, компаниар, сая төгрөгөөр	41
Хүснэгт 19. Орон нутгийн хэмжээний гол урсгалууд, сая төгрөгөөр	43
Хүснэгт 20. Улсын хэмжээний гол урсгалууд, сая төгрөгөөр	44
Хүснэгт 21. Улсын хэмжээний нэгтгэл, орлогын урсгалаар, сая төгрөгөөр	45
Хүснэгт 22. 2024 онд олборлох салбарт орсон хуулийн өөрчлөлтийн тойм	51
Хүснэгт 23. 2024 онд олборлох салбарт орсон УИХ-ын тогтоолын өөрчлөлтийн тойм	51
Хүснэгт 24. 2024 онд олборлох салбарт орсон Засгийн Газрын тогтоолын өөрчлөлтийн тойм	53
Хүснэгт 25. Төсвийн хууль тогтоомж	56
Хүснэгт 26. Төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээ, салбараар, 2023-2024 он, тэрбум төгрөг	59
Хүснэгт 27. Эрдэс бүтээгдэхүүний экспортын дундаж үнэ	60
Хүснэгт 28. Нэгтгэл тайланд хамрагдаж буй аж ахуйн нэгжүүдийн 2024 оны борлуулалтын хэмжээ	61
Хүснэгт 29. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн хэмжээ	63

Хүснэгт 30. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн үнийн дүн, тэрбум төгрөг	64
Хүснэгт 31. Нэгтгэл тайланд хамрагдаж буй аж ахуйн нэгжүүдийн 2024 оны олборлолтын хэмжээ	64
Хүснэгт 32. 2024 онд Цөмийн энергийн тухай хуульд орсон өөрчлөлтүүд.....	67
Хүснэгт 33. Хүчин төгөлдөр байгаа Ураны тусгай зөвшөөрлүүд.....	68
Хүснэгт 34. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордууд (Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт).....	68
Хүснэгт 35. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордууд (Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт).....	69
Хүснэгт 36. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох дүгнэлт гарсан талбай	73
Хүснэгт 37. Хөдөлгөөн хийгдсэн тусгай зөвшөөрлийн тоо, төрлөөр, 2020-2024 он	75
Хүснэгт 38. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын төлбөрийн мэдээлэл, 110 ААН-ээр, 2024 он	77
Хүснэгт 39. Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” (МГТБҮ) ТӨХХК-ийн төслийн хураангуй.....	84
Хүснэгт 40. Монгол Улсын газрын тосны нөөцийн мэдээлэл, сая тонн	85
Хүснэгт 41. Газрын тос, байгалийн хийн борлуулалтын мөнгөн дүн, 2023-2024 он.....	88
Хүснэгт 42. Газрын тос, байгалийн хийн олборлолтын мөнгөн дүн, 2023-2024 он	88
Хүснэгт 43. Төрийн байгууллагуудын ОҮИТБС-д оролцооны үнэлгээ	91
Хүснэгт 44. ТӨААН-ийн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл	92
Хүснэгт 45. ТӨААН хоорондын гүйлгээний ил тод байдал	94
Хүснэгт 46. ТӨААН-үүдийн тайлангийн стандарт хангалт, ил тод байдал	95
Хүснэгт 47. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайлангийн ил тод байдал	95
Хүснэгт 48. ТӨААН-үүд аудитын тайлангаа ил тод болгосон эсэх	96
Хүснэгт 49. ТӨААН-ийн компанийн дотоод дүрэм, журам ил тод болгосон байдал.....	97
Хүснэгт 50. ТӨААН-ийн худалдан авалтын ил тод байдалд хамааралтай хууль, тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлт	97
Хүснэгт 51. Шилэн дансанд ил тод болгосон эсэх.....	98
Хүснэгт 52. Худалдан авалтын ил тод байдал.....	99
Хүснэгт 53. ТӨААН-ийн шилэн дансны мэдээлэл	100
Хүснэгт 54. 2024 оны төсвийн үйл явцын шинэчлэлт.....	100
Хүснэгт 55. Олборлох салбарын зээллэгийн өөрчлөлтийн мэдээлэл, тэрбум төгрөгөөр ..	101
Хүснэгт 56. Монгол улсын 2024 оны төсөвт аймгуудад олгохоор батлагдсан санхүүгийн дэмжлэгийн дүн /сая.төг/	102
Хүснэгт 57. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд олгох 2024 оны орлогын шилжүүлгийн батлагдсан дүн /сая.төг/.....	103
Хүснэгт 58. 2024 оны гүйцэтгэл	104

Хүснэгт 59. ОУИТБС-ын Олон улсын хорооноос хэрэгжүүлсэн эцсийн өмчлөгчийн арга хэмжээ	107
Хүснэгт 60. Тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн эцсийн өмчлөгч	107
Хүснэгт 61. ОУИТБС-ын цахим тайлангийн системд бүртгэгдсэн эцсийн өмчлөгчид	108
Хүснэгт 62. Гэрээ, түүний ил тод байдалд холбогдох зүйл заалт	109
Хүснэгт 63. Мэдээллийн санд байршуулсан гэрээ	111
Хүснэгт 64. ААН-үүдийн тээвэрлэлтийн өндөр орлого хүлээн авсан ТОП 12 компани.....	112
Хүснэгт 65. Авто тээврээр тээвэрлэсэн экспортын ачааны мэдээ, өссөн дүнгээр.....	113
Хүснэгт 66. Төмөр замаар тээвэрлэсэн экспортын ачааны мэдээ, өссөн дүнгээр.....	113
Хүснэгт 67. Нийт экспортын ачааны мэдээ, өссөн дүнгээр	114
Хүснэгт 68. Газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын эрх олгосон аж ахуйн нэгжүүдийн 2024 оны нэгтгэл	115
Хүснэгт 69. Ус ашиглалт	120
Хүснэгт 70. 2024 онд ус ашигласны төлбөр төлсөн ТОП 10 компани, сая төгрөгөөр	120
Хүснэгт 71. Хог хаягдлын мэдээлэл, м3	120
Хүснэгт 72. Хог хаягдлын өндөр төлбөр төлсөн 10 компани, мян.төгрөгөөр	121
Хүснэгт 73. Оюутолгой ХХК-ийн төслийн зардал.....	123
Хүснэгт 74. Бадрах энерги ХХК-ийн төслийн зардал, мянган төгрөг	124
Хүснэгт 75. Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, 2025 оны 10-р сарын 06-ны байдлаар	127
Хүснэгт 76. 2022 оны Баталгаажуулалтын тайлангаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө	135

ТАНИЛЦУУЛГА



НЭГДҮГЭЭР
БҮЛЭГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТАНИЛЦУУЛГА

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА (ОУИТБС)

Ашигт малтмал, газрын тос, байгалийн хий зэрэг байгалийн баялгийн олборлолтоос бий болсон орлого, татвар, төлбөр, ашиг хуваарилалттай холбоотой мэдээллийг **олон нийтэд ил тод, нээлттэй** болгож, түүнийг нийтийн сайн сайхны төлөө зөв захиран зарцуулахад чиглэсэн **олон улсын сайн дурын стандарт, түншлэл** юм.



ЗОРИЛГО

- Байгалийн баялгийн орлогоос улбаатай авлига, хяналтын сул тал, **мэдээллийн хаалттай байдлыг бууруулах;**
- Иргэдийг орлого, зарцуулалтын талаарх **баталгаатай мэдээллээр хангаж, нийгмийн хяналт тогтоох;**
- Төр, хувийн хэвшил, иргэний **нийгмийн тэгш оролцоотойгоор** сайн засаглалыг бэхжүүлэх;



ҮНДСЭН ЗАРЧИМ

- 1) **Компанийн тайлагналт:** Олборлох салбарын компаниуд төлсөн татвар, төлбөрөө тайлагнана.
- 2) **Засгийн газрын тайлагналт:** Хүлээн авсан орлого, түүнтэй холбоотой зарцуулалтыг тайлагнана.
- 3) **Хараат бус баталгаажуулалт:** Хараат бус хянагч - нэгтгэгч баталгаажуулж, олон нийтэд ил тод тайлан танилцуулна.
- 4) **Олон талт оролцоо:** Төр, компани, иргэний нийгмийн төлөөлөлтэй олон талт оролцогчдын бүлэг удирдан зохицуулах.

Монгол Улс нь 2006 онд ОУИТБС-д нэгдсэн цагаасаа эхлэн нийт **18 удаагийн тайлан** бэлтгэн, олон нийтэд танилцуулсан бөгөөд энэхүү **19 дэх тайлангийн** Хараат бус хянагч-нэгтгэгчээр “Эс Ай Си Эй” ХХК болон “Гроут Финанс Аудит” ХХК-ын хамтарсан баг дөрөв дэх удаагаа сонгогдон ажиллаж байна.

2016	Стандарт батлагдаж, тайлагналт, оролцогч талуудын хяналтын тогтолцоог боловсронгуй болгосон.
2019	Байгаль орчин, нийгэм, жендерийн тэгш байдлыг хамруулсан өргөтгөл, шаардлага нэмсэн
2023	Гэрээний бүрэн ил тод байдал, эцсийн өмчлөгчийн мэдээллийг заавал тайлагнах үүрэг өгөгдсөн.



АЧ ХОЛБОГДОЛ

- Байгалийн баялгийн орлогоор ард түмний сайн сайхныг нэмэгдүүлэх;
- Төр, компани, иргэний нийгмийн **тогтвортой харилцаа, итгэлцлийг бэхжүүлэх;**
- Уул уурхай, олборлох салбарын тогтвортой, **ил тод, хариуцлагатай хөгжлийг дэмжих;**

1.1 ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Засгийн газар 2006 онд уг санаачилгыг хэрэгжүүлэхээ зарлан, ажлуудыг шат дараатайгаар эхлүүлсэн байна. Энэ хүрээнд ОУИТБС-ыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газар, уул уурхайн компаниуд, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулсан **Үндэсний зөвлөл** болон **Олон талт оролцогчдын ажлын хэсгийг (ОТАХ)** байгуулжээ.

*ОУИТБС-ын **СТАНДАРТ** нь санаачилгыг хэрэгжүүлэх зарчим, шаардлагыг тодорхойлсон баримт бичиг бөгөөд 2016 оны 2 дугаар сарын 24-өөс 25-нд Перу улсын Лима хотод болсон ОУИТБС-ын олон улсын хуралдаанаар батлагдсан. Үүнээс хойш тус стандартыг **2016, 2019, 2023** онуудад гурван удаа шинэчлэн баталжээ.*

Уг **стандарт** нь ОУИТБС-ын мэдээллийг цуглуулахдаа улс орнуудын одоо мөрдөж буй тайлан гаргалтын тогтолцоог ашиглахыг дэмждэг бөгөөд үр дүнг ил тод, нээлттэй байлгахыг шаардана. Мөн олборлох үйл ажиллагаанаас ашиг хүртэж буй хувь хүмүүсийн мэдээллийг ил болгох, төслүүдэд оролцож буй компаниуд эцсийн өмчлөгч буюу ашиг хүртэгч эздээ ил тод мэдээлэхийг бүх гишүүн орнуудад заавал биелүүлэх шаардлагатай гэж тусгасан.

- ✓ **2016 оны** стандартын хүрээнд гишүүн орнууд ОУИТБС-ын шаардлагыг хэрхэн хэрэгжүүлж буйг үнэлэх **баталгаажуулалтын тогтолцоо** илүү боловсронгуй болсон. Журамд өөрчлөлт ороогүй боловч үнэлгээнд улс орнуудын ялгаатай нөхцөл байдал, хамгийн бага шаардлагыг биелүүлэхээс давуулан хэрэгжүүлэх чармайлт, үргэлжлүүлэн сайжруулж буй үйл явцыг өргөн хүрээнд харгалзан үздэг байна.
- ✓ **2019 оны** стандарт нь дэлхийн хэмжээнд тулгамдаж буй байгаль орчин, нийгэм, жендерийн тэгш байдлын нөлөө зэрэг асуудлыг хамруулж, ил тод байдлыг өргөжүүлсэн. Тухайлбал, ашигт малтмалын борлуулалтын мэдээлэл, төслөөр тайлагнах тогтолцоо, мөн 2023 оноос хойш байгуулагдах бүх гэрээг ил тод болгох үүргийг гишүүн орнуудад онцгойлон хүлээлгэсэн.
- ✓ **2023 оны** шинэчлэл нь ОУИТБС-ын ил тод байдлын хүрээг өргөжүүлж, оролцогч улс орнуудад **илүү нарийвчилсан тайлагналт, гэрээний ил тод байдал, ашиг хүртэгч эздийн мэдээлэл** зэрэг шаардлагыг зааж өгсөн байна. Тухайлбал:
 - **Гэрээний бүрэн ил тод байдал** – 2023 оноос хойш байгуулагдсан бүх гэрээ, түүний нэмэлт өөрчлөлтийг олон нийтэд нээлттэй танилцуулахыг үүрэг болгожээ.
 - **Эцсийн өмчлөгч буюу ашиг хүртэгч эздийг ил тод мэдээлэх** – олборлох төслүүдэд оролцож буй хувь хүмүүс болон байгууллагуудын эцсийн өмчлөл, ашиг хүртэх эрхийг бүрэн тайлагнах.
 - **Нээлттэй, ил тод тайлагналтын өргөтгөл** – байгаль орчин, нийгэм, жендерийн тэгш байдал, нийгмийн хариуцлагын хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг тайлагнах шаардлага.
 - **Хэрэгжилтийг сайжруулах хяналт** – улс орнуудын тайлагналт, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог үргэлжлүүлэн боловсронгуй болгох.
- ✓ Энэ шинэчлэлээр ОУИТБС нь зөвхөн татвар, төлбөрийн ил **тод байдалд бус байгаль орчин, нийгэм, ашиг хүртэгчдийн эрх** зэрэг олон талын ил тод байдлыг нэгтгэсэн стандарт болжээ.

1.2 ХАРААТ БУС ХЯНАГЧ-НЭГТГЭГЧИЙН ҮҮРЭГ

ОУИТБС-ын хүрээнд хараат бус хянагч-нэгтгэгч нь хамгийн чухал үүрэгтэй байгууллага бөгөөд **тайлангийн үнэн зөв, ил тод байдлыг** баталгаажуулах гол хяналтын хэрэгсэл бөгөөд дараах чиглэлийн дагуу үүргүүдийг тус тус гүйцэтгэдэг байна.

01 МЭДЭЭЛЛИЙГ ЦУГЛУУЛАХ

- Олборлох салбарын компаниудын төлсөн татвар, төлбөр;
- Засгийн газрын хүлээн авсан орлого, зарцуулалт;
- Орлогын бус мэдээллийг (жишээ: лицензийн нөхцөл, гэрээ, ашиг хүртэгчид) цуглуулж, нэгтгэн тайлан үүсгэх.

02 МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВ БАЙДЛЫГ ХЯНАХ

- Компанийн болон засгийн газрын мэдээллийг харьцуулан шалгаж, зөрүү, зөрчил, алдааг тодорхойлно.
- Алдаа, давхардал, дутуу мэдээллийг тодорхойлж засварлахыг санал болгоно.

03 СТАНДАРТАД НИЙЦЭЖ БУЙ ЭСЭХИЙГ ҮНЭЛЭХ

- ОУИТБС-ын стандартын шаардлага, зарчим (ил тод тайлагналт, эцсийн өмчлөгчийн мэдээлэл, гэрээний ил тод байдал гэх мэт) хангасан эсэхийг шалган дүгнэлт гаргана.

04 ТАЙЛАНГ ОЛОН НИЙТЭД ИЛ ТОД БОЛГОХ

- Баталгаажуулсан тайланг ОУИТБС-ын стандартад нийцүүлэн олон нийтэд танилцуулахад бэлэн болгож, тайлангийн итгэлцлийг нэмэгдүүлэх;

05 ЗӨВЛӨМЖ, САЙЖРУУЛАЛТЫН САНАЛ ГАРГАХ

- Монгол улсын туршлага, стандартын шаардлагад нийцүүлсэн байдал мөн компаниудад сайжруулах арга хэмжээ, тайлагналт болон хяналтын тогтолцооны зөвлөмж өгч, ил тод байдлыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулна.

Дараах зураглалаар хараат бус хянагч-нэгтгэгч нь **төвлөрсөн хяналт** буюу компани болон төрийн мэдээллийн зөрүү, алдааг илрүүлж баталгаажуулж буй үйл явцыг нэгтгэн харууллаа. Монгол Улсын хувьд “Эс Ай Си Эй” ХХК болон “Гроут Финанс Аудит” ХХК хамтарсан баг сүүлийн жилүүдэд энэхүү үүргийг гүйцэтгэж байна.

Зураг 1. Хараат бус хянагч-нэгтгэгчийн үүргийн дүрслэлтэй процесс



1.3 ОРОЛЦОГЧИД

ОУИТБС-ын тайлан нэгтгэлд оролцогч талууд нь гурван үндсэн бүлэг болон тэдний төлөөллүүдээс бүрддэг. Үүнд:

- 1) **Засгийн газар/Төрийн байгууллагуудын төлөөлөл** - Холбогдох төрийн байгууллагууд оролцдог ба компаниудын төлсөн татвар, төлбөр, лицензийн төлбөрийг тайлагнах, цуглуулсан мэдээллээ хараат бус хянагч-нэгтгэгчид хүргүүлэх үүрэгтэй. Мөн тайлангийн дүн, ашиглалтын орлого, орон нутгийн төвлөрсөн орлогыг баталгаажуулдаг байна.
- 2) **Олборлох салбарын төрийн болон хувийн өмчит компаниуд** - Уул уурхай, газрын тос, байгалийн хий олборлогч компаниуд оролцдог ба татвар, төлбөр, лицензийн төлбөр, төслөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, ашиг хүртэгч эздийн мэдээллийг тайлагнах үүрэгтэй. *Нэгтгэл тайланд оролцож буй төрийн болон хувийн өмчит компаниудын талаарх мэдээллийг Хавсралт 1-ээс үзнэ үү.*
- 3) **Иргэний нийгмийн төлөөлөл** - Орон нутгийн иргэний нийгмийн байгууллага оролцдог ба тайлангийн үнэн зөв, ил тод байдлыг хянах, олон нийтэд мэдээллийг тайлагнах, зөвлөмж өгөх мөн олон талт оролцогчдын бүлгийн зөвлөлдөх, хяналт тавих ажиллагаанд идэвхтэй оролцдог байна.

Энэхүү **гурван талт оролцоо** нь олон талт хяналт, ил тод байдлыг баталгаажуулан үндсэн механизмыг бүрдүүлдэг байна.

1.4 ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ

Хараат бус хянагч-нэгтгэгч нь дөрөв дэх жилдээ энэхүү тайланг бэлтгэн гаргаж байгаа бөгөөд нэгтгэл хийх явцад тулгарч буй хүндрэл, бэрхшээлүүд нэмэгдсээр байна. **Тодруулбал, сайн дураар оролцох олборлох салбарын компаниудын идэвх буурч байгаа нь мэдээлэл цуглуулах явцыг удаашруулах болон мэдээллийн чанарыг бууруулах зэрэг сөрөг үр дагаврыг дагуулж байна.** Үүнд:

1. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН ҮЙЛ ЯВЦ

- ✓ Тайлангийн системд мэдээлэл оруулсан ААН, төрийн байгууллагын тоо буурсан буюу сайн дураар оролцох хандлага буурсан явдал;
- ✓ Сонгогдсон компаниудтай холбогдоход холбоо барих мэдээлэл дутмаг, мэдээлэл өгөхдөө хойрго хандах байдал;
- ✓ Компаниудын тайлан дахь өгөгдөл дутуу, хоорондоо зөрүүтэй байх нь нийт тайлангийн үнэн зөвийг бууруулах явдал;

- ✓ Эцсийн өмчлөгч буюу ашиг хүртэгчдийн мэдээлэл бүрэн нээлттэй биш, зарим тохиолдолд нууцлаг байх явдал;
- ✓ Орон нутгийн төвлөрсөн орлого, төсвийн зарцуулалтын мэдээлэл нэгтгэгдээгүй эсвэл хоорондоо нийцэхгүй байх явдал;

2. МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- ✓ Ил тод байдал, тайлагналт, гэрээний мэдээллийг нээлттэй болгох тодорхой зохицуулалт дутмаг байх явдал;
- ✓ Орон нутгийн болон улсын байгууллагуудын үүрэг, хариуцлага бүрэн тодорхой бус байгаа явдал;
- ✓ Тайлан бэлтгэхэд ашиглагдах автоматажсан систем, стандартын дагуу мэдээллийг нэгтгэх программ хангамж хангалтгүй байх явдал;

3. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН УР ЧАДВАР, ОЙЛГОЛТЫН ЗӨРҮҮ

- ✓ Засгийн газрын холбогдох байгууллагуудтай ажиллах шат дараалал ихтэйгээс шаардлагатай мэдээллийг цуглуулахад цаг хугацаа их орох явдал;
- ✓ Төр, компани, иргэний нийгмийн төлөөлөгчдийн мэдээлэл цуглуулах, тайлагналт хийх мэдлэг, туршлага харилцан адилгүй байх явдал;
- ✓ Ил тод байдлын ач холбогдлыг бүрэн ойлгоогүйгээс тайлангийн чанар, нарийвчлал муудах явдал;
- ✓ Олборлох салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ААН болон Төрийн байгууллагын тайлагнах мэдээллийг ирүүлсэн төрийн байгууллагын зүгээс мэдээллийн санд мэдээллийг алдаатай оруулах явдал;

Өмнө жилүүдтэй харьцуулахад системд мэдээлэл оруулсан ААН болон орон нутгийн тайлагналын тоо бага байсан. Нэгтгэл тайланд хамрагдах 110 ААН-ийн 103 ААН нь албан тайланд хамрагдах албан бичгийг хүлээн авсан ба үүнээс 66 байгууллагаас албан бичгийн хариу ирсэн байна. Түүнчлэн мэдээлэл оруулаагүй болон хариу ирүүлээгүй байгууллагуудаас мэдээлэл авах талд нэмэлт хүчин чармайлт гаргахыг шаардсан. Мөн ОУИТБС-ын нэгтгэл тайланд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд хамрагдах ёстой гэсэн эрх зүйн орчин нөхцөл байхгүй. Өөрөөр хэлбэл ямар нэгэн хууль, журам байхгүй учир арван есдүгээр нэгтгэл тайланд хамрагдаж байгаа тодорхой хэдэн байгууллагууд хамрагдахаас татгалзаж, тайланг бэлтгэхэд хүндрэл учруулж байсан.

1.5 ТАЛАРХАЛ



"Эс Ай Си Эй" ХХК-ын Судалгааны ажлын үйл явцад хувийн болон төрийн байгууллагууд, агентлагууд, салбарын холбогдолтой бүхий л байгууллагуудаас шаардлагатай зөвшөөрөл, албан бичиг, баримтуудыг авах, хүргүүлэхэд дэмжлэг үзүүлж, тайлан нэгтгэл боловсруулах ажилд идэвхтэй хамтран оролцон, мэдээллийг цаг тухайд нь ирүүлсэнд тань гүн талархал илэрхийлье.

ТОХИРУУЛГЫН АРГАЧЛАЛ БА МЭДЭЭЛЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ



ХОЁРДУГААР
БҮЛЭГ



ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОХИРУУЛГЫН АРГАЧЛАЛ БА МЭДЭЭЛЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

“Эс Ай Си Эй” ХХК болон “Гроут Финанс Аудит” ХК-ын хамтарсан баг нь нэгтгэл тайланг гэрээт ажлын даалгаварт заасан шаардлагын дагуу гүйцэтгэх үүрэгтэй. Энэхүү нэгтгэлээр олборлох салбарын компаниудын төлсөн төлбөрийг Засгийн газрын хүлээн авсан орлоготой тохируулах ажлыг хийдэг бөгөөд дэлгэрэнгүй мэдээллийг энэ бүлэгт тусгасан болно.
Тохируулгыг хийхдээ мөнгөн суурьт нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлан гүйцэтгэв.

- ➔ Хэрэв цахим тайлагналын системд **төлсөн байгууллага болон хүлээн авсан байгууллагын** аль аль нь материаллаг хэмжээний төлбөр эсвэл орлогоо бүрэн тайлагнаагүй бол энэхүү нэгтгэл тайланд тэдгээрийг багтаах боломжгүй бөгөөд эдгээр мэдээлэл тайланд орхигдох эрсдэлтэй.
- ➔ Харин **Засгийн газар болон компанийн** аль нэг нь тухайн төлбөр, орлогыг тайлагнасан тохиолдолд, орхигдсон мэдээллийг олж авч, нэгтгэлд багтаах бүрэн боломжтой ба өөр тохиолдолд орхигдсон төлбөр, орлогын мэдээлэл нь энэ тайланд багтаагүй болно.
- ➔ Нэгтгэлийн ажлыг тайлагнагч байгууллагуудаас бөглөж ирүүлсэн маягт, мэдээлэл болон тэднээс өгсөн тайлбарт үндэслэн гүйцэтгэсэн болно. Энэхүү нэгтгэлд **тоо мэдээллийн үнэн зөв, иж бүрэн байдалд аудит хийгээгүй** бөгөөд ажиллах явцад тайлагнагч байгууллагуудаас **хүлээн авсан мэдээлэл үнэн зөв гэдэгт** найдаж байна.

2.1 МЭДЭЭЛЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Монгол Улсын ОУИТБС-ын 2024 оны 19 дугаар нэгтгэл тайланд хамрагдах ААН-ийн цар хүрээг тодорхойлохдоо ОТАХ-тэй хамтран дараах асуудлуудыг харгалзаж үзсэн. Үүнд:

Тайланд хамрагдах уул уурхайн салбарын үндсэн мэдээллүүдийн хүрээг тогтоох,

Тайланд хамрагдсан компаниудаас авах нэмэлт мэдээллүүдийн хүрээг тогтоох,

Тайланд хамрагдах материаллаг төлбөр төлсөн компаниудыг тодорхойлох,

Тайланд хамрагдах материаллаг төлбөр хүлээж авсан төрийн байгууллагуудыг тодорхойлох,

Тайлан хамрагдах материаллаг төлбөр бүхий санхүүгийн урсгалуудыг тодорхойлох,

Тайлагнасан тоо мэдээлэл нь үнэн зөв гэдгээ баталгаажуулах хувилбарууд.

2.1.1. Эхлэлийн тайлангийн үйл явц

Эхлэлийн шатанд ОУИТБС-ын 2024 оны тайланд шаардагдах агуулга, ажлын даалгаврыг шаардлагын дагуу нягталж, цахим **тайлагналын иж бүрэн байдлыг** шалгасан. Мөн тайланд хамрагдах компани, төрийн байгууллагууд, төлбөр, орлогын урсгалуудыг тодорхойлж, оролцогч талуудын мэдээллийг системтэйгээр ил тод болгосон байдлыг хянаж, мэдээллийг тодруулах ажлуудыг зохион байгуулсан.

Эхлэлийн үе шатны **ЗОРИЛГО** нь ОУИТБС-ын тайлагналын үйл явцын хамрах хүрээг зөв тодорхойлох, тайлагнах маягтууд, мэдээлэл цуглуулах үйл явц, ОУИТБС-ын тайлан боловсруулах, эцэслэх, хэвлэх хуваарь зэргийг баталгаажуулах явдал юм.

- ◆ 2025 оны 6 дугаар сарын 20-нд **ОТАХ-ийн гишүүдийг хамруулсан эхлэлийн тайлангийн хурал** зохион байгуулж, 2024 оны ОУИТБС-ын тайлангийн агуулга, цар хүрээ, мөн материаллаг хэмжээний төлбөр, орлогын үзүүлэлтүүдийг хэлэлцсэн. Энэхүү семинарын үеэр оролцогч талуудын гаргасан саналыг тусгаж, ТББ-аас хамруулах хүсэлтэй байсан **45 аж ахуйн нэгжийн саналыг авч**, ОУИТБС-ын 2024 оны тайлангийн **хамрах хүрээг ОТАХ-ийн гишүүд баталсан**.

2.1.2. Төлбөр, орлогын бодит байдал (Материаллаг байдал)

Төлбөр, орлогын бодит байдлыг (материаллаг байдал) тооцоход Засгийн газрын тайланд тусгагдсан **нийт төлбөр, орлогын дүнгийн 98 хувиас дээш хэсгийг хамруулах** зарчмыг баримталсан. Тус аргачлалын дагуу уул уурхайн бус компаниудын төлбөр, орлогын дүнг **Засгийн газрын тайлагнасан нийт дүнгээс хасаж тооцсон ба 300 сая төгрөгөөс дээш төлбөр, орлоготой компаниудыг сонгоход нийт төлбөр, орлогын 98 хувийг хамруулах боломжтой** болсон. Энэ үзүүлэлтийг эхлэлийн семинараар хэлэлцэж, ОТАХ албан ёсоор зөвшөөрсөн бөгөөд **ТББ-аас гаргасан саналыг харгалзан үзэж 45 компанийг нэмэлтээр** хамруулсан. Энэхүү мэдээллийг шинжилж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 1. Засгийн газрын тайлагнасан орлого болон компанийн тоо, тэрбум төгрөгөөр

№	Ангилал	Компанийн тоо		ЗГ-ын тайлагнасан дүн		Дүнд эзлэх хувь	
		2023	2024	2023	2024	2023	2024
1	100 тэрбум дээш	11	7	6,975.6	6,779.3	85.5%	87.5%
2	1 тэрбум-100 тэрбум	101	63	1,072.5	906.5	13.1%	11.7%
3	500 сая-1 тэрбум	72	28	51.8	23.2	0.6%	0.3%
4	300сая-500 сая	51	30	20.1	15.5	0.2%	0.2%
5	300 сая хүртэл	958	725	42.9	23.2	0.5%	0.3%
НИЙТ		1,193	853	8,163.1	7,747.8	100%	100%

Үүнээс гадна Засгийн газрын хүлээн авсан нийт орлого, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийн хэмжээнд тулгуурлан алт, зэс, нүүрсний үйл ажиллагаа бүхий **55** компанийг тэргүүнд сонгон авч, **нийтдээ 110 компанийг** тайланд хамруулахаар баталсан.

2.1.3. Тайланд хамруулах компаниудын сонголт

2024 оны нэгтгэлийн тайланд бүх төрлийн төлбөр, орлогын урсгалыг **ямар нэгэн босго тогтоохгүйгээр нийтэд нь хамруулж, үүссэн зөрүүг тохируулах зарчмыг баримталсан** болно. ОУИТБС-ын стандартын шаардлагын дагуу:


- ✓ **4.1** – Татвар болон орлогыг цогцоор нь ил тод болгох;
- ✓ **4.5** – Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдтэй холбоотой гүйлгээг ил тод болгох;
- ✓ **4.6** – Орон нутгийн түвшний төлбөр, орлогыг ил тод харуулах гэх үндсэн зарчмуудыг хэрэгжүүлсэн байна.

Зураг 2. Нэгтгэл тайланд хамруулсан компаниудын үйл ажиллагааны чиглэл



2024 оны нэгтгэлийн дүнгээр, олборлох салбарын компаниуд Засгийн газарт нийт **9.7 их** наяд төгрөгийн төлбөр төлсөн бөгөөд үүнээс **79.7% буюу хамгийн их хэсгийг Татварын ерөнхий газарт төвлөрүүлсэн**, үлдсэн хэсгийг бусад холбогдох байгууллагууд болон орон нутгийн төсөвт төлсөн байна.

График 1. Засгийн газрын байгууллагуудын хүлээн авсан төлбөр, орлого, сая төгрөгөөр



ОУИТБС-ын нэгтгэл тайланд хамруулахаар ТАН эвслээс санал болгож буй 101 тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс дараах **45** компанийг сонгон тайланд хамруулсан байна.

Хүснэгт 2. ТББ-аас санал болгон сонгогдсон 45 компани

№	Регистр	Аймгийн нэр	Компанийн нэр	Өмчийн хэлбэр	Ашигт малтмалын төрөл	Санал болгосон ТББ
1	5098564	Сүхбаатар аймаг	АДАЭ ГХО ХХК	Хувийн	Жонш	Их Бага Баян Шарга ТББ
2	5051118	Сүхбаатар аймаг	Андын илч ГХО ХХК	Хувийн	Нүүрс	Их Бага Баян Шарга ТББ
3	5215919	Сүхбаатар аймаг	Бадмаарагхаш ГХО ХХК	Хувийн	Нүүрс	Их Бага Баян Шарга ТББ
4	6690912	Сүхбаатар аймаг	Бичигт шим майнинг ХХК	Хувийн	Боржин	Их Бага Баян Шарга ТББ
5	5477301	Сүхбаатар аймаг	Блэйкмаунт майнинг ХХК	Хувийн	Холимог металл	Их Бага Баян Шарга ТББ
6	4065115	Ховд аймаг	Вестернхолд ХХК	Хувийн	Шохойн чулуу	Ховдын толь ТББ
7	5122392	Сүхбаатар аймаг	Гаррисон-Азия ГХО ХХК	Хувийн	Алт	Их Бага Баян Шарга ТББ
8	5060222	Сүхбаатар аймаг	Голденхейлс ГХО ХХК	Хувийн	Молибден, Гянтболд	Их Бага Баян Шарга ТББ
9	6194559	Сүхбаатар аймаг	Гуо мао жиа хэ ГХО ХХК	Хувийн	Нүүрс	Их Бага Баян Шарга ТББ
10	2074737	Сүхбаатар аймаг	Гурвансайхан ГХО ХХК	Хувийн	Уран	Их Бага Баян Шарга ТББ
11	5070287	Сүхбаатар аймаг	Дорнын чулуулаг ХХК	Хувийн	Нүүрс	Их Бага Баян Шарга ТББ
12	5463599	Сүхбаатар аймаг	Каскейдмайнинг ГХО ХХК	Хувийн	Төмөр	Их Бага Баян Шарга ТББ
13	2708345	Сүхбаатар аймаг	Лэндмонголиа ГХО ХХК	Хувийн	Алт	Их Бага Баян Шарга ТББ
14	5070651	Сүхбаатар аймаг	Миний тоонот ХХК	Хувийн	Гянтболд	Их Бага Баян Шарга ТББ
15	5036496	Сүхбаатар аймаг	Молиметал ГХО ХХК	Хувийн	Зэс, молибден	Их Бага Баян Шарга ТББ
16	5253535	Сүхбаатар аймаг	Монгол майнинг энд эксплорэйшн ХХК	Хувийн	Алт	Их Бага Баян Шарга ТББ
17	5150884	Сүхбаатар аймаг	Монгол ураниум ресурс ХХК	Хувийн	Нүүрс	Их Бага Баян Шарга ТББ
18	5051304	Сүхбаатар аймаг	Монголжүюаньли ГХО ХХК	Хувийн	Жонш	Их Бага Баян Шарга ТББ
19	5401801	Ховд аймаг	Монголиан нэшнл рийр ийрт корп ГХОХХК	Хувийн	Газрын ховор элемент, цацраг идэвхит бодис	Ховдын толь ТББ
20	5197783	Сүхбаатар аймаг	МТ майнинг ХХК	Хувийн	Алт, зэс	Их Бага Баян Шарга ТББ
21	5106656	Сүхбаатар аймаг	Нагааранз ХХК	Хувийн	Нүүрс	Их Бага Баян Шарга ТББ
22	5966302	Сүхбаатар аймаг	Нүүрс хими технологи ХХК	Хувийн	Нүүрс	Их Бага Баян Шарга ТББ
23	2337231	Сүхбаатар аймаг	Олгойбулаг ХХК	Хувийн	Нүүрс	Их Бага Баян Шарга ТББ
24	2801019	Сүхбаатар аймаг	Полиметалл ресурс ХХК	Хувийн	Цайр, төмрийн хүдэр	Их Бага Баян Шарга ТББ
25	5615631	Сүхбаатар аймаг	Премиумкөөл корпораци ХХК	Хувийн	Нүүрс	Их Бага Баян Шарга ТББ
26	5180945	Сүхбаатар аймаг	Сидакуангей ГХО ХХК	Хувийн	Нүүрс	Их Бага Баян Шарга ТББ
27	5084903	Сүхбаатар аймаг	Соронзонтолгой ХХК	Хувийн	Төмөр	Их Бага Баян Шарга ТББ
28	5524997	Сүхбаатар аймаг	Сунхунголд ГХО ХХК	Хувийн	Жонш	Их Бага Баян Шарга ТББ
29	5774047	Ховд аймаг	Талстмолор ХХК	Хувийн	Вольфром/ гянтболд	Ховдын толь ТББ
30	2016931	Сүхбаатар аймаг	Талын гал ХК	Хувийн	Нүүрс	Их Бага Баян Шарга ТББ
31	5301769	Сүхбаатар аймаг	Талын элч ГХО ХХК	Хувийн	Нүүрс	Их Бага Баян Шарга ТББ
32	5112389	Сүхбаатар аймаг	Титан-Орд ХХК	Хувийн	Жонш, гянтболд	Их Бага Баян Шарга ТББ
33	4183525	Сүхбаатар аймаг	Тэрмэнжонш ХХК	Хувийн	Жонш	Их Бага Баян Шарга ТББ


№	Регистр	Аймгийн нэр	Компанийн нэр	Өмчийн хэлбэр	Ашигт малтмалын төрөл	Санал болгосон ТББ
34	5351324	Сүхбаатар аймаг	Урагшлахговь ГХО ХХК	Хувийн	Нүүрс	Их Бага Баян Шарга ТББ
35	2868687	Сүхбаатар аймаг	Уулсноён ХХК	Хувийн	Алт	Их Бага Баян Шарга ТББ
36	5100038	Сүхбаатар аймаг	Хаантоонот ХХК	Хувийн	Холимог металл	Их Бага Баян Шарга ТББ
37	2166631	Сүхбаатар аймаг	Хунт-Өгөөж ХХК	Хувийн	Хайлуур жонш	Их Бага Баян Шарга ТББ
38	2831686	Сүхбаатар аймаг	Цэгээн-Үүдэн ХХК	Хувийн	Нүүрс	Их Бага Баян Шарга ТББ
39	2830213	Дорнод аймаг	Шинь Шинь ГХО ХХК	Хувийн	Нүүрс	Их Бага Баян Шарга ТББ
40	5665914	Сүхбаатар аймаг	Шинэ уужим орд ХХК	Хувийн	Холимог металл	Их Бага Баян Шарга ТББ
41	2568683	Сүхбаатар аймаг	ЭБНЭ ХХК	Хувийн	Жонш	Их Бага Баян Шарга ТББ
42	5452503	Сүхбаатар аймаг	Эм Эл цахиурт овоо ГХО ХХК	Хувийн	Төмрийн хүдэр	Их Бага Баян Шарга ТББ
43	5211859	Сүхбаатар аймаг	Эрдэнийн босго ХХК	Хувийн	Нүүрс	Их Бага Баян Шарга ТББ
44	5072948	Сүхбаатар аймаг	Эрдэнийн олз ГХО ХХК	Хувийн	Нүүрс	Их Бага Баян Шарга ТББ
45	5190479	Сүхбаатар аймаг	Эрдэнийн тал майнинг ХХК	Хувийн	Төмөр, молибден	Их Бага Баян Шарга ТББ

2.2 МЭДЭЭЛЛИЙН ЦУГЛУУЛАЛТЫН АРГАЧЛАЛ

Хараат бус хянагч-нэгтгэгч нь Монголын ОУИТБС-ын цахим тайлагналын системийг ашиглан **төлбөр, орлогын мэдээлэл** болон **орлогын бус мэдээллийг** нэгтгэн цуглуулж, **анхны зөрүүг тодорхойлсон**. Үүний дараа сонгогдсон компаниудаас зөрүү үүссэн шалтгааныг тайлбарлах нэмэлт мэдээлэл, нөхөн сэргээлтийн талаарх мэдээлэл, мөн **2024 оны санхүүгийн аудитлагдсан тайлангийн материалыг авч, баталгаажуулсан**.

Ийнхүү цахим тайлангийн системийн хүрээнд оролцогч талуудын мэдээлэл цуглуулалт, оролцооны байдлыг бүрэн хянаж, нэгтгэсэн нь тайлангийн суурь мэдээлэл болж байна.

Зураг 3. Цахим тайлангийн систем дэх талуудын оролцоо



2.2.1. 2024 оны нэгтгэлд ашигласан маягтууд

ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн **2019 оны 12 дугаар сард хуралдсан 18 дугаар хуралдааны** шийдвэрийн дагуу ажлын албанаас **ОУИТБС-ын компанийн тайлагналын маягтыг шинэчлэх** ажлыг хэрэгжүүлсэн. Шинэчилсэн маягтыг **ҮСХ-ны зөвшөөрлөөр, АҮЭБЯ-ны сайдын 2020 оны 3 дугаар сарын 5-ны А/37 тоот тушаалаар** баталсан байна.

Түүнчлэн уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын **2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн А/123 тоот тушаалаар** тайлангийн маягт болон түүнийг нөхөх зааврыг шинэчлэн баталсан бөгөөд үүнд дараах маягтууд багтсан:

- ✓ Ашигт малтмалын хайгуул, олборлолт, үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны жилийн тайлангийн маягт (3-ОУИТБС-1);
- ✓ Газрын тосны хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын жилийн тайлангийн маягт (3-ОУИТБС-2);
- ✓ Орон нутгийн төсөвт ашигт малтмал, газрын тосны хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжээс төвлөрүүлсэн барьцаа, албан татвар, хураамжийн орлогын жилийн тайлангийн маягт (3-ОУИТБС-3);
- ✓ Ашигт малтмал, газрын тосны хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжээс төрийн захиргааны төв байгууллага болон бусад төсөвт байгууллагад төвлөрүүлсэн албан татвар, хураамж, бусад орлогын жилийн тайлангийн маягт (3-ОУИТБС-4);
- ✓ Ашигт малтмал, газрын тосны хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, борлуулалтын жилийн нэгдсэн тайлангийн маягт (3-ОУИТБС-5);
- ✓ Ашигт малтмал, газрын тосны хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжээс улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн албан татвар, хураамжийн орлогын жилийн нэгтгэлийн тайлангийн маягт (3-ОУИТБС-6).

Эдгээр маягтууд нь ОУИТБС-ын тайлангийн **тоон болон чанарын мэдээллийг цогцоор** нь цуглуулж, засгийн газрын болон орон нутгийн төсөвт төвлөрсөн орлогын ил тод байдлыг хангах үндсэн хэрэгсэл болж байна.

2.2.2. Задаргааны түвшин

ОУИТБС-ын Стандартын **4.7 дахь заалтад** зааснаар:

- ✓ Олон талт оролцогчдын бүлэг мэдээллийг олон нийтэд зориулан хэвлэн нийтлэхэд ямар түвшинд хүртэл задлах боломжтой болохыг зөвшилцөх шаардлагатай гэж заасан байна.
- ✓ Мөн ОУИТБС-ын тайлангийн мэдээлэл нь компаниуд, төрийн байгууллагууд болон орлогын урсгал бүрээр нь дэлгэн харуулах боломжтой байх ёстой гэж тодорхойлсон.

Энэ нь тайлангийн ил тод байдал, хяналт шалгалт, олон нийтэд ойлгомжтой байдлыг хангах үндсэн зарчим болж байгаа юм.

2.3 БАТАЛГААЖУУЛАЛТ

2.3.1. Монгол Улсын аудит, баталгаажуулалтын орчин нөхцөл

Монгол Улсын төрийн аудитын дээд байгууллага нь **Үндэсний Аудитын газар (ҮАГ)** юм. ҮАГ нь олон улсын аудитын **INTOSAI** байгууллагын гишүүн бөгөөд түүний стандартын дагуу аудитын үйл ажиллагаа явуулдаг. Түүнчлэн олон улсын аудитын **INTOSAI** байгууллагын гишүүн бөгөөд түүний стандартын дагуу аудитын үйл ажиллагаа явуулдаг байна. ҮАГ-ын гол үүрэг нь:

- ✓ Яам, агентлаг, төрийн өмчит байгууллагуудын санхүүгийн тайланг аудит хийж, Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлантай харьцуулан **УИХ-аар батлуулдаг**.
- ✓ Орон нутгийн түвшинд (аймаг, сум) байгууллагууд **жил бүр санхүүгийн тайлан гаргаж**, ҮАГ-ын харьяа орон нутгийн аудитын байгууллагаар аудит хийлгэх журамтай.


Хууль эрх зүйн орчин - Аудит баталгаажуулалтын үйл ажиллагааг Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Санхүүгийн удирдлагын тухай хууль зэрэг эрх зүйн баримт бичгүүд зохицуулдаг. Үүнээс гадна олон улсын стандарт (INTOSAI, ISA) болон ОУИТБС-ын Стандартыг баримталж, аудитын чанар, ил тод байдлыг хангадаг.

Төрийн өмчит компаниудын хувьд **жил тутмын санхүүгийн тайланд аудит хийх** ажиллагааг Үндэсний Аудитын газар хариуцдаг ба аудитыг гүйцэтгүүлэхийн тулд зохих хэмжээний **туршлага, чадвартай хөндлөнгийн аудитын байгууллагуудыг** сонгон шалгаруулах журмаар томилж ажиллуулахыг зөвшөөрдөг.

Сонгогдсон аудитын байгууллагууд нь **Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт (АДБОУС)** болон **Аудитын олон улсын стандарт (АОУС)**-ын дагуу аудитын ажлыг гүйцэтгэдэг.

- ✓ Энэхүү журам нь төрийн өмчит компаниудын санхүүгийн тайлангийн үнэн зөв, ил тод байдлыг хангах үндсэн механизм болдог.

2.3.2. ОУИТБС-ын тайлангийн баталгаажуулах явц



Өмнөх жилүүдэд тайлан гаргаж байсан компаниудын гүйцэтгэх удирдлага нь өөрсдийн тайлан, мэдээлэлд ТУЗ-ийг төлөөлөх эрх бүхий этгээдийн гарын үсэг бүхий баталгааг бичгээр гаргаж өгөх, компани бүр аудит хийлгэсэн санхүүгийн тайлангийн мэдээллийг цахим тайлангийн системээр илгээх зэргийг ОУИТБС-ын ажлын албатай тохиролцсон. Иймээс 2024 онд энэхүү зохицуулалтыг адил зарчмаар хэрэгжүүлсэн, улмаар тайлангийн мэдээллийн үнэн зөв, баталгаатай байдлыг хангах ажлыг зохион байгуулсан.

Зураг 4. ОУИТБС-ын тайлангийн баталгаажуулах явц



2.4 МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВ БАЙДАЛ

ОУИТБС-ын тайлан гаргаж буй төрийн байгууллагууд, төрийн болон хувийн компаниудын тайлангаа баталгаажуулсан байдал, олон улсын стандартын дагуу хариуцлагатай хараат бус аудитораар баталгаажуулсан эсэхэд үнэлгээ хийв.

Нэгтгэлд хамрагдсан 110 компаниас **67 нь ил тод байдлын тайланг баталгаажуулсан** бол **43 компани мэдээлэл ирүүлээгүй** байна. Нэгтгэл тайланд хамрагдаагүй үлдсэн 43 компанийн **4 нь албан ёсоор татгалзсан, 13 нь үйл ажиллагаа зогссон болон эхлээгүй, 19 нь мэдээлэл ирүүлээгүй бол үлдсэн 7 нь холбоо барих мэдээлэл олдоогүй** байна.

Өмнөх нэгтгэлүүдийн үед компаниудаас аудитлагдсан санхүүгийн тайланг шаардаж авдаг байсан боловч компаниудын аудитлагдсан санхүүгийн тайлангаас илүү ОУИТБС-д тайлагнасан мэдээллийг голлон ашиглаж байна. Учир нь санхүүгийн тайлан аккруэл суурийн дагуу бэлтгэгддэг бол ОУИТБС-ын тайлан мөнгөн сууриар бэлтгэгддэг. Доорх хүснэгтээр нэгтгэлд хамрагдсан 110 компанийн ирүүлсэн мэдээллийг харуулсан бөгөөд **аудитын тайланг 12 компани, нөхөн сэргээлтийн мэдээллийг 25 компани** ирүүлсэн байна.

Эдгээр компаниудын дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 6-с үзнэ үү.

Хүснэгт 3. Компаниудаас ирсэн мэдээлэл

Мэдээ ирүүлсэн эсэх	Нэгтгэлийн залруулгын маягт		Нөхөн сэргээлтийн мэдээлэл		Аудитын тайлан	
	2023	2024	2023	2024	2023	2024
Ирүүлсэн	92	67	34	25	21	12
Ирүүлээгүй	9	43	67	85	80	98
НИЙТ	101	110	101	110	101	110

Өмнөх нэгтгэл тайланд хамрагдалтын хувь **80.8 хувьтай байсан** бол энэ жил нэгтгэл тайланд хамрагдсан хувь **19.9 хувиар буурч 60.9 хувьд** хүрсэн байна.

- ◆ ОУИТБС-ын стандартад өгөгдөл мэдээллийн чанарын асуудлыг чухлаар авч үздэг ба цаашид **ЗГ болон компаниуд мэдээллээ системтэйгээр тайлагнах, Хараат бус хянагч-нэгтгэгчийн зүгээс хийх тохируулгын хэрэгцээг багасгах, мэдээллийн араас шалгах аас зайлсхийх олон улсын жишгийг дагаж мөрдөхийг** зорьж байгаа юм.
- ◆ Төрийн байгууллагууд, ТӨААН-үүд болон компаниуд нь цахим тайланд тайлагнасан төлбөр орлогын мэдээлэл болон нэмэлтээр ирүүлсэн мэдээллээ үнэн зөв гэдгийг баталгаажуулж байгаа боловч **тайлангууд аль аль талдаа алдаатай байгаа нь нэгтгэлээс харагдаж** байна.
- ◆ Иймд ОУИТБС-ийн тайланг буруу тайлагнасан оролцогч талуудын хариуцлагыг дээшлүүлэх, **шаардлага 4.9-д заасны дагуу төрийн болон хөндлөнгийн аудитын байгууллагаар ил тод байдлын тайланг баталгаажуулахад** анхаарч ажиллах хэрэгтэй байна.

2.4.1. Тайлан тушаалт, хариу ирүүлсэн байдал

ОУИТБС-ын 2024 онд тайлан илгээсэн **1,010 компани, 14 аймаг, 3 дүүрэг хамрагдсан.**

ОУИТБС-ын стандартын дагуу шаардлагатай мэдээллийг хүсэж нийт 9 яам, төрийн байгууллага руу албан бичиг явуулснаас ЗТЯ, БОУАӨЯ, ГБХНХЯ-наас бусад газрууд хариу ирүүлж холбогдох мэдээллийг өгсөн. Мөн баримт бичгийн судалгаанд Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хороо болон Нийгмийн даатгалын ерөнхий газар зэрэг холбогдох төрийн байгууллагуудын мэдээллийг ашиглав.

ОУИТБС-ын стандарт нь өгөгдөл, **мэдээллийн чанар, үнэн зөв байдал** болон **ил тод байдлын** түвшнийг чухлаар авч үздэг. Үүний хүрээнд Засгийн газар болон компаниуд мэдээллээ **системтэй, бүрэн, нэг мөрөөр тайлагнах**, харин хараат бус хянагч-нэгтгэгчийн зүгээс хийх **тохируулга, баталгаажуулалтын ажлын хэрэгцээг багасгах, мэдээллийн дараах шалгалтаас зайлсхийх** олон улсын сайн туршлагыг хэрэгжүүлэх зорилт тавьсан байдаг.

Компаниуд болон төрийн байгууллагуудын ОУИТБС-ын тайланг тогтмол тушааж хэвших, тайлагнасан мэдээллийн үнэн зөв байдлыг хангах талаар жил бүрийн нэгтгэлийн тайланд зөвлөмж өгч ирсэн боловч, 2024 оны тайлангийн үр дүнд **мэдэгдэхүйц ахиц гараагүй** байна. Иймд:

- ✓ Засгийн газрын орлого болон компанийн төлбөрийн зөрүүг бууруулах зорилгоор тайлангийн системд мэдээлэл оруулах **ирцийг нэмэгдүүлэх**, ялангуяа **орон нутгийн байгууллагуудын мэдээллийг бүрэн хамруулахад** анхаарах;
- ✓ ОУИТБС-ын стандартын дагуу нэмэлт мэдээлэл авах шаардлага тулгарсан бөгөөд компаниуд болон төрийн байгууллагуудтай холбогдох, мэдээлэл ирүүлэх явц **удаашралтай, хугацаа их алддаг**. Иймд холбогдох байгууллагуудад **нөлөөллийн арга хэмжээ авах**;
- ✓ Цахим тайлангийн системд байршуулж буй мэдээллийн бүрдлийг **алдаагүй, иж бүрэн** байх хүрээнд цахим тайлангийн системд программын тохиргоо хийх.

Засгийн газар болон компаниудын зүгээс алдаатай, дутуу тайлагнах тохиолдол жил бүр давтагдаж байгаа нь ОУИТБС-ын тайлангийн зөвлөмжийн хэрэгжилтэд **хангалттай анхаарал хандуулахгүй байгааг** харуулж байна. Доорх хүснэгтэд ОУИТБС-ын нэгтгэлд хамрагдсан 110 байгууллагын тайлагналын ирцийг харуулав. Мэдээллээс харахад дийлэнх маягтуудын бөглөсөн байдал 50 хувьд хүрэхгүй байв.

8	<p><u>Засгийн газарт чиглэл өгөх тухай, /</u></p> <p>1) Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн олгох, бүртгэх, шилжүүлэх, хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө, тэдгээрийн гүйцэтгэл, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэр, техник, эдийн засгийн үндэслэл зэрэг мэдээллийг агуулсан ашигт малтмалын улсын бүртгэлийн байгууллага, татварын байгууллагатай харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг боловсронгуй болгох;</p> <p>2) Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулж олон улсын жишигт нийцүүлэх, үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх, ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;</p> <ul style="list-style-type: none"> ✓ 1/ Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал, менежментийг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсад нэр хүнд бүхий хуулийн этгээдтэй хамтран тэдгээрийн засаглалын шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, үр дүнг тайлагнах; ✓ 2/ Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэлийг харгалзан бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, үр ашгийг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах асуудлыг судалж, дүн шинжилгээний хийсний үндсэн дээр хуулийн этгээдийг нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах; ✓ 3/ Төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл, төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг биржээр олон нийтэд нээлттэй худалдах асуудлын талаар холбогдох санал боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; ✓ 4/ Нийтийн мэдээллийг ил тод байдлын тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн мэдээллийг нийтэд мэдээлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох; ✓ 5/ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх; <p>3) Төсвийн ил тод, үр ашигтай байдал, санхүүгийн хяналт, хариуцлагыг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч, холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийг 2025 оны хоёрдугаар улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх: /дугаар 52, 2024 оны 12 дугаар сарын 12-нд батлагдсан.</p>
9	<p>Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай, дугаар 58, 2024 оны 12 дугаар сарын 27-нд батлагдсан.</p>

Эх сурвалж: <https://www.parliament.mn/>, <https://legalinfo.mn/>

С. Засгийн Газрын тогтоолын хүрээнд хийгдсэн гол өөрчлөлтүүдээс дурдвал:

Хүснэгт 24. 2024 онд олборлох салбарт орсон Засгийн Газрын тогтоолын өөрчлөлтийн тойм

№	ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ
1	"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай, дугаар 45, 2024 оны 01 дүгээр сарын 31-нд батлагдсан.
2	Аж Үйлдвэр, эрдэс баялгийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай, дугаар 30, 2024 оны 08 дугаар сарын 07-нд батлагдсан.
3	Газрын улсын тусгай хэрэгцээнд авах тухай /1. Булган аймгийн Орхон сум, Орхон аймгийн Жаргалант сумдын нутаг дэвсгэрт стратегийн ач холбогдол бүхий Эрдэнэтийн овоо зэс, молибдений ордыг ашиглаж байгаа "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын баяжуулах үйлдвэрийн хаягдлын шинэ санг байгуулах зориулалтаар нийт 7046.15 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, газрын хилийн заагийн эргэлтийн цэгийн солбицлыг хавсралт ёсоор баталсугай. /, дугаар 116, 2024 оны 3 дугаар сарын 20-нд батлагдсан.
4	Жагсаалт шинэчлэн батлах тухай / Нээлтийн өгөгдлийн жагсаалт / дугаар 96, 2024 оны 9-р сарын 25-нд батлагдсан.
5	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай, 218, 2024 оны 12 дугаар сарын 18-нд батлагдсан.
6	Тогтоолд нэмэлт оруулах тухай /Засгийн газрын 2023 оны 223 дугаар тогтоолоор баталсан "Биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангилал" -д доор дурдсан агуулгатай 4, 5 дахь заалт нэмэх. /дугаар 7.3, 2024 оны 02 дугаар сарын 28-нд батлагдсан.
7	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай / "Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай "Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 362 дугаар тогтоолын 5 дахь заалтын ", байнгын ачаа тээврийн хил нэвтрэх С төрлийн зорчих зөвшөөрлийг олгох эрхийг олборлолтын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдэд шилжүүлэх" гэснийг хасах/ дугаар 170, 2024 оны 11 дүгээр сарын 13-нд батлагдсан.
8	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай / "Газрын тосны зарим бүтээгдэхүүний гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 35 дугаар тогтоолын 1 дэх заалтын "2025 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийг хүртэл" гэснийг "2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн хүртэл" гэж өөрчилсүгэй./ дугаар 242, 2024 оны 12-р сарын 25-нд батлагдсан.
9	Тогтоолын хавсралтад өөрчлөлт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай / "1.Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай" Засгийн газрын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 131 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Хужирт-Бат-Өлзийт чиглэлийн 49 км авто зам, барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол"-ын 11 дэх заалтын дараа энэ тогтоолын хавсралтад заасны агуулга бүхий 12 дахь заалт нэмсүгэй. /дугаар 66, 2024 оны 09 дүгээр сарын 04-нд батлагдсан.
10	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай/ 1. "Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах , эрх олгох тухай" Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 139 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай замын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол"-д хавсралт ёсоор баталсан 6-32 дахь заалт нэмсүгэй./ дугаар 208, 2024 оны 05-р сарын 15-нд батлагдсан.
11	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай /1. Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 502 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүний жагсаалт" -ын 4-т заасныг доор дурдсанаар өөрчилсүгэй. / дугаар 168, 2024 оны 11-р сарын 13-нд батлагдсан.

№	ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ
12	Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудасны талаар авах арга хэмжээний тухай / 1.Төрийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас (gov.mn)-ыг ашиглалтад оруулж, төрийн байгууллагад цахим хуудас ашиглах эрх үүсгэх, мэдээлэл байршуулах ажлыг үе шаттай зохион байгуулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, цахим хуудсыг ашиглах заавар, аргачлалыг баталж, мөрдүүлэхийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүүд даалгасугай. /дугаар 208, 2024 оны 12-р сарын 4-нд батлагдсан.
13	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбилцдыг батлах, эрх олгох тухай / 1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Дундговь, Өвөрхангай, Төв, Хэнтий аймгийн нутагт хамаарах улсын чанартай хатуу хучилттай авто замын их засварын ажилд шаардагдах түгээмэл тархацтай хатуу хучилттай авто замын их засварын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг хавсралт ёсоор баталсугай. /дугаар 225, 2024 оны 05-р сарын 22-нд батлагдсан.
14	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбилцдыг батлах, эрх олгох тухай / 1.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн XV.1.1.53-т тусгагдсан Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумаас Жаргалтхаан сум чиглэлийн 59.2 км хатуу хучилттай авто замын барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбилцлыг хавсралт ёсоор баталсугай. / дугаар 102, 2024 оны 9-р сарын 25-нд батлагдсан.
15	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбилцдыг батлах, эрх олгох тухай / 1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн XV.1.1.95-д тусгагдсан Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн хэвтээ тэнхлэгийн авто замын Арвайхээр-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шатны Өвөрхангай аймгийн нутагт хийгдэх 2.61 км хоёр түвшний уулзварын барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайж, ашиглах талбайн солбицлыг хавсралт ёсоор баталсугай. / дугаар 101, 2024 оны 9-р сарын 25-нд батлагдсан.
16	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбилцдыг батлах, эрх олгох тухай /1.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн XV.1.1.49-д тусгагдсан Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг хавсралт ёсоор баталсугай. / дугаар 100, 2024 оны 9-р сарын 25-нд батлагдсан.
17	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбилцдыг батлах, эрх олгох тухай /1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа Баян-Өлгий аймгийн Бугат сумын 5.8 км хатуу хучилттай авто зам, Алтанцөгц сумын Хар үзүүр, Ховд голын 217 метр урт төмөр бетон гүүр, Дэлүүн сумын 2.5 км хатуу хучилттай авто замын барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг хавсралт ёсоор баталсугай. /дугаар 236, 2024 оны 5-р сарын 29-нд батлагдсан.
18	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбилцдыг батлах, эрх олгох тухай / 1.Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулийн XV.1.1.44-т тусгагдсан Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн 61.9 км хатуу хучилттай авто замын барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг хавсралт ёсоор баталсугай. / дугаар 65, 2024 оны 9-р сарын 4-нд батлагдсан.
19	Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбилцдыг батлах, эрх олгох тухай / 1.Улсын төсвийн хөрөнгөөр баригдах Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай авто замын барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг хавсралт ёсоор баталсугай. / дугаар 139, 2024 оны 4-р сарын 3-нд батлагдсан.
20	Үндэсний баялгийн сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай / 1.Үндэсний баялгийн сангийн 2024 оны төвлөрүүлсэн орлогоос зохих журмын дагуу Хуримтлалын сан, Хөгжлийн сан, Ирээдүйн өв санд хуваарилж, 2025 оны зорилтот түвшнийг хангуулж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан нарт даалгасугай. /дугаар 223, 2024 оны 12-р сарын 20-нд батлагдсан.

Эдгээр өөрчлөлтүүд нь олборлох салбарын ил тод байдал, төрийн эзэмшлийн хувь, ашиг тусын хуваарилалтыг сайжруулах, баялгийг ард түмэнд хүртээмжтэй болгох чиглэлтэй билээ.

Эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлогууд, бодлогын шинэчлэлд УИХ-ын 52-р тогтоолоор 2020 онд батлагдсан "Алсын Хараа-2050" Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогоор тодорхойлогдсон хэвээр байна. Түүнчлэн 2024 онд энэхүү бодлогын түвшинд шинэчлэл, өөрчлөлт хийгдээгүй болно.

Уул уурхай, газрын тос, түлш, цөмийн энергийн салбарын **эрх зүйн тогтолцоо болон түүний хэрэгжилтийн практикт** тодорхой зөрүү, давхардал, уялдаатай байдлын талаар дараах дүгнэлт саналыг хүргүүлээд байна.

2006 оноос мөрдөгдөж байгаа "Ашигт малтмалын тухай" хууль нь ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох харилцаанд төвлөрсөн, явцуу хүрээтэй зохицуулалттай хэмээн судлаачид шүүмжилж байна. Хууль батлагдсанаас хойш нийт **300 орчим нэмэлт, өөрчлөлт** орсноор анхны үзэл баримтлал, зорилго нь тодорхойгүй болж, **хууль хэрэгжүүлэх явцад зөрчил, давхардал, эрх мэдлийн давхцал үүсэхэд нөлөөлсөн** байна.

Иймд хуулийн уялдаа, зохицуулалтын хүрээг өргөжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын 95 дугаар захирамжаар "Ашигт малтмалын тухай" хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд одоогоор шинэчилсэн найруулгын төсөл боловсруулагдаж байна.

2024 онд батлагдсан хууль, тогтоолын жагсаалтыг дээр оруулсан бөгөөд 2024 онд ямар нэг царцаалтын асуудал байхгүй болно.

4.1.2 Төсвийн бодлого, төсвийн хууль тогтоомж

Төсөв нь Монгол Улсын **эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх үндсэн санхүүгийн хэрэгсэл** бөгөөд тухайн жилийн хугацаанд **төрийн санд төвлөрөх нийт орлого болон түүнийг зарцуулах арга хэмжээг багтаасан орлого, зарлагын тэнцэл** юм.



Төсвийн орлого нь **татварын орлого, татварын бус орлого, гадаадын тусламжаас** бүрдэнэ. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлогоос **Төсвийн тогтворжуулалтын сан** болон **Ирээдүйн өв санд** хуваарилагдах хэсгийг хасаж тооцсоны дараах үлдэгдлийг **нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого** гэж нэрлэдэг.

- ❖ **Татварын орлого** нь Татварын ерөнхий хууль-ийн дагуу тогтоосон төрөл бүрийн татвар, хураамж, төлбөрөөс бүрдэнэ.
- ❖ **Татварын бус орлого** дараах эх үүсвэрүүдийг хамарна. Үүнд:
 - Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох **хувьцааны ногдол ашиг**;
 - Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг **ашигласны төлбөр**;
 - Төрийн болон орон нутгийн өмчийг **хувьчилсан, худалдсан, түрээсэлсний орлого**;
 - **Торгуулийн төлбөр**;
 - **Төсвийн байгууллагын үйл ажиллагаанаас олсон орлого**;
 - **Засгийн газарт олгогдсон зээл, тусламж**;

- Хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлсэн **бусад орлого болно.**

Ийнхүү төсвийн орлого нь төрийн үйл ажиллагааг санхүүжүүлэх үндсэн эх үүсвэр бөгөөд эдийн засгийн бодлого, хөгжлийн зорилтын хэрэгжилтийг дэмжих чухал хэрэгсэл болдог.



Төсвийн зарлага нь **урсгал зардал** болон **хөрөнгийн зардал** гэсэн үндсэн хэсгүүдээс бүрддэг ба төрийн **үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэдэг** байна. Эдгээрт иргэдэд боловсрол олгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, улс орны аюулгүй байдлыг хангах, дэд бүтцийг хөгжүүлэх, нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх зэрэг үйл ажиллагаа багтдаг.



Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу төр, иргэн, байгууллагаас төлсөн **эрүүл мэндийн даатгалын шимтгэлээр** эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг санхүүжүүлдэг.

Төсөвтэй холбогдох хуулиудын зорилт болон 2024 онд тэдгээрт орсон өөрчлөлтийн тоог дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 25. Төсвийн хууль тогтоомж

ТӨСВИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ

ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

Төсвийн бодлого, 2024 оны төсвийн бодлоготой холбоотой хууль тогтоомжийн өөрчлөлтийн тухай

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль болон тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн дагалдах хуулиудад олборлох салбарын хүрээнд дараах бодлогын арга хэмжээг баталж, хэрэгжүүлж байна.

- ✓ Ашигт малтмал баяжуулах, боловсруулах, нэмүү өртөг шингэсэн ашигт малтмалын баяжмал, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжийн нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг 4 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх зохицуулалтыг оруулсан. Тус зохицуулалт нь Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дугаар зүйлийн 40.6 дахь заалтад туссан бөгөөд 2027 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хүртэл хэрэгжихээр байна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16.2-д заасан төсвийн тогтворжуулалтын сангийн эх үүсвэрүүдийг татан төвлөрүүлсэн байдал

Төсвийн тогтворжуулалтын санд **2024 онд 443.9 тэрбум төгрөгийн орлого** төвлөрсөн байна.

Төсвийн орлогын хуваарилалтын зарчим, орон нутгийн хуваарилалтын орлого хуваах тогтолцоо томьёо

Орон нутгийн төсвийн орлогыг тухайн аймгийн онцлогийг харгалзан, орон нутгаас ирүүлсэн санал болон ИТХ-аар тогтоосон хувь хэмжээг тус тус харгалзан тооцдог тул нэгдсэн томьёогоор тооцох боломжгүй юм.

ТӨСВИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ

ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЭЛ

Орлого, төсвийн тооцооллын тодотгол

2024 оны батлагдсан төсөвт олон улсын зах зээл дээрх цэвэр зэсийн үнийг **тонн тутамд 9,500.0 ам.доллар, нүүрсний үнийг дунджаар тонн тутамд 115.0 ам.доллараар тооцсон. Зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 182.5 ам.доллар** байхаар тооцсон болно.

2024 онд авралын санхүүжилт, идэвхжүүлэх багц, олборлох салбарт, эсхүл төрийн өмчит компанид үзүүлсэн татаасны мэдээлэл

Олборлох салбарт болон тухайн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчит компанид ямар нэг хэлбэрээр татаас олгоогүй болно.

2024 оны олборлох салбарын зээллэгийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл

Салбарын зээллэгийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг Монгол Банкны www.stat.mongolbank.mn цахим хаягаар хандан авах боломжтой байна.

2024 онд Ирээдүйн өв сангийн хөрөнгийг онцгой нөхцөлд ашигласан эсэх талаарх мэдээлэл

Ирээдүйн өв сангаас 2024 онд ямар нэг зарцуулалт хийгдээгүй болно.

Эх сурвалж: *Монгол Улсын Сангийн Яам*

Түүнчлэн зарим **төсвийн тухай хуулийн** мэдээллүүдийг **2023 оны буюу 18 дугаар нэгтгэл тайлангаас** дараах агуулгаар тоймлон авч үзэх боломжтой. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль;
- Ирээдүйн өв сангийн тухай хууль;
- Үндэсний баялгийн сангийн тухай хууль болно.

4.2 ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛӨЛ (Шаардлага 3.1 болон шаардлага 6.3)


Монгол Улсын Их Хурал 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр **“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай”** хуулийг баталсан ба хуулийн дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, түүнд хүрэх үр дүнг илэрхийлэх чанарын болон тоон үзүүлэлтүүдийг биелэлт нь дараах байдалтай байна.

Түүнчлэн олборлох үйлдвэрлэл нь Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбар бөгөөд эдийн засгийн өсөлтийн голлох үзүүлэлт болсоор ирсэн. 2024 оны байдлаар эрдэс баялгийн салбар нь **Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 32.1 хувийг, ДНБ-ний 27.3 хувийг** тус тус бүрдүүлж байгаа бөгөөд уул уурхайн салбарын ДНБ хэмжээ нь сүүлийн жилүүдэд тогтмол өсөлттэй байна.

Энд, эрдэс баялгийн салбарын дэлгэрэнгүйг Аж Үйлдвэр, Эрдэс Баялгийн Яам (mmhi.gov.mn) болон ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг, Ашигт Малтмал, Газрын Тосны Газар (mrpam.gov.mn)-аас тус тус эрхлэн гаргадаг сар бүрийн статистик мэдээнүүдээс авах боломжтой байна.

ДНБ-ий оны үнээрх өсөлтийг уул уурхайн салбараар авч үзвэл 2024 онд өмнөх оноос 1,988.0 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

График 2. ДНБ, Уул уурхайн салбарын дүн, эзлэх хувь, (оны үнээр), 2020-2024 он, тэрбум төгрөг




Эх сурвалж: <https://www.1212.mn/>

4.2.1 Төвлөрүүлсэн орлого (Шаардлага 4.1)

Эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрүүлсэн орлого **10,383.6** тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс **2,703.9 тэрбум төгрөг буюу 35.2 хувиар өссөн** байна.

График 3. Эрдэс баялгийн салбарын төвлөрүүлсэн орлого, 2020-2024 он, тэрбум төгрөг



Эх сурвалж: <https://mmhi.gov.mn/>

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2024 оны гүйцэтгэлээр **31,375.1** тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс **7,065.0 тэрбум төгрөг буюу 29.1 хувиар өссөн** байна. Төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээ, эзлэх хувийг салбараар харуулав.

График 4. Эрдэс баялгийн салбарын төвлөрүүлсэн орлого, салбараар, 2023-2024 он, тэрбум төгрөг



Эх сурвалж: <https://mmhi.gov.mn/>

Уул уурхай, олборлох салбараас улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 2,784.1 тэрбум төгрөг буюу 38.3% хувиар өссөн байна. Ашигт малтмалын хувьд цайр улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй бол бусад нь өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 26. Төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээ, салбараар, 2023-2024 он, тэрбум төгрөг

Үзүүлэлт	Гүйцэтгэл			
	2023	2024	+/-	Хувь
Нийт орлогын дүн	7,679.8	10,383.6	2,703.8	35.2%
Уул уурхай, олборлох салбар				
Алт	311.5	375.4	63.9	20.5%
Зэс	2,232.1	2,311.4	79.4	3.6%
Нүүрс	4,314.6	6,749.4	2,434.8	56.4%
Төмөр	97.0	158.9	62.0	63.9%
Цайр	134.3	95.5	-37.7	-28.1%
Хайлуур жонш	23.8	53.1	29.3	123.1%
Бусад	163.8	316.4	152.6	93.1%
Газрын тосны салбар				
Газрын тос	304.2	237.8	-66.3	-21.8%
Тусгай зөвшөөрөл болон бусад орлого				
Тусгай зөвшөөрлийн төлбөр	36.6	41.9	5.2	14.3%
УТХ-өөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	3.2	3.9	0.8	23.7%
Төсөвт байгууллагын өөрийн орлого /СШ/	53.7	35.3	-18.4	-34.3%
Бусад орлого	5.1	3.5	-1.5	-30.3%


Эх сурвалж: <https://mmhi.gov.mn/>

4.2.2 Экспортын орлого (Шаардлага 3.3)

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 27,395.9 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 2,958.7 сая ам.доллар буюу 12.1 хувиар өссөн төдийгүй экспорт импортоос давамгайлж 4,170.9 сая ам.доллаароор өссөн үзүүлэлттэй гарсан байна.

Голлох бүтээгдэхүүнүүдийн хувьд төсвийн тодотголд тусгагдсанаар Монгол Улс гадаад зах зээлд 78,100 мянган тонн нүүрс, 1,560 мянган тонн зэсийн баяжмал, 18 тонн алт экспортлох зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлснээс дараах байдлаар биелэгджээ.

График 5. Эрдэс бүтээгдэхүүний экспортын биелэлт, голлох бүтээгдэхүүнээр, 2024 он



Эх сурвалж: <https://mmhi.gov.mn/>

Эрдэс бүтээгдэхүүний экспорт **14,789.0 сая ам.долларт хүрч** өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 799.0 сая ам.доллар буюу 5.7 хувиар өссөн байна. Чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, цайрын баяжмал, хайлуур жонш, молибдены баяжмал, боловсруулаагүй нефть, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт, мөнгө, тунгаасан зэс ба хайлш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь нийт экспортын 93.7 хувийг эзэлж байна.

Хүснэгт 27. Эрдэс бүтээгдэхүүний экспортын дундаж үнэ

Барааны төрөл	Хэмжих нэгж	12 дугаар сар (өссөн дүнгээр)		Өөрчлөлт	
		2023	2024	Зөрүү	Хувь
Чулуун нүүрс	тн/ам.дол	131.4	107.3	-24.1	-18.3%
Зэсийн баяжмал	тн/ам.дол	1,721.7	1,957.7	236.0	13.7%
Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	77.8	79.6	1.7	2.2%
Цайрын хүдэр, баяжмал	тн/ам.дол	1,462.2	1,452.3	-9.8	-0.7%
Жоншны хүдэр, баяжмал	тн/ам.дол	250.4	232.6	-17.7	-7.1%
Молибдены баяжмал	тн/ам.дол	18,939.0	15,993.6	-2945.40	-15.6%
Алт	тн/ам.дол	62,897.7	77,233.0	14,335.3	22.8%

Эх сурвалж: <https://mmhi.gov.mn/>

2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр уул уурхайн олборлох салбарын хувьд:

- ◆ **НҮҮРС:** Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 200.5 сая ам.доллар буюу 2.3 хувиар буурч, биет хэмжээгээр 14,142.5 мян.тн буюу 20.3 хувиар өссөн байна. Түүнчлэн нүүрсийг 100.0 хувь БНХАУ руу экспортолсон байна.
- ◆ **ЗЭСИЙН БАЯЖМАЛ:** Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 693.4 сая ам.доллар буюу 26.4 хувиар, биет хэмжээгээр 170.4 мян.тн буюу 11.2 хувиар тус тус өссөн байна. Зэсийн баяжмалыг мөн 100.0 хувь БНХАУ руу экспортолсон байна.
- ◆ **АЛТ:** Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 161.4 сая ам.доллар буюу 21.9 хувиар өсөж, биет хэмжээгээр 88.5 кг буюу 0.8 хувиар буурсан байна. Алтны 82.4 хувийг Швейцар, 17.3 хувийг АНУ руу тус тус экспортолсон байна.

График 6. Эрдэс баялгийн салбарын экспортын үнэлгээ (сая ам.доллар), хэмжээ, 2024 он

Чулуун нүүрс	83,755.0 мян.тн	8,698.0
Зэсийн баяжмал	1,695.4 мян.тн	3,319.1
Төмрийн хүдэр, баяжмал	597.6	7,510.5 мян.тн
Хайлуур жоншны хүдэр, баяжмал	318.5	1,369.1 мян.тн
Цайрын баяжмал	183.3	126.2 мян.тн
Молибдены баяжмал	96.1	6,007.1 тн
Алт	899.4	11,645.1 кг

Эх сурвалж: <https://mmhi.gov.mn/>

Дараах хүснэгтээр 2024 оны нэгтгэл тайланд хамрагдсан аж ахуй нэгж, компаниудын борлуулалтын хэмжээг харууллаа.

Хүснэгт 28. Нэгтгэл тайланд хамрагдаж буй аж ахуйн нэгжүүдийн 2024 оны борлуулалтын хэмжээ

№	Компани	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	Биет хэмжээ	Борлуулалтын үнийн дүн (мян.төгрөг)
1	Ай Би Би Ай ХХК	Алт	гр	200,551.0	48,825,400.0
		Мөнгө	гр	15,533.6	46,124.0
2	Багануур ХК	Хүрэн нүүрс	м.тн	4.9	237,581.0
3	Биг могул коул энд энерги ХХК	Эрчим хүчний нүүрс	м.тн	483.8	31,700,600.0
4	БМНС ХХК	Алт	гр	76,840.4	20,809,200,000.0
		Мөнгө	гр	19,054.2	58,237,100.0
5	Бороогоулд ГХО ХХК	Алт	гр	2,203,430.0	563,809,000.0
		Мөнгө	гр	474,375.0	1,342,210.0
6	Инфинитиспэйс ГХО ХХК	Төмрийн хүдэр	тн	721,151.0	131,498,000.0
7	Их түмэн хүрд ХХК	Урт дөлт нүүрс	тн	1,241,120.0	166,523,000.0
8	Их говь энерги ХХК	Хагас антрацит нүүрс	тн	199,379.0	37,445.4
9	Коулдголд монгол ХХК	Алт	гр	28,140.7	7,727,330.0
		Мөнгө	гр	2,886.7	8,768.8
10	МАК Цемент ХХК	Гөлтгөнө	тн		
		Шавар	тн		
		Шохойн чулуу	тн		
11	Монполимет ХХК	Алт	гр	-	10,638,000.0
12	Монцемент билдинг материалс ХХК	Занар	тн		
		Шохойн чулуу	тн		
		Чулуунцар	тн		
13	Наран мандал энтерпрайзес ГХО ХХК	Алт	гр	277.7	71,012,400.0
		Хүдэр	тн		
14	Олон ихт баян ХХК	Хүдэр	тн	100.0	23,400,600.0

№	Компани	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	Биет хэмжээ	Борлуулалтын үнийн дүн (мян.төгрөг)
15	Оюутолгой ГХО ХХК	Зэсийн баяжмал	тн	962,703.0	7,403,880,000.0
16	Өсөхзоос ХХК	Боловсруулаагүй нүүрс	тн	2,927,890.0	749,816,000.0
17	Платинумланд ХХК	Алт	гр	192,250.0	4,419,020,000.0
18	Саусгоби сэндс ГХО ХХК	1/3 коксжих нүүрс	тн	1,789,870.0	515,652,000.0
		Коксжих чанаргүй нүүрс	тн	5,241,220.0	834,391,000.0
		Баяжуулсан нүүрс	тн	560,317.0	127,893,000.0
19	Си Өү Эй Эл ХХК	Нүүрс	тн	529,994.0	249,229,000.0
20	Си Эм Кэй Ай ГХО ХХК	Хайлуур жоншны баяжмал	тн	33,980.7	27,123,080.0
21	Тавантолгой ХК	Нүүрс (чулуун)	мян.тн	2,714.4	-
22	Талстдөл ХХК	Хайлуур жонш	тн	107,072.5	1,801,022,500.0
		Баяжмал хайлуур жонш	тн	25,141.2	22,311,700,000.0
23	Тефисмайнинг ХХК	Нүүрс	тн	820,479.2	265,968,266,400.0
24	Топ ган дриллинг ХХК	Алт	кг	234.4	63,116,200.0
25	Түмэн айл инвест ХХК	Урт дөлт нүүрс	тн	2,973,400.0	442,308,000.0
		Битумт, үл барьцалдах нүүрс	тн	7,923.8	1,254,140.0
26	Тэн Хун ГХО ХХК Уулс мандал ХХК	Алт	кг	365.5	95,436,800.0
		Мөнгө	кг	238.6	755,440.0
27	Хан алтай ресурс ХХК	Нүүрс	мян.тн	354.5	54,016,540.0
28	Тэн Хун ГХО ХХК	Хүдэр	мян.тн	-	-
		Алт	тн	1.7	455,814,000.0
29	Хангад-Эксплорэйшн ГХО ХХК	Түүхий нүүрс	тн	33,094.1	3,640,404.0
		Баяжуулсан коксжихгүй нүүрс	тн	2,085.3	229,378.0
		Баяжуулсан сул коксжих нүүрс	тн	463,077.0	200,905,580.0
		Баяжуулсан нүүрс	тн	-	-
		Баяжуулсан коксжих нүүрс	тн	518,410.4	314,016,200.0
30	Хур эрдэнэ баялаг ГХО ХХК	Дэгдэмхий бодис дунд коксжих, боловсруулаагүй нүүрс	тн	464,850.0	191,309,000,000.0
31	Цагаан-Өвөлжөө ХХК	Нүүрс	тн	1,141,510.0	35,548,000,000.0
32	Цайртминерал ГХО ХХК	Цайрын хүдэр	мян.тн	-	-
		Цайрын баяжмал	мян.тн	69.2	-
33	Шанжин-Орд ГХО ХХК	Хүдэр	тн	-	-
		Чулуулаг хөрс	м3	-	-
		Баяжмал	тн	362,273.0	26,618,300,000.0
34	Шарын гол ХК	Мөнгө	кг	1.5	4,253.8
		Нүүрс	тн	172,037.0	95,199,500.0
35	Эн И Си ХХК	Алт	кг	17.1	4,694,560.0
		Нүүрс	тн	-	-

№	Компани	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	Биет хэмжээ	Борлуулалтын үнийн дүн (мян.төгрөг)
36	Энержиресурс ХХК	Түүхий нүүрс	мян.тн	-	-
		Баяжуулсан коксжих нүүрс	мян.тн	4,225.8	2,402,590,000.0
		Баяжуулсан дунд зэрэг үнстэй хагас хатуу коксжих нүүрс	мян.тн	2,704.9	538,939,000.0
		Баяжуулсан эрчим хүчний нүүрс	мян.тн	1,199.6	136,555,000.0
37	Эрдэнэс Таван толгой ХК	Коксжих нүүрс	тн	27,472,500.0	9,838,580,000.0
		Исэлдсэн нүүрс	тн	2,154,120.0	404,988,000.0
		Баяжуулсан коксжих нүүрс	тн	12,800.0	7,150,720.0
		Баяжуулсан исэлдсэн нүүрс	тн	-	-
38	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	Зэсийн баяжмал	тн	566,939.0	3,534,720,000.0
		Молибдений баяжмал	тн	5,603.3	313,448,000.0
39	Дорнын чулуулаг ХХК	Боловсруулаагүй нүүрс	тн	175,434.0	4,817,360.0
40	Каскейдмайнинг ГХО ХХК	Төмрийн хүдэр	мян.тн	-	-
		Төмрийн бүхэллэг баяжмал	мян.тн	2.2	465,300.0
41	Олгойбулаг ХХК	Нүүрс	тн	16,893.6	1,080,670.0
42	Талстмолор ХХК	Гянтболд	тн	201.0	9,133,270.0

4.2.3 Үйлдвэрлэл (Шаардлага 3.2)

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс 16,416.6 мян.тн буюу 20.2 хувь, зэсийн баяжмал 166.9 мян.тн буюу 12.0 хувь, төмрийн хүдэр 1,307.4 мян.тн буюу 24.5 хувь, төмрийн баяжмал 1,165.6 мян.тн буюу 50.6 хувь, хайлуур жоншны хүдэр 127.1 мян.тн буюу 41.8 хувь, цайрын баяжмал 149.3 мян.тн буюу 37.0 хувиар тус тус өссөн байна.

Харин молибдены баяжмал 145.5 тн буюу 2.6 хувь, алт 2,259.8 кг буюу 15.2 хувь, хайлуур жоншны баяжмал 61.2 мян.тн буюу 32.5 хувиар, мөнгөний баяжмал 817.0 тн буюу 5.0 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 29. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн хэмжээ

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	2023	2024
1. Уул уурхай, олборлолт				
1.1	Нүүрс	мян.тн	81,304.9	97,721.5
1.2	Газрын тос	мян.бар	4,888.9	4,188.3
1.3	Зэсийн баяжмал	мян.тн	1,395.3	1,562.2
1.4	Молибдений баяжмал	тн	5,643.7	5,498.2
1.5	Цэвэршүүлээгүй алт	кг	14,854.8	12,594.9
1.6	Төмрийн хүдэр	мян.тн	5,334.8	6,642.2
	Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	2,304.4	3,470.0
1.7	Хайлуур жоншны хүдэр	мян.тн	304.1	431.2
	Хайлуур жоншны баяжмал	мян.тн	188.4	127.1
1.8	Цайрын баяжмал	мян.тн	402.9	552.2
1.9	Мөнгөний баяжмал	тн	16,454.0	15,637.0
2. Боловсруулах үйлдвэр				
2.1	Баяжуулсан нүүрс	мян.тн	6,979.4	8,041.6

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	2023	2024
2.2	Нүүрсэн шахмал түлш	мян.тн	504.6	511.4
2.3	Катодын зэс 99%	тн	9,661.3	6,976.3
2.4	Металл бэлдэц	тн	37,680.5	35,987.1
2.5	Металл цувимал	тн	36,117.9	35,031.8
2.6	Ган төмөр хийц	тн	6,195.7	4,504.5

Эх сурвалж: <https://mmhi.gov.mn/>

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 32.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.5 их наяд төгрөг буюу 5.0 хувиар өссөн байна. Үүнд, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 22.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.2 их наяд төгрөг буюу 5.7 хувиар өсөхөд нүүрс олборлолт 834.7 тэрбум төгрөг буюу 8.8 хувиар, металлын хүдэр олборлолт 509.1 тэрбум төгрөг буюу 4.9 хувиар, бусад ашигт малтмал олборлолт 62.0 тэрбум төгрөг буюу 20.3 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

Хүснэгт 30. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн үнийн дүн, тэрбум төгрөг

№	Салбар	2023	2024
1	Уул уурхай олборлолт	21,602.4	22,833.1
2	Нүүрс олборлолт	9,461.5	10,296.2
3	Газрын түүхий тос	1,305.9	1,122.1
4	Металлын хүдэр олборлолт	10,473.4	10,982.6
5	Бусад ашигт малтмал олборлолт	304.9	366.9
6	Уул уурхайн туслах үйл ажиллагаа	56.6	65.4
7	Боловсруулах үйлдвэр	6,965.9	7,028.6
8	Кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	257.0	227.7
9	Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	5.2	5.4
10	Резинан болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	10.8	5.2
11	Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	642.3	673.4
12	Металл боловсруулах үйлдвэрлэл	418.1	516.5
13	Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	43.4	33.6
14	Тээврийн хэрэгслийн бусад тоног төхөөрөмж үйлдвэрлэл	6.1	6.4
15	Бусад боловсруулах үйлдвэрлэл	390.2	279.9
16	Нийт дүн	30,671.9	32,202.6

Эх сурвалж: <https://mmhi.gov.mn/>

Дараах хүснэгтээр 2024 оны нэгтгэл тайланд хамрагдсан аж ахуй нэгж, компаниудын олборлолтын хэмжээг харууллаа.

Хүснэгт 31. Нэгтгэл тайланд хамрагдаж буй аж ахуйн нэгжүүдийн 2024 оны олборлолтын хэмжээ

№	Компани	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Олборлосон үнийн дүн (мян.төгрөг)
1	Ай Би Би Ай ХХК	Алт	гр	200,551.0	48,825,400.0
		Мөнгө	гр	15,533.6	46,124.0
2	Багануур ХК	Хүрэн нүүрс	м.тн	5.0	239,562.0
3	Биг могул коул энд энерги ХХК	Эрчим хүчний нүүрс	м.тн	529.4	
4	БМНС ХХК	Алт	гр	76,840.4	20,809,200,000.0
		Мөнгө	гр	19,054.2	58,237,100.0
5		Алт	гр	2,203,430.0	563,809,000.0

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2024 оны нэгтгэл тайлан

№	Компани	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Олборлосон үнийн дүн (мян.төгрөг)
	Бороогоулд ГХО ХХК	Мөнгө	гр	474,375.0	1,342,210.0
6	Инфинитиспэйс ГХО ХХК	Төмрийн хүдэр	тн	688,574.0	146,207,000.0
7	Их түмэн хүрд ХХК	Урт дөлт нүүрс	тн	1,726,880.0	152,952,000.0
8	Их говь энерги ХХК	Хагас антрацит нүүрс	тн	852.5	222,998.0
9	Коулдголд монгол ХХК	Алт	гр	28,140.7	
		Мөнгө	гр	2,886.7	
10	МАК Цемент ХХК	Гөлтгөнө	тн	83,194.9	1,733,440.0
		Шавар	тн	243,260.0	1,754,190.0
		Шохойн чулуу	тн	1,188,240.0	9,737,060.0
11	Монполимет ХХК	Алт	гр	-	10,638,000.0
12	Монцемент билдинг материалс ХХК	Занар	тн	52,893.0	1,364,640,000.0
		Шохойн чулуу	тн	211,968.0	5,468,780,000.0
		Чулуунцар	тн	456,762.0	77,339,700,000.0
13	Наран мандал энтерпрайзес ГХО ХХК	Алт	гр	277.7	71,012,400.0
		Хүдэр	тн	90,135.8	30,780,500.0
14	Олон ихт баян ХХК	Хүдэр	тн	75.2	12,338,900.0
15	Оюутолгой ГХО ХХК	Зэсийн баяжмал	тн	993,965.0	3,858,600,000.0
16	Өсөхзоос ХХК	Боловсруулаагүй нүүрс	тн	2,823,020.0	343,705,000.0
17	Платинумланд ХХК	Алт	гр	156,860.0	-
18	Саусгоби сэндс ГХО ХХК	1/3 коксжих нүүрс	тн	1,805,340.0	110,732,000.0
		Коксжих чанаргүй нүүрс	тн	8,387,740.0	511,971,000.0
		Баяжуулсан нүүрс	тн		
19	Си Өү Эй Эл ХХК	Нүүрс	тн	620,928.0	82,324,400.0
20	Си Эм Кэй Ай ГХО ХХК	Хайлуур жоншны баяжмал	тн	-	-
21	Тавантолгой ХК	Нүүрс (чулуун)	мян.тн	4,335.5	-
22	Талстдөл ХХК	Хайлуур жонш	тн	107,074.0	1,726,160,000.0
		Баяжмал хайлуур жонш	тн	28,794.2	9,849,780,000.0
23	Тефисмайнинг ХХК	Нүүрс	тн	2,651,470.0	273,585,000,000.0
24	Топ ган дриллинг ХХК	Алт	кг	234.4	63,116,200.0
25	Түмэн айл инвест ХХК	Урт дөлт нүүрс	тн	3,198,590.0	200,976,000.0
		Битумт, үл барьцалдах нүүрс	тн	7,923.8	497,870.0
26	Тэн Хун ГХО ХХК Уулс мандал ХХК	Алт	кг	280.4	95,436,800.0
		Мөнгө	кг	238.6	755,440.0
27	Хан алтай ресурс ХХК	Нүүрс	мян.тн	409.2	1,209,480.0
28	Тэн Хун ГХО ХХК	Хүдэр	мян.тн	4,730.6	-
		Алт	тн	94.6	455,814,000.0
29		Түүхий нүүрс	тн	3,644,360.0	139,728,000.0

№	Компани	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Олборлосон үнийн дүн (мян.төгрөг)
		Баяжуулсан коксжихгүй нүүрс	тн	348,827.0	642,104.0
	Хангад-Эксплорэйшн ГХО ХХК	Баяжуулсан сул коксжих нүүрс	тн	538,469.0	62,499,600.0
		Баяжуулсан нүүрс	тн	738,298.0	128,910,000.0
		Баяжуулсан коксжих нүүрс	тн	-	-
30		Хур эрдэнэ баялаг ГХО ХХК	Дэгдэмхий бодис дунд коксжих, болосруулаагүй нүүрс	тн	492,060.0
31	Цагаан-Өвөлжөө ХХК	Нүүрс	тн	635,209.0	-
32	Цайртминерал ГХО ХХК	Цайрын хүдэр	мян.тн	502.0	-
		Цайрын баяжмал	мян.тн	80.5	-
33	Шанжин-Орд ГХО ХХК	Хүдэр	тн	340,017.0	4,372,830,000.0
		Чулуулаг хөрс	м3	88,316.0	572,938,000.0
		Баяжмал	тн	221,893.0	16,679,900,000.0
34	Шарын гол ХК	Мөнгө	кг	1.5	4,253.8
		Нүүрс	тн	1,719,810.0	80,170,600.0
		Алт	кг	17.1	4,694,560.0
35	Эн И Си ХХК	Нүүрс	тн	1,036.0	22,792.0
36	Энержиресурс ХХК	Түүхий нүүрс	мян.тн	12,694,600.0	900,151,000.0
		Баяжуулсан коксжих нүүрс	мян.тн	-	-
		Баяжуулсан дунд зэрэг үнстэй хагас хатуу коксжих нүүрс	мян.тн	-	-
		Баяжуулсан эрчим хүчний нүүрс	мян.тн	-	-
37	Эрдэнэс Таван толгой ХК	Коксжих нүүрс	тн	28,644,400.0	1,969,420,000.0
		Исэлдсэн нүүрс	тн	1,804,240.0	127,664,000.0
		Баяжуулсан коксжих нүүрс	тн	53,768.8	15,255,600.0
		Баяжуулсан исэлдсэн нүүрс	тн	26,247.4	6,713,410.0
38	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	Зэсийн баяжмал	тн	568,240.0	3,541,880,000.0
		Молибдений баяжмал	тн	5,498.4	308,134,000.0
39	Дорнын чулуулаг ХХК	Боловсруулаагүй нүүрс	тн	204,527.0	4,817,360.0
40	Каскейдмаининг ГХО ХХК	Төмрийн хүдэр	мян.тн	16.3	561,315.0
		Төмрийн бүхэллэг баяжмал	мян.тн	5.5	95,392.5
41	Олгойбулаг ХХК	Нүүрс	тн	20,224.9	-
42	Талстмолор ХХК	Гянтболд	тн	201.0	-

4.3 АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ, АШИГЛАЛТ БА ЛИЦЕНЗИЙН БОДЛОГО

4.3.1 Ураны тухай тойм мэдээлэл

Цөмийн энергийн тухай хууль 2009 онд батлагдаж, 27 аж ахуйн нэгжид цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын 164 тусгай зөвшөөрөл олгосон ба Монгол Улсын нутаг дэвсгэрийн 2.6 хувийг эзэлж байжээ. Харин одоогоор монгол орны нутаг

дэвсгэрийн хэмжээнд цацраг идэвхт ашигт малтмалын 13 орд, 100 орчим илрэл, 1000 гаруй эрдэсэжсэн цэг, цацраг идэвхт гажил илрүүлсэн байдаг.

Харин 2024 онд Цөмийн энергийн тухай хуульд дараах хэсгүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Хүснэгт 32. 2024 онд Цөмийн энергийн тухай хуульд орсон өөрчлөлтүүд

ОГНОО	ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТҮҮД
<p>2024/01/12</p> <p>Нэмэлт оруулах тухай</p>	<p>1 дүгээр зүйл. Цөмийн энергийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.10 дахь хэсгийн "бичгээр" гэсний дараа ", эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр" гэж, 28 дугаар зүйлийн 28.2.7, 28.2.10 дахь заалтын, 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийн "бичгээр" гэсний дараа ", эсхүл цахим хэлбэрээр" гэж тус тус нэмсүгэй.</p>
<p>2024/08/30</p> <p>Өөрчлөлт оруулах тухай</p>	<p>1 дүгээр зүйл. Цөмийн энергийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн "шинжлэх ухааны" гэснийг "Цөмийн энергийн" гэж, 111 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 111.1 дэх хэсгийн, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн "Боловсролын" гэснийг "Цөмийн энергийн" гэж, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн, 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн, 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсгийн, 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсгийн, 28 дугаар зүйлийн 28.2.6, 28.2.7, 28.2.8 дахь заалтын, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн, 36 дугаар зүйлийн 36.1.5 дахь заалтын, 43 дугаар зүйлийн 43.4 дэх хэсгийн, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийн "боловсролын" гэснийг "цөмийн энергийн" гэж тус тус өөрчилсүгэй. 2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>
<p>2024/11/21</p> <p>Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай</p>	<p>1 дүгээр зүйл. Цөмийн энергийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй. 2 дугаар зүйл. Цөмийн энергийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсгийн "улсын ерөнхий" гэсний дараа "байцаагч, эсхүл ахлах" гэж, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн "төлнө" гэсний өмнө "ногдуулан тайлагнаж, төсөвт" гэж, 28 дугаар зүйлийн 28.6.4 дэх заалтын "35.5," гэсний дараа "35.11," гэж тус тус нэмсүгэй. 3 дугаар зүйл. Цөмийн энергийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай. 4 дүгээр зүйл. Цөмийн энергийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.9.2 дахь заалтын "1-3" гэснийг "3" гэж, 20 дугаар зүйлийн 20.3.2 дахь заалтын "Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлд" гэснийг "энэ хуулийн 20¹ дүгээр зүйлд" гэж, 28 дугаар зүйлийн 28.2.11 дэх заалтын дугаарыг "28.2.12" гэж, мөн зүйлийн 28.6.4 дэх заалтын "47.1, 47.5, 47.6, 48.7-48.10-т" гэснийг "48.7, 48.8-д" гэж, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн "10" гэснийг "20" гэж тус тус өөрчилсүгэй. Хэвлэх 5 дугаар зүйл. Цөмийн энергийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.</p>

Эх сурвалж: <https://legalinfo.mn/>

Эдгээр өөрчлөлтүүд нь цөмийн энергийн салбарын зохицуулалтыг сайжруулах, олон улсын стандартад нийцүүлэх, төрийн хяналтыг бэхжүүлэх зорилготой юм.

☹ **Монгол дахь ураны олборлолт ба олон нийтийн санаа зовнил:** Монгол Улс 1948 оноос ураны судалгааг эхлүүлсэн түүхтэй бөгөөд 2024 онд ураны олборлолттой холбоотой асуудлууд дахин анхаарлын төвд орсон байна. Иргэдийн эсэргүүцлийн үндсэн шалтгаан нь ураны олборлолт нь хүн, мал амьтны эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай гэх айдас байв. Тухайлбал,

ураны олборлолт нь цацраг идэвхт хаягдал үүсгэж, энэ нь хүн, малын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болох талаар олон нийтийн санаа зовнил үүссээр байна.

Ашигт малтмал газрын тосны газрын мэдээлснээр дараах газруудад ураны тусгай зөвшөөрлүүд олгогдоод байна.

Хүснэгт 33. Хүчин төгөлдөр байгаа Ураны тусгай зөвшөөрлүүд

Д/д	Жагсаалт	Талбайн нэр	Талбайн хэмжээ (га)	Аймаг	Сум	Эзэмшигч
1	MV-018914	Өмнөт	2,464.9	Дорноговь	Улаанбадрах	Бадрах энержи
2	MV-018915	Зөвч овоо	18,213.6	Дорноговь	Улаанбадрах	Бадрах энержи
3	MV-018916	Дулаан уул	27,697.3	Дорноговь	Улаанбадрах	Бадрах энержи

Эх сурвалж: АМГТГ

Уран олборлох гэрээний онцлог заалтуудаас дурдвал:

- 3. Гэрээний хугацаа:** 20 жил. Цаашид 10 хүртэлх жилээр сунгаж болно.
- 4. Хөрөнгө оруулалтын хэмжээ:**
1.650.000.000 (Нэг тэрбум зургаан зуун тавин сая) ам.доллар.
Эхний хөрөнгө оруулалтын хэмжээ 500 сая ам.доллар.
- 5.Төсөл хэрэгжих үе шат:**
 - Бүтээн байгуулалтын үе шат (Дөрвөн жил)
 - Уурхайн ашиглалтын үе шат
 - Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн үе шат
- 6. Засгийн газрын хяналт, шалгалт:**
"Геологийн судалгаа шинжилгээний төв" ТӨҮГ-ын Цөмийн шинжилгээний лабораторийн тогтмол хяналтад байна.
- 7. Шууд үр өгөөж:** Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн шууд үр өгөөжийн 51-ээс доошгүй хувийг Монгол улсын Засгийн газар хүртэнэ.

Энэхүү Хөрөнгө оруулалтын гэрээнд Монгол, Франц хоёр улсын Засгийн газрын болон Орано группийн холбогдох төлөөллүүд гарын үсэг зурсан байна. Гэрээнд Монгол Улсыг төлөөлж, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Эрдэнэс Монгол нэгдлийн гүйцэтгэх захирал С.Наранцогт нарт эрх олгосны дагуу гарын үсэг зуржээ. Түүнчлэн гэрээний талаарх нэмэлт мэдээллийг <https://mining.mn/> сайтаас авах боломжтой юм.

4.3.2 Стратегийн ач холбогдол бүхий ордууд

Монгол Улсад “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд” гэдэг нь эдийн засаг, нийгэм, үндэсний аюулгүй байдалд онцгой нөлөөтэй, төрийн оролцоо шаардахуйц ордыг хэлдэг. Энэ ойлголт нь Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27-р тогтоолоор дараах ордуудыг стратегийн ач холбогдолтой гэж тодорхойлогдсон байдаг.

Доорх мэдээлэл нь 2024 оны байдлаар хүчин төгөлдөр, стратегийн ач холбогдол бүхий ордууд болон тэдгээрийн товч тайлбарыг багтаав.

Хүснэгт 34. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордууд (Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт)

№	Ордын нэр	Ашигт малтмалын төрөл	Байршил	Тайлбар
1.	Таван толгой	Чулуун нүүрс	Өмнөговь, Цогтцэций	Тавантолгой ХК, Энержиресорс ХХК, Эрдэнэс Тавантолгой ХК"-ийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн хэмжээнд нөөц тооцсон талбайг хамааруулна. <i>/Энэ заалтад 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 73 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон./</i>

№	Ордын нэр	Ашигт малтмалын төрөл	Байршил	Тайлбар
2.	Нарийн сухайт	Нүүрс	Өмнөговь, Гурвантэс	Монгол Улсын Засгийн газартай тогтвортой байдлын гэрээ байгуулсан.
3.	Багануур	Хүрэн нүүрс	Улаанбаатар, Багануур	Нөөц тооцсон талбайг хамааруулна. “Багануур” ХК олборлодог.
4.	Шивээ Овоо	Хүрэн нүүрс	Говьсүмбэр, Шивээговь	Нөөц тооцсон талбайг хамааруулна. “Шивээ Овоо” ХК олборлодог.
5.	Мардай	Уран	Дорнод, Дашбалбар	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн бөгөөд хувийн хөрөнгөөр нэмэлт хайгуул хийж байна.
6.	Дорнод	Уран	Дорнод, Дашбалбар	
7.	Гурван булаг	Уран	Дорнод, Дашбалбар	
8.	Төмөртэй	Төмрийн хүдэр	Сэлэнгэ, Хүдэр	Уг ордын тусгай зөвшөөрлийг “БЛТ” ХХК эзэмшиж байсныг 2006 онд цуцалсан. Нөөц тооцсон талбайг хамааруулна.
9.	Оюу толгой	Зэс, молибдени	Өмнөговь, Ханбогд	Ордын нөөцийн тооцоо бүхий тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэхэд бэлтгэж байна. Бүлэг ордын хэмжээгээр ойлгоно.
10.	Цагаан суварга	Зэс, молибдени	Дорноговь, Мандах	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн бөгөөд хувийн хөрөнгөөр нэмэлт хайгуул хийж байна.
11.	Эрдэнэт	Зэс, молибдени	Орхон, Баян-Өндөр	Монгол Улс-ОХУ-ын Засгийн газар хоорондын гэрээгээр зохицуулагдаж байгаа.
12.	Бүрэнхаан	Фосфорит	Хөвсгөл, Алаг-Эрдэнэ	Хөвсгөлийн их дархан цаазат газрын гадна ногдох нөөц тооцогдсон хэсэгт дөрвөн компани хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшдэг.
13.	Бороо	Алт	Сэлэнгэ, Баянгол	Монгол Улсын Засгийн газартай тогтвортой байдлын гэрээ байгуулсан.
14.	Төмөртэйн овоо	Цайр, хар тугалга	Сүхбаатар, Сүхбаатар	Монгол Улсын Засгийн газартай тогтвортой байдлын гэрээ байгуулсан.
15.	Асгат	Мөнгө	Баян-Өлгий, Ногооннуур	Монгол Улс-ОХУ-ын Засгийн газар хоорондын гэрээ бүхий хамтарсан Монголросцветмет нэгдэл тусгай зөвшөөрлийг нь эзэмшиж байгаа.
16	Гацуурт <i>/Энэ заалтыг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор нэмсэн/</i>	Алт	Сэлэнгэ, Мандал	Ордын хил хязгаарыг Засгийн газар тогтооно.

Эх сурвалж: <https://legalinfo.mn/>

Хүснэгт 35. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордууд (Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт)

д/д	Ордын нэр	Ашигт малтмалын төрөл	Байршил	Тайлбар
1.	Улаан-Овоо	Нүүрс	Сэлэнгэ, Түшиг	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн.
2.	Өвдөг худаг	Нүүрс	Дундговь, Баянжаргалан	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, одоо ашиглаж байгаа.
3.	Баянтээг	Нүүрс	Өвөрхангай, Нарийнтээл	Хувьцаат компани ашиглаж байгаа.

д/д	Ордын нэр	Ашигт малтмалын төрөл	Байршил	Тайлбар
4.	Нүүрст хотгор	Нүүрс	Увс, Бөхмөрөн	Хувьцаат компани ашиглаж байгаа.
5.	Хар тарвагатай	Нүүрс	Увс, Өмнөговь	Хувьцаат компани ашиглаж байгаа.
6.	Адуунчулуун	Нүүрс	Дорнод, Хэрлэн	Хувьцаат компани ашиглаж байгаа.
7.	Тэвшийн говь	Нүүрс	Дундговь, Сайнцагаан	Хувьцаат компани ашиглаж байгаа.
8.	Талбулаг	Нүүрс	Сүхбаатар, Баруун-Урт	Хувьцаат компани ашиглаж байгаа.
9.	Чандган тал	Нүүрс	Хэнтий, Мөрөн	Хувьцаат компани ашиглаж байгаа.
10.	Хөөтийн хонхор	Нүүрс	Дундговь, Баянжаргалан	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн.
11.	Хөөт	Нүүрс	Дорнод, Матад	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн.
12.	Налайх	Нүүрс	Улаанбаатар, Налайх	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, уул техникийн нөхцөл хүндэрсэн.
13.	Алаг тогоо	Нүүрс	Дорноговь, Даланжаргалан	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, нэмэлт хайгуулыг хувийн хөрөнгөөр хийсэн.
14.	Зээгт	Нүүрс	Говь-Алтай, Чандмань	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, одоо хувьцаат компани ашиглаж байгаа.
15.	Могойн гол	Нүүрс	Хөвсгөл, Цэцэрлэг	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, одоо хувьцаат компани ашиглаж байгаа.
16.	Сайхан-Овоо	Нүүрс	Булган, Сайхан	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, одоо хувьцаат компани ашиглаж байгаа.
17.	Баргилт	Төмрийн хүдэр	Хэнтий, Дархан	Улсын эрдэс баялгийн нөөцөд бүртгэгдээгүй.
18.	Төгрөг нуур	Нүүрс	Төв, Баян	Улсын эрдэс баялгийн нөөцөд бүртгэгдээгүй.
19.	Наран толгой	Алт	Төв, Жаргалант	Одоо бага хүчин чадлаар ашиглаж байгаа.
20.	Тавт	Алт	Булган, Тэшиг	Хувийн хөрөнгөөр хайгуул хийж нөөц өссөн.
21.	Төмөр толгой	Төмрийн хүдэр	Дархан-Уул, Хонгор	Тусгай зөвшөөрлийг цуцалсан.
22.	Баян давааны бүлэг орд	Цагаан тугалга, гянтболд	Төв, Эрдэнэ	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, одоогоор ашиглаагүй.
23.	Улаан Уул	Цагаан тугалга, гянтболд	Баян-Өлгий, Улаанхус	Одоо бага хэмжээгээр ашиглаж байгаа.
24.	Жанчивлангийн бүлэг орд	Цагаан тугалга, гянтболд	Төв, Эрдэнэ	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, одоогоор ашиглаагүй.
25.	Цагаан даваа	Цагаан тугалга, гянтболд	Төв, Баянчандмань	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, одоогоор бага хэмжээгээр ашиглаж байгаа.

д/д	Ордын нэр	Ашигт малтмалын төрөл	Байршил	Тайлбар
26.	Мөнгөн Өндөр	Мөнгө	Хэнтий, Өмнөдэлгэр	Улсын эрдэс баялгийн нөөцөд бүртгэгдээгүй.
27.	Хөх адар	Зэс, цайр	Баян-Өлгий, Толбо	Хувийн хөрөнгөөр нэмэлт хайгуул хийгдэж байгаа.
28.	Шаврын царам	Пироп	Архангай, Тариат	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, одоогоор бага хэмжээгээр ашиглаж байгаа.
29.	Шүдэн уул	Чулуун давс	Увс, Давст	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, одоогоор ашиглаагүй.
30.	Ширээ уул	Гөлтгөнө	Дундговь, Дэлгэрхангай	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн.
31.	Өвдөг худаг	Хүрэн нүүрс	Дундговь, Өндөршил	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, одоо ашиглаж байгаа.
32.	Цайдам нуур	Хүрэн нүүрс	Төв, Баян	Нөөцийн зэрэг С2-оос доош үнэлэгдсэн.
33.	Цагаан цав	Цеолит	Дорноговь, Сайхандулаан	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн, одоо бага хэмжээгээр ашиглаж байгаа.
34.	Манхан уул	Фосфорит	Хөвсгөл, Алаг-Эрдэнэ	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн.
35.	Онгилог нуур	Фосфорит	Хөвсгөл, Алаг-Эрдэнэ	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн.
36.	Лугийн гол	Газрын ховор элемент	Дорноговь, Хатанбулаг	Нөөцийн зэрэг С2-оос доош үнэлэгдсэн.
37.	Хонгор	Жонш	Дорноговь, Даланжаргалан, Айраг	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн.
38.	Улаан	Цайр, хар тугалга	Дорнод, Дашбалбар	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн.
39.	Цав	Цайр, хар тугалга	Дорнод, Чойбалсан	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн.

Эх сурвалж: <https://legalinfo.mn/>

4.3.3 Бичил уул уурхай буюу гар аргаар ашигт малтмал олборлох



Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.23-т **“Бичил уурхай эрхлэх”** гэж үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-д заасан **хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагааг бичил уул уурхай олборлолт гэж тодорхойлдог.**



“Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” нь хамгийн сүүлд 2022 оны 8 дугаар сарын 3-ны өдөр МУ-ын засгийн газрын Дугаар 296 тогтоолоор шинэчлэгдэн хэрэгжсээр байна.
Уг журам хэрэгжиж эхэлснээр бичил уурхай эрхлэгчид төрийн үйлчилгээ авах боломжтой болж, нөхөн сэргээлт хийдэг болсон байна.


Эх сурвалж: <https://legalinfo.mn/>

Бичил уурхайн эдийн засагт оруулж буй хувь нэмэр:

Бичил уурхай эрхлэгчид олборлосон алтаа албан ёсны борлуулалтын сүлжээгээр дамжуулснаар Монгол банкны гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна. Мөн энэ үйл ажиллагаа шууд болон шууд бус байдлаар ажлын байр бий болгож, үндэсний болон орон нутгийн эдийн засгийн хөгжилд тодорхой үр нөлөө үзүүлж байна.

Гэсэн хэдий ч сүүлийн 5 жилийн худалдан авсан алтны хэмжээ буурсаар байгаа бөгөөд 2024 оны хувьд өмнөх онтой харьцуулахад 1,403 кг-аар буурсан үзүүлэлттэй байна.


График 7. Монгол банкны худалдан авсан алтны хэмжээ, 2020-2024 (кг)



Эх сурвалж: <https://www.mongolbank.mn/>

Харин сарын үзүүлэлтээр харахад, улирлын онцлогоос шалтгаалан дулааны улиралд олборлон, худалдсан алтны хэмжээ өндөр байв.

График 8. Монгол банкны худалдан авсан алтны хэмжээ, 2024 он, сараар (кг)



Эх сурвалж: <https://www.mongolbank.mn/>

Бичил уурхайн талаарх мэдээллийн тархац, эх сурвалж:

Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо нь **2013 оны 5 дугаар сарын 2-ны** өдөр анх байгуулагдсан бөгөөд 15 аймгийн 45 суманд 70 гишүүн байгууллага, 429 нөхөрлөлд багтсан 6500 гаруй гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа тогтвортой явуулж байна. Холбоо нь бичил уурхайн салбарыг хариуцлагатай хөгжүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах, гишүүдийн эрх ашгийг хамгаалах, чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр төр, олон улсын байгууллагуудтай хамтран ажилладаг байна.

Хүснэгт 36. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох дүгнэлт гарсан талбай

Аймаг, нийслэл	Дүгнэлт гарсан талбай		Хэмжээ	
	Тоо	Хувь	Га	Хувь
Баян-Өлгий	1	3.4%	4.76	4.7%
Баянхонгор	4	13.8%	13.35	13.3%
Булган	2	6.9%	5.16	5.1%
Говь-Алтай	1	3.4%	0.02	0.0%
Дорноговь	4	13.8%	19.25	19.1%
Сэлэнгэ	8	27.6%	27.07	26.9%
Төв	2	6.9%	5.00	5.0%
Увс	2	6.9%	7.54	7.5%
Хэнтий	5	17.2%	18.58	18.4%
НИЙТ	29	100.0%	100.73	100.0%

Эх сурвалж: <https://mrpam.gov.mn/>

Монголын бичил уурхай эрхлэгчдийн талаар болон дэлгэрэнгүй статистик мэдээллийг АҮЭБЯ, АМГТГ, БОУАӨЯ болон Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбооноос авах боломжтой.


Бичил уурхайн нөхөн сэргээлтийн байдал: Олборлолт эхлэхийн өмнө бичил уурхай эрхлэгч нь сумын нөхөн сэргээлтийн санд нөхөн сэргээлтийн барьцаа байршуулдаг (жишээ нь 3,000,000 төгрөг буюу 1,052 ам.доллар) бөгөөд бичил уурхайн байгууллага тухайн талбайг нөхөн сэргээлгүй хаяж явсан тохиолдолд тус хөрөнгийг ашиглана. Гэвч орон нутгийн удирдлага уг мөнгийг зориулалтаар нь зарцуулдаг эсэх, эсвэл бичил уурхайн байгууллагад нөхөн сэргээлтийн ажил хийхэд туслах зорилгоор цаг тухайд нь мөнгийг гаргаж өгсөн эсэх нь тодорхойгүй бөгөөд тухайн санд хуримтлуулсан хөрөнгийн зарцуулалтыг тайлагнадаггүй, мэдээлэл нь хаалттай байна.

4.3.4 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа (шаардлага 2.2, шаардлага 2.3)

ЭРХ ЗҮЙН ҮНДЭС: Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох, цуцлах, шилжүүлэх, сунгах үйл ажиллагаа:

- ✓ Ашигт малтмалын тухай хууль: (2022 оны 4-р сарын 12-ны өдөр Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам (“Тусгай зөвшөөрөл олгох журам” гэх) шинэчлэгдэн батлагдаж, 2018 онд батлагдсан Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам хүчингүй болсон)

График 9. Ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо, талбайн хэмжээ (мянган га), 2020-2024 он



Эх сурвалж: <https://mrpam.gov.mn/>

АМГТГ-ын кадастрын цахим хуудсанд **2024 оны байдлаар 2,724 тусгай зөвшөөрлийн мэдээллийг нийтэд ил болгосон байна.** Түүнчлэн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээллийг Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг, Ашигт малтмалын, газрын тосны газрын сар бүр эрхлэн гаргадаг Эрдэс баялгийн статистик мэдээнээс дараах сайтаар хүлээн авах боломжтой. <https://cmcs.mrpam.gov.mn/>

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл явц:

АМГТГ	• Өргөдөл гаргахаар бүртгүүлсэн этгээдэд дугаар олгож, өргөдөл хүлээн авна.
АМГТГ-ын Кадастрын хэлтэс	• Хүсэлтэд дурдсан талбай нь ашигт малтмал эрэх, хайх, боломжтой эсэхийг тогтооно.
Орон нутгийн засаг захиргаа	• Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох хүсэлтийг аймгийн эсвэл хотын захиргаа руу 30 хоногийн дотор хариу авахаар хүргүүлэх бөгөөд хэрэв энэ хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд АМГ тухайн орон нутгийн засаг захиргааг уг саналыг зөвшөөрсөн гэж үзнэ.
АМГТГ	• Тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг зөвшөөрөл хүсэгч ажлын 10 өдөрт багтаан төлнө.
АМГТГ-ын Кадастрын хэлтэс	• АМГ нь хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар олгох бөгөөд дараа нь хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 удаа тус бүр 3 жилийн хугацаатай сунгаж болно.

Эх сурвалж: АМГТГ

Бусад **ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй холбоотой** мэдээллүүдийг **2023 оны буюу 18 дугаар нэгтгэл тайлангаас** дараах агуулгаар тоймлон авч үзэх боломжтой. Үүнд:

- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлөөс ашиглалтын тусгай зөвшөөрөл болгож өөрчлөх үйл явц;
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулах замаар олгох үйл явц;
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шилжүүлэх үйл явц;
- Тусгай зөвшөөрөл олгоход ашигладаг техникийн шалгуур үзүүлэлтүүд;
- Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц;
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц болно.

Ашигт малтмал газрын тосны газраас эрхлэн гаргадаг 2020-2024 онд хөдөлгөөн хийгдсэн тусгай зөвшөөрлүүдийн мэдээллийг дараах хүснэгтээр үзүүлэв. Ашигт малтмалын тухай хууль болон тусгай зөвшөөрөл олгох журамд, тусгай зөвшөөрлийг нөхөн олгох тухай зохицуулалт тодорхой заагдаагүй хэдий ч 2024 онд **ашиглалтын тусгай зөвшөөрөл 10, хайгуулын тусгай зөвшөөрөл 5-ыг нөхөн** олгосон байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.15-д зааснаар: Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл шинээр олгох, дахин олгох, цуцлах, шилжүүлэх, барьцаалах, талбайг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаан өгөх, шилжүүлэх ажиллагааг олон нийтийн хяналтын дор явуулах нөхцөлийг бүрдүүлэх; ёстой байна.

Хүснэгт 37. Хөдөлгөөн хийгдсэн тусгай зөвшөөрлийн тоо, төрлөөр, 2020-2024 он

Тусгай зөвшөөрлийн төрөл	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Шинээр олгосон	90	163	93	238	105
Талбай буцаасан	71	26	34	27	28
Цуцалсан/хүчингүй	140	75	45	39	47
Дуусгавар болгосон	133	120	100	27	57
Шилжүүлсэн	83	74	63	92	101
Сунгуулсан	68	246	291	94	304
Барьцаалсан	27	38	22	21	21
Барьцаа чөлөөлсөн	28	16	23	31	31
Нөхөн олгосон	17	11	6	11	15

Эх сурвалж: <https://mrpam.gov.mn/>

Дараах хүснэгтээр “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын төлбөрийн мэдээлэл”-ийг харуулж байна. Энэ нь төрөөс (улсын төсвөөс) хөрөнгө гарган ашигт малтмалын хайгуул хийж, орд илрүүлсэн тохиолдолд, тухайн ордыг ашиглах эрхийг хувийн компани, байгууллага, этгээдэд олгох үед төрд төлөх төлбөртэй холбоотой мэдээлэл юм. Өөрөөр хэлбэл төрийн мөнгөөр хайгуул хийж, нөөц тогтоосон ордыг хэн, ямар нөхцөлөөр ашиглаж байгаа, тэдгээрээс төрд хэр хэмжээний төлбөр, хураамж орж байгаа тухай билээ.

Судалгаанд хамрагдсан 110 ААН-ийн 113 тусгай зөвшөөрлийн 2024 оны төлбөрийн мэдээллийг харахад нийт 16 тусгай зөвшөөрөлд гэрээ байгуулаагүй, 1 тусгай зөвшөөрөлд нөхөн төлбөрийн тооцоолол хийгдэж байгаа, 13 тусгай зөвшөөрөлд нөхөн төлбөрийн тооцоолол хийлгэсэн ч төлбөр гараагүй бол үлдсэн 43 компанийн 80 тусгай зөвшөөрөл нийт 46.9 тэрбум төгрөгийн төлбөр төлсөн байв.

Уг төлбөрийн мэдээллийг “Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцох, төлөх журам” болон “Ашигт малтмалын тухай хууль”-ийн:

- “47 дугаар зүйл - Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр”
- “60 дугаар зүйл - Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр” – өөр зохицуулдаг байна.

Тус зохицуулалтын хүрээнд ХАЗ-ын гэрээ (Хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн гэрээ) буюу төрийн зарцуулсан хөрөнгийг буцаан төлөх зорилгоор байгуулдаг ба гэрээний загварыг АМГТГ-ын (<https://mrpam.gov.mn/>) сайтаас татан авах боломжтой.

Түүнчлэн, улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлыг **баталгаажуулсан баримт бичиг нь “акт”** хэлбэртэй байдаг. Энэ нь тухайн ордын хайгуулын ажлын үр дүнг улсын мэдэлд хүлээн авсан, хайгуулын ажил төрийн хөрөнгөөр хийгдсэнийг нотолсон эрх зүйн баримт бичиг юм. Энэхүү актыг үндэслэн АМГТГ нөхөн төлбөрийн гэрээ байгуулах болон төлбөр тооцоог хийх ажиллагааг эхлүүлдэг. Акт гарсан орд нь “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн орд” гэж хуулийн дагуу тооцогддог тул тухайн ордод ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан этгээд заавал хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн (ХАЗ) гэрээ байгуулах үүрэгтэй болдог байна.

Хэрэв гэрээ байгуулаагүй бол хуулийн зөрчил үүсэх ба **“Ашигт малтмалын тухай хууль”**-ийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол **АМГТГ тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, цуцлах үндэслэл** болдог байна.

Түүнчлэн *“Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлыг нөхөн төлөх гэрээ”-ний үүргээ бүрэн биелүүлээгүй тохиолдолд Ашигт малтмалын тухай хуулийн **60 дугаар зүйлийн 60.9 дэх хэсгийн** “Нөхөн төлбөр төлөх гэрээний үүргийг биелүүлэх тухай мэдэгдлийг төрийн захиргааны байгууллагаас авснаас хойш 30 хоногийн дотор энэ хуулийн **60.1, 60.7-д** заасан нөхөн төлбөр, алдангийг төлөөгүй бол тусгай зөвшөөрлийг цуцалж, тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд сонгон шалгаруулалт зарлана” гэж заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл бүрддэг.*

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2024 оны нэгтгэл тайлан

Хүснэгт 38. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын төлбөрийн мэдээлэл, 110 ААН-ээр, 2024 он

№	Регистр	Компанийн нэр	Тусгай зөвшөөрөл	Гэрээ хийсэн огноо	Гэрээний дугаар	Төлбөр		Үлдэгдэл	Акт	Тайлбар
						Доллар	Төгрөг			
1	5098564	АДАЭ ГХО ХХК	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
2	5809797	Ай Би Би Ай ХХК	MV-020602	10/5/2020	ХАЗ-2020/01/20	-	182,980,432.0	-	№2021/24 2021/09/15	
3	5051118	Андын илч ГХО ХХК	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
4	5005094	Аурум металс ХХК	MV-018354	3/22/2019	ХАЗ-2019/01/24	-	13,773,989.7	-	№2021/18 2021/09/15	
5	2008572	Багануур ХК	MV-001371	4/14/1999	ХАЗ-1999/04/14	94,694.0	-	-	-	
6	5215919	Бадмаарагхаш ГХО ХХК	MV-016679	2018.07.19	ХАЗ-2018/01/43	-	17,880,622.3	-	№2022/03	
7	5502977	Бадрах энержи ХХК	MV-018914	8/9/2017	ХАЗ-2017/01/37	-	1,492,178,770.3	-	№2021/27 2021/09/15	
			MV-018915							
			MV-018916							
8	2007126	Баялаг-Орд ХХК	222А	1/10/2008	ХАЗ-2008/01/10	108,612.0	-	-	11/18/2015	
9	6528732	Баян хөх толгой ташгай ХХК	-	-	-	-	-	-	-	Тусгай зөвшөөрөл байхгүй
10	2014491	Баянтээг ХК	367А	4/9/2010	-	459,154.2	-	409,194.0	-	
11	5369223	Биг могоул коул энд энержи ХХК	MV-020772	3/1/2018	ХАЗ-2018/01/16	-	15,944,920.5	-	-	
12	6690912	Бичигт шим майнинг ХХК	-	-	-	-	-	-	-	Тусгай зөвшөөрөл байхгүй
13	5477301	Блэйкмаунт майнинг ХХК	MV-021108	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
14	2801299	БМНС ХХК	MV-001410	2/27/2018	ХАЗ-2018/01/10	-	10,462,429.0	-	2019/05/17 №2019/02/20	
15	2855119	Болдтөмөр ерөө гол ГХО ХХК	MV-008888	11/2/2005	ХАЗ-2005/11/02	-	39,462.0	-	2005/04 акт	
16	2094533	Бороогоулд ГХО ХХК	MV-015285	7/30/2021	ХАЗ-2021/07/07	-	246,989,903.3	-	№2024/11 2024/11/07	
			MV-001970	6/30/2021	ХАЗ-2021/05/06	-	340,489,544.1	-	№2023/04 2023/01/17	
			MV-000238	7/23/2001	ХАЗ-2001/07/23	170,118.0	-	-	№11/08 2011/06/07	
			MV-000198	4/4/2002	ХАЗ-2002/04/04	2,387,046.0	-	-	№11/09 2011/06/07	
17	3737373	Бугантнандин ХХК	-	-	-	-	-	-	-	Тусгай зөвшөөрөл байхгүй

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2024 оны нэгтгэл тайлан

№	Регистр	Компанийн нэр	Тусгай зөвшөөрөл	Гэрээ хийсэн огноо	Гэрээний дугаар	Төлбөр		Үлдэгдэл	Акт	Тайлбар
						Доллар	Төгрөг			
18	4065115	Вестернхолд ХХК	MV-021081	6/18/2025	ХАЗ-2025/06/14	-	12,855,320.9	-	№2025/08/28	
19	5122392	Гаррисон-Азия ГХО ХХК	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
20	6463932	Говийн шандаст хүлэг ГХО ХХК	-	-	-	-	-	-	-	Тусгай зөвшөөрөл байхгүй
21	5060222	Голденхейлс ГХО ХХК	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
22	6194559	Гуо мао жиа хэ ГХО ХХК	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
23	2074737	Гурвансайхан ГХО ХХК	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
24	2766337	Доншен газрын тос монгол ГХО ХХК	-	-	-	-	-	-	-	Тусгай зөвшөөрөл байхгүй
25	5070287	Дорнын чулуулаг ХХК	-	-	-	-	-	-	-	Нөхөн төлбөрийн тооцоолол хийлгэсэн. Төлбөр гараагүй
26	5467266	Инфинитиспэйс ГХО ХХК	-	-	-	-	-	-	-	Тусгай зөвшөөрөл байхгүй
27	6375839	Их түмэн хүрд ХХК	MV-021559	6/18/2025	ХАЗ-2025/06/16	-	3,417,975.2	-	№2025/09/32	
28	5522935	Их говь энерги ХХК	MV-018775 MV-018548 MV-017196	5/25/2017	ХАЗ-2017/01/22	-	4,550,429.3	-	2017/06/06 №2017/02/18	
29	5463599	Каскейдмайнинг ГХО ХХК	MV-012328	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
30	2571498	Коулдголд монгол ХХК	MV-001137	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
31	2708345	Лэндмонголиа ГХО ХХК	MV-020606	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
32	5830974	МАК Цемент ХХК	MV-009427	-	-	-	-	-	-	Нөхөн төлбөрийн тооцоолол хийлгэсэн. Төлбөр гараагүй
33	5689945	Макс-Ойл ХХК	-	-	-	-	-	-	-	Тусгай зөвшөөрөл байхгүй
34	5070651	Миний тоонот ХХК	MV-017337	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
35	5036496	Молиметал ГХО ХХК	MV-010889 MV-009975	7/6/2025 7/5/2025	ХАЗ-2025/07/19 ХАЗ-2025/07/18	- -	1,008,551,392.2 282,118,899.4	- -	- -	
36	5253535	Монгол майнинг энд эксплорэйшн ХХК	MV-005028	9/25/2012	-	181,359.0	-	-	Акт үйлдэх	
37	5150884	Монгол ураниум ресурс ХХК	MV-021459	-	-	-	-	-	-	Нөхөн төлбөрийн тооцоолол

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2024 оны нэгтгэл тайлан

№	Регистр	Компанийн нэр	Тусгай зөвшөөрөл	Гэрээ хийсэн огноо	Гэрээний дугаар	Төлбөр		Үлдэгдэл	Акт	Тайлбар	
						Доллар	Төгрөг				
										хийлгэсэн. Төлбөр гараагүй	
38	5051304	Монголжүюаньли ГХО ХХК	MV-010988	8/6/2009	ХАЗ-2009/08/06	167,813.0	-	-	2015/04 акт		
39	5401801	Монголиан нэшнл рийр ийрт корп ГХОХХК	MV-006911	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй	
40	2095025	Монголын Алт МАК ХХК	MV-000716	-	-	-	-	-	-	Нөхөн төлбөрийн тооцоолол хийлгэсэн. Төлбөр гараагүй	
			MV-020297	9/25/2018	ХАЗ-2018/01/50		123,873,077.7	-	№2022/02		
			MV-012199								
			MV-017334	7/24/2008	ХАЗ-2008/07/24	347,892.0	-	-			
			MV-014892								
			MV-012463	-	-	-	-	-	Нөхөн төлбөрийн тооцоолол хийлгэсэн. Төлбөр гараагүй		
			MV-002545	-	-	-	-	-	-	-	
			MV-012226	12/25/2007	ХАЗ-2007/12/25		82,547.0	-	Акт-08/01		
			MV-012225								
MV-000227											
MV-005459											
MV-006852											
41	2029278	Монполимет ХХК	MV-000321	1/6/2000	ХАЗ-2000/01/06	445,316.7	-	-	-		
			MV-000184	1/6/2000	ХАЗ-2000/01/05	48,770.0	-	-	-		
42	5106567	Монцемент билдинг материалс ХХК	MV-013681	12/13/2017	ХАЗ-2017/01/51	-	32,421,369.2	-	-		
43	5197783	МТ майнинг ХХК	MV-021769	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй	
44	5106656	Нагааранз ХХК	MV-020444	-	-	-	-	-	-	Нөхөн төлбөрийн тооцоолол хийлгэсэн. Төлбөр гараагүй	
45	5295858	Наран мандал энтерпрайзес ГХО ХХК	MV-006907 MV-006720	11/30/2018	ХАЗ-2018/01/60	-	287,926,053.0	-	№2023/19		
46	5442893	Нутгийн хаш ХХК	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй	
47	5966302	Нүүрс хими технологи ХХК	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй	

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2024 оны нэгтгэл тайлан

№	Регистр	Компанийн нэр	Тусгай зөвшөөрөл	Гэрээ хийсэн огноо	Гэрээний дугаар	Төлбөр		Үлдэгдэл	Акт	Тайлбар	
						Доллар	Төгрөг				
48	2337231	Олгойбулаг ХХК	MV-017611	-	-	-	-	-	-	Нөхөн төлбөрийн тооцоолол хийлгэсэн. Төлбөр гараагүй	
49	6287727	Олон ихт баян ХХК	MV-021248	-	-	-	-	-	-	Нөхөн төлбөрийн тооцоолол хийлгэж байгаа,	
			MV-021441	-	-	-	-	-	-		
50	2705133	ОНТРЭ ГХО ХХК	MV-015225	-	-	-	-	-	-	Нөхөн төлбөрийн тооцоолол хийлгэсэн. Төлбөр гараагүй	
			MV-015226								
51	2678187	Оюут Улаан ХХК	MV-017387	7/7/2014	ХАЗ-2014/04/83	1,386,927.2	-	-	Акт №2019/02/29		
52	2657457	Оюутолгой ГХО ХХК	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй	
53	5199077	Өсөхзоос ХХК	MV-017317	2/6/2019	ХАЗ-2019/01/04	-	8,807,473.3	-	Акт 2020/2/35		
54	2867095	Петроматад ГХО ХХК	-	-	-	-	-	-	-	Тусгай зөвшөөрөл байхгүй	
55	2075385	Петрочайнна дачин тамсаг ГХО ХХК	-	-	-	-	-	-	-	Тусгай зөвшөөрөл байхгүй	
56	5076285	Платинумланд ХХК	MV-001134	12/21/2012	ХАЗ-2012/23/12	388,080.1	-	-	Акт № 2/5/2019		
			MV-013786	6/23/2021	ХАЗ-2021/02/03	-	-	-	-	-	-
			MV-013787								
			MV-000782	3/23/1999	3/23/1999	19,456.0	-	-	-	-	-
			MV-000200	10/12/1998	-	12,780.0	-	-	12,780.0	-	-
MV-000181	1/17/2006	1/17/2006	3,993.0	-	-	3,993.0	-	-	Төлөөгүй		
57	2801019	Полиметалл ресурс ХХК	MV-017524	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй	
58	5615631	Премиумкөүл корпораци ХХК	MV-016975	-	-	-	-	-	-	Нөхөн төлбөрийн тооцоолол хийлгэсэн. Төлбөр гараагүй	
59	5084555	Саусгоби сэндс ГХО ХХК	MV-016869	7/4/2025	ХАЗ-2025/07/17	-	2,186,775.7	-	№2025/08/02		
			MV-012726	12/25/2007	ХАЗ-2007/12/25	21,860.0	-	-	-		
60	5261198	Си Өү Эй Эл ХХК	MV-016865	2017/0613	ХАЗ-2017/01/25	-	2,774,154.9	-	2017/12/28 №2017/02/34		

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2024 оны нэгтгэл тайлан

№	Регистр	Компанийн нэр	Тусгай зөвшөөрөл	Гэрээ хийсэн огноо	Гэрээний дугаар	Төлбөр		Үлдэгдэл	Акт	Тайлбар
						Доллар	Төгрөг			
61	5288703	Си Эм Кэй Ай ГХО ХХК	MV-004153	9/10/2009	ХАЗ-2009/09/10	42,401.0	-	-	2012/12 акт	
62	5180945	Сидакунгей ГХО ХХК	MV-017686	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
63	6232485	Сора интернэшнл ХХК	MV-020738	-	-	-	-	-	-	Нөхөн төлбөрийн тооцоолол хийлгэсэн. Төлбөр гараагүй
64	5084903	Соронзонтолгой ХХК	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
65	6101615	Степ голд ГХО ХХК	MV-017111	-	-	-	-	-	-	Нөхөн төлбөрийн тооцоолол хийлгэсэн. Төлбөр гараагүй
66	5524997	Сунхунголд ГХО ХХК	MV-009918	3/12/2019	ХАЗ-2019/01/19	-	24,683,329.0	-	№2019/02/13	
67	2016656	Тавантолгой ХК	MV-000287 MV-011945	12/4/2009	ХАЗ-2009/12/04	737,146.3			Акт-10/01	
68	5105439	Талстдөл ХХК	MV-017291	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
69	5774047	Талстмолор ХХК	MV-020930	-	-	-	-	-	-	Нөхөн төлбөрийн тооцоолол хийлгэсэн. Төлбөр гараагүй
70	8326401	Талын алтан булаг майнинг ХХК	-	-	-	-	-	-	-	Тусгай зөвшөөрөл байхгүй
71	2016931	Талын гал ХК	MV-014563	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
72	5301769	Талын элч ГХО ХХК	MV-016938	-	-	-	-	-	-	Нөхөн төлбөрийн тооцоолол хийлгэсэн. Төлбөр гараагүй
73	2807459	Тефисмайнинг ХХК	MV-018293	-	-	-	-	-	-	Нөхөн төлбөрийн тооцоолол хийлгэсэн. Төлбөр гараагүй
			MV-018291	7/6/2018	ХАЗ-2018/01/36	-	5,225,653.7	-	2019/04/26 №2019/02/16	
74	5112389	Титан-Орд ХХК	MV-020836	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
75	2872943	Тод-Ундрага ХХК	MV-017573	6/19/2017	ХАЗ-2017/01/26	-	205,222,644.3	-	№2021/13	
76	6268048	Топ ган дриллинг ХХК	-	-	-	-	-	-	-	Тусгай зөвшөөрөл байхгүй
77	5874963	Түмэн айл инвест ХХК	MV-021530	6/18/2025	ХАЗ-2025/06/15	-	19,901,279.7	-	№2025/08/01	

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2024 оны нэгтгэл тайлан

№	Регистр	Компанийн нэр	Тусгай зөвшөөрөл	Гэрээ хийсэн огноо	Гэрээний дугаар	Төлбөр		Үлдэгдэл	Акт	Тайлбар	
						Доллар	Төгрөг				
78	2839717	Тэн Хун ГХО ХХК	MV-000713	2/18/2005	ХАЗ-2005/02/18	207,700.0	-	-	-		
79	4183525	Тэрмэнжонш ХХК	MV-005899	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй	
80	5351324	Урагшлахговь ГХО ХХК	MV-017431	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй	
81	6369987	Уулс мандал ХХК	-	-	-	-	-	-	-	Тусгай зөвшөөрөл байхгүй	
82	2819996	Уулсзаамар ХХК	MV-020427	6/4/2019	ХАЗ-2019/01/44	-	14,260,767.7	-	№2019/02/31		
			MV-009305	11/10/2016	ХАЗ-2016/40	208,089.3	-	-	-	акт-2020/02/33	
			MV-000926								
			MV-000704	12/21/2012	ХАЗ-2012/23/12	388,080.1	-	-	-	2010/2 акт	
			MV-001134								
MV-005778											
MV-012439											
83	2868687	Уулсноён ХХК	MV-005974	6/6/2006	ХАЗ-2006/06/06	2,808.0	-	-	2/24/2019		
			MV-000203	199803/27	ХАЗ-1998/03/27	137,405.6	-	70,283.6	-		
84	5100038	Хаантоонот ХХК	MV-021511	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй	
85	6413811	Хан алтай ресурс ХХК	MV-021537	6/23/2021	ХАЗ-2021/04/04	-	27,437,462.1	-	№2022/01 2022/01/05		
86	2887134	Хангад-Эксплорэйшн ГХО ХХК	MV-014493	11/17/2010	ХАЗ-2010-Н03/68	21,576.8	-	-	-		
87	2166631	Хунт-Өгөөж ХХК	MV-016689	3/16/2016	ХАЗ-2016/03/16	42,370.0	-	-	№2020/02/34 тоот		
88	5671833	Хур эрдэнэ баялаг ГХО ХХК	MV-017301	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй	
89	5324998	Хүннү алтай минералс ХХК	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй	
90	5352827	Цагаан-Өвөлжөө ХХК	MV-020800	-	-	-	-	-	-	Нөхөн төлбөрийн тооцоолол хийлгэсэн. Төлбөр гараагүй	
91	2548747	Цайртминерал ГХО ХХК	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй	
92	2641984	Цементшохой ХХК	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй	
93	6342485	Цүй ханг инвест ГХО ХХК	MV-012325	1/19/2018	ХАЗ-2018/01/01	-	7,588,625.4	-	2018/12/20 №2018/02/34		
94	2831686	Цэгээн-Үүдэн ХХК	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй	
95	5197325	Шанжин-Орд ГХО ХХК	MV-010665	10/19/2010	ХАЗ-2010/08/56	327,889.0	-	-	Акт үйлдэж байгаа		

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2024 оны нэгтгэл тайлан

№	Регистр	Компанийн нэр	Тусгай зөвшөөрөл	Гэрээ хийсэн огноо	Гэрээний дугаар	Төлбөр		Үлдэгдэл	Акт	Тайлбар
						Доллар	Төгрөг			
96	2050374	Шарын гол ХК	MV-001498	5/11/2000	ХАЗ-2000/05/11	46,368.0	-	-	Акт-2009/10	
97	2830213	Шинь Шинь ГХО ХХК	MV-000247	6/5/2006	ХАЗ-2006/06/05	1,302,205.0	-	-	Акттай	
			MV-010089	12/25/2007	ХАЗ-2007/12/25	546,200.0	-	-	2012/12/05/11 акт	
98	5665914	Шинэ уужим орд ХХК	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
99	2568683	ЭБНЭ ХХК	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
100	5452503	Эм Эл цахиурт овоо ГХО ХХК	MV-018500	3/21/2019	ХАЗ-2019/01/22	-	11,607,770.1	-	№2021/05	
			MV-015610	2/4/2013	ХАЗ-2013/01/10	159,185.3	-	-	2017/11/23 №2017/02/30	
101	5155568	Эн И Си ХХК	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
102	2887746	Энержиресурс ХХК	MV-011952	9/12/2008	ХАЗ-2008/21/55	1,188,100.0	-	-	-	
103	5211859	Эрдэнийн босго ХХК	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
104	5072948	Эрдэнийн олз ГХО ХХК	MV-012297	10/21/2011	ХАЗ-2011/Н04/135	268,248.6	-	-	2017/04/21 №2017/02/20	
105	5190479	Эрдэнийн тал майнинг ХХК	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
106	5892295	Эрдэнэ Харвест ГХО ХХК	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
107	2718243	Эрдэнэмонгол ГХО ХХК	-	-	-	-	-	-	-	Нөхөн төлбөрийн тооцоолол хийлгэсэн. Төлбөр гараагүй
108	2550466	Эрдэнэс критикал минералс ТӨҮГ	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
109	5435528	Эрдэнэс Таван толгой ХК	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй
110	2074192	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	-	-	-	-	-	-	-	Гэрээ байгуулаагүй

Эх сурвалж: [АМГТГ](#)

4.4 ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРЫН ТОЙМ

4.4.1 Газрын тосны нөөц ба төрийн оролцоо

Газрын тос бол стратегийн нөөц гэж үздэг тул үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар дараах зүйлсийг 2027 он хүртэл баримтлах бодлого бичигт заасан байна.

Зорилго: Монгол Улсын газрын тосны салбарт эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх, нөөцийг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлэх, газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг тогтвортой хангах.

ЗГ-ын 2018 169 дүгээр тогтоолд:

- Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлэх;
- Газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Газрын тосны бүтээгдэхүүнээр хэрэглэгчийг тогтвортой хангах, чанарын хяналтын тогтолцоог сайжруулах;
- Салбарын хүний нөөц, ажиллах хүчийг бэлтгэх, мэргэшүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх;
- Газрын тосны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үед байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон хөгжил, орон нутгийн хөгжлийг дэмжих;
- Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулж хөгжүүлэх зэрэг асуудлыг тусгасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эдийн засгийг тэлэх 14 мега төслийг багтаасан бөгөөд тэдгээрийн нэг нь “Монгол Улсад Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл” юм. Уг төслийг дэд бүтцийн дараалал, барилга байгууламжийн төвөгшил, инженерчлэлийн ажилд зарцуулагдах хугацааг нарийвчлан тооцсоны үндсэн дээр **2028 онд** ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” (МГТБҮ) ТӨХХК-ийн төсөл нь стратегийн ач холбогдолтой бүтээн байгуулалт бөгөөд Монгол Улсын эдийн засгийн бүтцийг шинэчлэх, эрчим хүчний хараат бус байдлыг хангах, нефть-химийн салбарыг хөгжүүлэхэд чиглэсэн юм.

Хүснэгт 39. Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” (МГТБҮ) ТӨХХК-ийн төслийн хураангуй

ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР	
Байршил	Дорноговь аймгийн Алтанширээ сум
Төсөл баталсан шийдвэр, огноо	2024/08/27, УИХ-ын тогтоол №21
Эх үүсвэр, батладсан төсөв	БНЭУ-ын Эксим банк, Хөгжлийн банк, Эрдэнэс Тавантолгой ХК (1.9 тэрбум ам.доллар)
Хүрэх үр дүн	<ul style="list-style-type: none"> ✓ Ган, төмөрлөгийн үйлдвэрийн суурь түүхий эд, стратегийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл; ✓ Нефть-химийн аж үйлдвэрийн шинэ салбар, технологийн дэвшил; ✓ Шатахууны дотоодын хэрэгцээний 50-60 хувийг хангах; ✓ Жилд 1.5 сая тонн түүхий тосноос 1.3 сая тонн бүтээгдэхүүн гарган авна.

Эх сурвалж: <https://mongolrefinery.mn/>, <https://forum.mn/>

Газрын тосны нөөц: Монгол Улсын Ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд нийт баталгаат геологийн нөөц нь **335.6 сая тонн бүртгэгдсэнээс олборлох боломжтой буюу ашиглалтын нөөц нь 43.59 сая тонн** байна.


Хүснэгт 40. Монгол Улсын газрын тосны нөөцийн мэдээлэл, сая тонн

Төрөл	Бүртгэсэн огноо	Баталгаат нөөц	Ашиглалтын горим	Ашиглалтын баталгаат нөөц	Нийт олборлолт 1998-2025.06	Үлдэгдэл ашиглалтын нөөц
Тосон-Уул	2010.02.18, 2011.06.21	179.1	Байгалийн	20.17	6.22	13.95
Тамсаг	2012.05.16	127.5	Ус шахалт	21.02	4.24	16.78
Зүүнбаян, Цагаан-Элс	2011.06.08	26.05	Байгалийн	2.1	1.04	1.06
Цэн Тогоруу	2021.03.02	1.15	Байгалийн	0.14	-	0.14
Өлгий	2024.09.16	1.8	Байгалийн	0.16	-	0.16
Нийт		335.6		43.59	11.75	31.91

Эх сурвалж: <https://mrapam.gov.mn/>

Газрын тосны бүтээгдэхүүний сүүлийн 2 жилийн нөөцийг харьцуулан авч үзвэл Автобензин А-80 түлшний нөөц буурсан бол бусад нөөцийн үзүүлэлт өссөн дүнтэй байна.

График 10. Газрын тосны бүтээгдэхүүний үлдэгдэл нөөц төрлөөр (тонн), 2023-2024 он




Эх сурвалж: <https://mrapam.gov.mn/>

4.4.2 Газрын тосны хайгуул болон тусгай зөвшөөрөл (Шаардлага 2.2.а)

Газрын тосны эрлийн талбайнуудын хувьд уламжлалт газрын тосны 4 талбай, уламжлалт бус газрын тосны 7 талбайд /нүүрсний давхаргын метан хийн 6, шатдаг занарын 1/ **НИЙТ 11 талбайд эрлийн ажил гүйцэтгэж** байна.

Зураг 5. Газрын тосны эрэл, хайгуулын байршил



Эх сурвалж: <https://mrpam.gov.mn/>

Хуулийн шинэчлэлт:

Төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим систем www.tender.gov.mn/-ийн суурь бүтэц дээр нэмэлт хөгжүүлэлт хийлгэн 2022 оны 11 дүгээр сараас хойш 100.0 хувь цахим хэлбэрээр Ашигт малтмалын тухай хууль, Аж үйлдвэр, эрдэс баялгийн **сайдын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/102 дугаар тушаалаар** шинэчлэн баталсан, Сонгон шалгаруулалтын журамд заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулж байна.

Эх сурвалж: <https://legalinfo.mn/>

Тусгай зөвшөөрөл олгоход бүрдүүлэх материал. Үүнд:

1) ХАЙГУУЛ

- ✓ Бүтээгдэхүүн хуваах гэрээний хуулбар;
- ✓ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;
- ✓ Тухайн жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө;
- ✓ Байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны нэг хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулсан баримт болно.

2) АШИГЛАЛТ

- ✓ Газрын тосны нөөц бүртгэсэн тухай төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр;
- ✓ Тухайн жилд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл;
- ✓ Орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө;
- ✓ Ашиглалтын үеийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ;

- ✓ Эрх бүхий төрийн захиргааны байгууллагаас баталсан нэг загварын байр зүйн зураг дээр ашиглалтын талбайн булангийн цэгүүдийн солбицлыг градус, секундээр тодорхойлж тэмдэглэсэн зураг;
- ✓ Байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болгон тухайн жилийн хайгуулын ажлын хөрөнгө оруулалтын гурван хувь, ашиглалтын үед гэрээлэгчид ногдох ашигт газрын тосны нэг хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулсан баримт болно.

Эх сурвалж: <https://mmhi.gov.mn/>

4.4.3 Бүтээгдэхүүн хуваах гэрээ (Шаардлага 2.4)

Газрын тосны Бүтээгдэхүүн хуваах гэрээг **Газрын тосны хуулийн 7.1.8, 8.1.5, 9.1.2** дахь заалтын дагуу Засгийн газрын шийдвэрээр Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэрээ байгуулан, Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгодог.

Монгол Улсын хэмжээнд газрын тосны хэтийн төлөв бүхий хайгуулын **33 талбай ялгаснаас** өнөөдрийн байдлаар **28 талбайд 31 гэрээлэгч Засгийн газрын баталсан бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу ажиллаж** байна.

Нийт гэрээлэгчдээс БХГ-ний төлбөр, урамшуулал **1,753,579 ам.долларыг** Монгол Улсын орлогод, тухайн жилийн батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу **22,797,011 ам.долларыг** газрын тосны хайгуулын ажилд зарцуулж газрын тосны хайгуулын хөрөнгө оруулалт нийт **24,550,590 ам.доллар** болсон байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээт хайгуулын талбайнуудад 2023-2024 онуудад хийгдсэн ажлууд:

- ◆ **2023 онд:** Газрын тосны хайгуулын талбайд 2 цооног өрөмдөж, 547.5 км.кв 3 хэмжээст чичирхийллийн судалгааны ажил хийсэн байна.
 - *Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын талбайд хайгуул, үнэлгээ, туршилтын 41 цооног өрөмдөж, 260 т.км 2 хэмжээст чичирхийллийн судалгааны ажил хийсэн байна.*
- ◆ **2024 онд:** Газрын тосны хайгуулын талбайд 400 т.км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, 2 цооног өрөмдлөгийн ажил хийсэн байна.
 - *Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын талбайд хайгуул, үнэлгээ, туршилтын 13 цооног өрөмдөж, 107.8 т.км 2 хэмжээст чичирхийллийн судалгааны ажил хийсэн байна.*

Эх сурвалж: <https://mrpam.gov.mn/>


2024 онд шинээр БХГ болон эрлийн гэрээ хийгдээгүй бөгөөд одоогийн байдлаар БХГ-ийн **27 гэрээ ltodgeree.mn** сайтад байршсан байна. Гэрээний талаарх мэдээллийг сайтаас болон **2023 оны буюу 18 дугаар нэгтгэл тайлангаас** үзэх боломжтой байна.

4.4.4 Газрын тосны үйлдвэрлэл, эдийн засгийн үзүүлэлт

2024 онд газрын тосны экспортын хэмжээг 4,850.0 мянган баррель байхаар төлөвлөснөөс 4,074.1 мянган баррель биелсэн нь төлөвлөсний 84.0 хувьд хүрсэн байна.

Газрын тосны салбар улсын төсөвт төвлөрүүлсэн орлого **237,8 тэрбум төгрөг** болж Монгол Улсын **нэгдсэн төсвийн орлогын 0.7 хувийг** эзэлж байна.

Зураг 6. Газрын тосны экспортын төлөвлөгөө, гүйцэтгэл 2024 он



Эх сурвалж: <https://mmhi.gov.mn/>, <https://mrpam.gov.mn/>

Газрын тосны олборлолтын салбарын борлуулалт **167.8 тэрбум төгрөгөөр буюу 13.3 хувиар буурсан** байна.

Хүснэгт 41. Газрын тос, байгалийн хийн борлуулалтын мөнгөн дүн, 2023-2024 он

ГАЗРЫН ТҮҮХИЙ ТОС, БАЙГАЛИЙН ХИЙН БОРЛУУЛАЛТ	2023		2024			Өөрчлөлт	
	XII	I-XII	XII	I-XII	Гад-д	Тоо	%
	97.4	1,259.4	76.8	1,091.5	1,091.5	-167.8	-13.3%

Эх сурвалж: <https://mmhi.gov.mn/>


Харин газрын түүхий тос, байгалийн хий олборлолт **183.9 тэрбум төгрөг буюу 14.1 хувиар буурсан** байна.

Хүснэгт 42. Газрын тос, байгалийн хийн олборлолтын мөнгөн дүн, 2023-2024 он

ГАЗРЫН ТҮҮХИЙ ТОС, БАЙГАЛИЙН ХИЙН ОЛБОРЛОЛТ	2023		2024		Өөрчлөлт	
	XII	I-XII	XII	I-XII	Тоо	%
	100.4	1,305.9	87.8	1,122.1	-183.9	-14.1%

Эх сурвалж: <https://mmhi.gov.mn/>

График 11. Газрын тосны олборлолт (мянган баррель), 2021-2024 он




Эх сурвалж: <https://mrapam.gov.mn/>

◆ ЭКСПОРТ

2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр **322.1 сая ам.долларын 4,074.1 мян.бар** газрын тос экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 656.3 мян.бар буюу 13.9 хувь, үнийн дүнгээр 42.6 сая ам.доллар буюу 11.7 хувиар тус тус буурсан байна. Түүнчлэн газрын тосыг 100.0 хувь БНХАУ руу экспортолсон байна.

График 12. Газрын тосны экспорт (мянган баррель), 2021-2024 он



Эх сурвалж: <https://mmhi.gov.mn/>

◆ ИМПОРТ

- ✓ Эрдэс бүтээгдэхүүний импортын үнийн дүнгийн **88.4 хувийг газрын тосны бүтээгдэхүүн** эзэлж байна.
- ✓ 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр **2,162.0 сая ам.долларын 2,720.4 мян.тн** газрын тосны бүтээгдэхүүн импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр **418.1 мян.тн буюу 18.2 хувь, үнийн дүнгээр 293.4 сая ам.доллар буюу 15.7 хувиар** тус тус өссөн байна.
- ✓ Газрын тосны бүтээгдэхүүний импортын нийт үнийн дүнгийн **89.6 хувийг авто бензин, дизель түлшний импорт**, үүний 29.7 хувийг авто бензин, 59.9 хувийг дизель түлшний импорт тус тус эзэлж байна.
 - **Авто бензиний импорт:** 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 643.2 сая ам.долларын 897.5 мян.тн авто бензин импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 167.6 мян.тн буюу 23.0 хувиар, үнийн дүнгээр 120.7 сая ам.доллар буюу 23.1 хувиар тус тус өссөн байна.
 - **Дизель түлшний импорт:** 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1,296.0 сая ам.долларын 1,641.5 мян.тн дизелийн түлш импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 186.0 сая ам.доллар буюу 16.8 хувиар, биет хэмжээгээр 294.5 мян.тн буюу 21.9 хувиар тус тус өссөн байна.

4.4.5 Байгалийн хийн тойм

Австралийн хөрөнгийн биржид бүртгэлтэй гурван компани 2019 оноос хойш Монгол Улсад метан хийн хайгуул хийж, туршилтын цооног өрөмдөх ажлыг эхлүүлжээ. Ингэснээр манай улсад метан хийн нөөцийг тогтоож, тэрхүү нөөцийг ашиглах боломжийг тодорхой болгох юм.

Дэлхийн улс орнууд метан хийг эрчим хүч, дулаан, химийн салбарт түгээмэл ашиглаж, үр ашгийг нь хүртсээр байна. Хийн түлшийг эрчим хүчнийхээ салбарт хэрэглэснээр томоохон хотууд агаарын бохирдлоосоо салж чадсан түүх бий. Монгол Улс нүүрсний арвин нөөцтэй. Энэ нөөцөө түшиглэн нүүрсний давхаргын метан хий олборлох бүрэн боломжтой гэдгийг мэргэжилтнүүд хэлж байна.

Метан хийн цооног өрөмдлөгийн ажлыг Өмнөговь аймгийн сав газрыг түшиглэн нэр бүхий гурван компани гүйцэтгэж байгаа нь "Жи Өү Эйч", "Метан газ ресурс", "Тэлмэн ресурс" аж. Австралийн Засгийн газрын техникийн туслалцааны хүрээнд Монгол орны нүүрсний давхаргын метан хийн хэтийн төлөвийн судалгааг метан хийн чиглэлээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад дотоодын мэргэжилтнүүдээр хийлгэж, 7.4 триллион метр куб метан хийн баялаг байгааг тогтоосон байна.

4.5 ОЛБОРЛОХ САЛБАР ДАХЬ ТӨРИЙН ОРОЛЦОО (шаардлага 2.6, 4.5, 6.2)

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ын дагуу “Төрийн оролцоо”-той холбоотой мэдээлэл нь тайлангийн суурь бүрэлдэхүүн хэсгийн нэг бөгөөд төрийн өмчит болон төрийн оролцоотой компанийн хөрөнгө оруулалт, өмчлөл, орлого хуваарилалт, засаглалын ил тод байдлыг тодорхой харуулах зорилготой юм.

Энэхүү хэсэгт ОУИТБС-ын **шаардлага 2.6 — “Төрийн оролцоо”**, мөн түүнтэй уялдсан бусад шаардлагуудын хүрээнд тайланд тусгах ёстой бүх мэдээллийг бүрэн багтаасан болно.

Монгол улсын Олборлох салбар дахь ТӨААН-ийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг:

- I. **Нэгдүгээрт**, эдийн засгийн өсөлтийг дэмжих, тухайн зах зээлийн нийт нийлүүлэлт, бүтээмжид нөлөөлөх нөлөөг тодорхойлох;
- II. **Хоёрдугаарт**, төсвийн орлого бүрдүүлэлтэд гүйцэтгэх үүргийг тооцох;
- III. **Гуравдугаарт**, хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт нөлөөлж тогтворжуулах чиг үүргийн хүрээгээр хязгаарлаж шинжлэхээр арга зүйгээ боловсруулсан бөгөөд төрийн эдийн засагт гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлохын тулд төрийн өмчийн аж ахуйн нэгжийн эдийн засгийн харилцаанд оролцох нөхцөлийг зохицуулж буй эрх зүйн орчныг судлах шаардлагатай болсон.

2024 оны олборлох салбарын 19 дэх тайлангийн хүрээнд төрийн оролцоотой асуудлаар мэдээлэл бүрдүүлэх, баталгаажуулах үйл ажиллагаанд дараах төрийн байгууллагууд хамтран ажиллах, шаардлагатай мэдээллүүдийг нээлттэйгээр хуваалцахыг хүссэн ба оролцооны байдлыг доорх хүснэгтээр дүгнэн харууллаа.

Хүснэгт 43. Төрийн байгууллагуудын ОУИТБС-д оролцооны үнэлгээ

№	Байгууллагын нэр	Хангалттай	Дунд	Хангалтгүй	Шалтгаан
1	 Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ)		✓		
2	 АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ	✓			
3	 БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ (БОУАӨЯ)			✓	Мэдээлэл өгөөгүй
4	 ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ (ХНХЯ)			✓	Мэдээлэл өгөөгүй
5	 МОНГОЛЫН ГААЛЬ Гаалийн Ерөнхий Газар (ГЕГ)	✓			
6	 ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ			✓	Мэдээлэл өгөөгүй
7	 САНГИЙН ЯАМ	✓			
8	 Татварын Ерөнхий Газар (ТЕГ)		✓		
9	 ERDENES MONGOL GROUP Эрдэнэс Монгол ХХК	✓			

4.5.1 ЗГ болон ТӨААН-ийн олборлох салбарын компаниуд дахь эзэмшил, эзэмшилд гарсан өөрчлөлтийн шилжүүлгийн нөхцөл

Компанийн тухай хуулийн 2.6-д зааснаар төрийн өмчит компанийн хувьд өмчлөгч нь төрийг төлөөлөн **Монгол Улсын Их Хурал**, харин орон нутгийн өмчит компанийн хувьд **тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал** байна. Эдгээр өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх, хувьцаа эзэмшигчийн үүргийг биелүүлэх этгээд нь **Засгийн газар** болон **орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас эрх олгосон байгууллага, албан тушаалтан** байж болно.

ОУИТБС-ын Стандартын **2.6.a.ii** заалтад зааснаар ЗГ болон ТӨААН-ийн хувьд тухайн улсад үйл ажиллагаа явуулж буй **уул уурхай, газрын тос, байгалийн хийн компаниудад эзэмшиж буй хувь эзэмшлийн түвшинг ил тод мэдээлэх** үүрэгтэй. Энэхүү шаардлага нь ТӨААН-үүдийн **охин компани, салбар болон хамтарсан аж ахуйн нэгжүүдэд мөн хамаарна.**

Мөн тайлант хугацаанд төрийн өмчит болон төрийн оролцоотой компаниудын **өмчлөл, хувь эзэмшлийн бүтэц, түвшинд гарсан аливаа өөрчлөлтийг ил тод мэдээлэх** шаардлагатай байдаг.

Хүснэгт 44. ТӨААН-ийн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл

№	Компанийн нэр	Тусгай зөвшөөрлийн тоо	Ашигт малтмал	Хувьцаа эзэмшигчид	Хувь
1	Тавантолгой ХК	1	Нүүрс	Шандас импекс ХХК	16%
				Ажнай корпораци ХХК	20%
				Орон нутгийн өмч	51%
				Бусад	13%
2	Эрдэнэс Тавантолгой ХК	8	Нүүрс	Засгийн газар	85%
				ААН	1%
				Иргэд	15%
3	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	13	Зэс, дайрга	Засгийн газар	100%
4	Багануур ХК	3	Нүүрс, хайрга, элс	Засгийн газар	75%
				Монголиан нэшнл коал корпорэйшн	21%
				Бусад	4%
5	Эрдэнэс Критикал Минералс ТӨҮГ	28	Хайлуур жонш, төмөр, алт, хайрга, элс	Засгийн газар	100%
6	Цемент Шохой ХХК	2	Цемент, шохой, чулуунцар	-	-
7	Баянтээг ХК	1	-	-	-

“Эрдэнэс Монгол” ХХК 2024 онд олборлох салбарт үйл ажиллагаа явуулдаг **таван** компанийн **495.6 тэрбум** төгрөгийн ногдол ашиг хүлээн авч “Үндэсний баялгийн сан”-д төвлөрүүлсэн байна.

Эх сурвалж: “Эрдэнэс Монгол” ХХК

ТӨААН-ийн төрийн оролцоо, бодлогын өөрчлөлтүүд

Монгол Улсын Засгийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар дараах зарчмуудыг баримталдаг.

- Төрийн өмчит компаниудыг засаглал сайжруулах, ил тод болгох, олон нийтийн шууд хяналтад оруулах замаар нээлттэй хувьцаат компани болгох;
 - Төрийн оролцоог стратегийн салбар болон зах зээлд зайлшгүй шаардлагатай үйл ажиллагаанд хязгаарлах хэрэгтэй зэрэг чиглэлд анхаарч байна.
- ✓ 2023-2025 онд ашиггүй ажиллаж буй ТӨААН-үүдийг албан журмаар татан буулгах, бусадтай нэгтгэх ажлын хүрээнд **“Эрдэнэс Монгол” ХХК 42 ААН-ийг 31 болгож бууруулан** ажилласан байна.
- ✓ Төрийн өмчит компаниудын засаглал, үйл ажиллагааг сайжруулах ажлын суурийг зөв тавьж эрх зүйн орчныг бүрдүүлэх үүднээс нэгдлийн 15 компанийн дүрэм, бүтцийг шинэчилж, үр ашиггүй 6 компани, 2 төслийн нэгжийг татан буулгаж, 2 компанийг нэгтгэн нийт 3 тэрбум төгрөгийн зардал хэмнэж ажилласан.

Эх сурвалж: “Эрдэнэс Монгол” ХХК

4.5.2 Засгийн газар болон ТӨААН-ийн санхүүгийн харилцаа, гүйлгээ (Шаардлага 2.6, 4.2, 4.5)

ЗГ болон ТӨААН-ийн санхүүгийн харилцааг зохицуулсан үндсэн дүрэм журам:



ЗГ болон ТӨААН-үүдийн хоорондын харилцааг **Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хууль** болон **хуулийн дагалдах Төрийн өмчийг хэрэгжүүлэх журмуудаар** зохицуулдаг.

*Энэхүү хуульд тусгайлан заагаагүй бол ЗГ болон ТӨААН-үүдийн хоорондын харилцааг **Компанийн тухай хууль** болон **тухайн төрийн өмчит аж ахуйн нэгжийн Компанийн дүрмээр** зохицуулдаг.*



Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн **21.15-т** Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн **Засгийн газрын гишүүн нийт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүн, тэдгээрээс төсвийн байгууллагын санхүү болон мөнгөн хөрөнгийн гүйлгээнд нөлөөлөх байдал, ажлын үр дүнд хяналт тавина** гэж заасан.



Хуулийн **21.16-д** Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь **санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана.**

Гэхдээ тухайн санхүүгийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр богино хугацаанд авах зээл, үнэт цаасанд хамаарахгүй.



Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн **21 дүгээр зүйлийн 13 дугаар заалтад** Төрийн мэдлийн хувьцаа эзэмшигч нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс олгох **ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох саналыг төлөөлөн удирдах зөвлөлд бичгээр** гаргана.

*Харин **Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг хуваарилах өдөр зэргийг тогтооно гэж заасан байна.***



Төрийн болон орон нутгийн өмчийн тухай **хуулийн 9 дүгээр зүйлд** Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд дараах бүрэн эрхтэй гэж заасан. Үүнд:

- I. Төрийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;
- II. Төрийн өмчит хуулийн этгээдийн өөрт олгогдсон эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах хэмжээ, хязгаарыг энэ хуульд нийцүүлэн тогтоох;
- III. Төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдах, шилжүүлэх тухай шийдвэр гаргах;
- IV. Хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалтыг батлах;
- V. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;
- VI. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгөөс бусад өмчийн этгээдтэй хамтран хуулийн этгээд байгуулах, хөрөнгө оруулах, оруулсан хувь хөрөнгөө татан авах талаар тухайн хуулийн этгээдээс гаргасан саналыг хэлэлцэж шийдвэрлэх;

- VII. Хуульд заасан тохиолдолд бусдын өмчлөлийн зүйлийг төрийн өмчид дайчлан авах шийдвэр гаргах, нийгэмчлэх санал, төсөл боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;
- VIII. Төрийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн тооллогын дүн, төсвийн гүйцэтгэлийн тайланг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- IX. Төрийн өмчит хуулийн этгээдийн улсын ба орон нутгийн төсөвтэй харилцах хуваарийг тогтоох, өөрчлөх;
- X. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой банкны төрийн өмчид ногдох хэсгийг хувьчлах хөтөлбөр, банкин дахь төрийн өмчийн эд хөрөнгийг үнэлэх журмыг Монгол банктай зөвшилцөн батална.
- XI. Хуульд заасан бусад бүрэн эрх.

Дээрх хуулийн заалтад үндэслэн Засгийн газар тогтоол гарган Төрийн өмчит ААН-ийн санхүүгийн харилцааг зохицуулж байна.

Банкны мэдээллийн нууц болон ОУИТБС-ын тайлагнал:

Банкны тухай хуулийн 7.2-д зааснаар банк, түүний харилцагч болон гуравдагч этгээдийн нууц гэж үзсэн аливаа мэдээллийг 7.2.1–7.2.11-д дурдсанаас бусад тохиолдолд **банкны хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, хянан шалгах зөвлөл болон ажилтан** бусдад гаргаж өгөх, задруулах, ашиглахыг хориглоно. Эдгээр заалтуудад **ОУИТБС-ын тайлагналын зорилгоор мэдээллийг ил тод болгох зохицуулалт** тусгагдаагүй байна.

ТӨААН-ийн хоорондын гүйлгээ: (Шаардлага 4.5)

ОУИТБС стандартын шаардлага 4.5-н дагуу Олборлох компаниудын зүгээс ТӨААН-д хийсэн төлбөр, ТӨААН-ээс төрийн байгууллагууд, төрийн байгууллагаас ТӨААН хооронд хийгдсэн материаллаг төлбөрийг ил тод болгодог.

Шилэн дансны тухай хуулийн 6.4.5-р заалтын хүрээнд цалингийн зардлаас бусад **таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг ил тод болгох шаардлагатай** бөгөөд дараах хүснэгтэд гүйлгээг ил тод болгосон холбоосыг байршууллаа.

Хүснэгт 45. ТӨААН хоорондын гүйлгээний ил тод байдал

№	Компанийн нэр	Ил тод болгосон эсэх	Холбогдох линк
1	Тавантолгой ХК	үгүй	https://shilendans.gov.mn/organization/61990?ry=2024
2	Эрдэнэс тавантолгой ХК	тийм	https://shilendans.gov.mn/organization/53339?ry=2024
3	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	тийм	https://shilendans.gov.mn/organization/38753?ry=2024
4	Багануур ХК	тийм	https://shilendans.gov.mn/organization/24450?ry=2024
5	Эрдэнэс Критикал Минералс ТӨҮГ	тийм	https://shilendans.gov.mn/organization/27094?ry=2024
6	Цемент шохой ХХК	тийм	https://shilendans.gov.mn/organization/52497?ry=2024
7	Баянтээг ХК	тийм	https://shilendans.gov.mn/organization/27756?ry=2024

4.5.3 ТӨААН-д санхүүгийн тайлангаа олон нийтэд ил тод болгосон байдал (Шаардлага 2.6.b)

ОУИТБС-н шаардлага 2.6.b-н дагуу компаниуд санхүүгийн тайлангаа ил тод болгох ёстой бөгөөд нэгтгэл тайланд хамрагдсан ТӨААН-үүдийн санхүүгийн тайлангаа аудит хийлгэсэн болон ил тод болгосон эсэхийг дараах хүснэгтээс үзнэ үү.

Хүснэгт 46. ТӨААН-үүдийн тайлангийн стандарт хангалт, ил тод байдал

Компанийн нэр	ТӨААН нь санхүүгийн тайлан бэлтгэдэг эсэх	Санхүүгийн тайлан аудитлагдсан эсэх	НББ-ийн Олон улсын стандартын дагуу тайланг бэлтгэсэн эсэх	Олон улсын стандартын дагуу аудитласан эсэх	ТӨААН-ийн тайланг олон нийтэд ил тод болгосон эсэх
Тавантолгой ХК	тийм	-	-	-	үгүй
Эрдэнэс таван толгой ХК	тийм	тийм	тийм	тийм	тийм
Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ	тийм	тийм	тийм	тийм	тийм
Багануур ХК	тийм	тийм	тийм	тийм	тийм
Эрдэнэс Критикал Минералс ТӨҮГ	тийм	тийм	тийм	тийм	тийм
Цемент шохой ХХК	тийм	тийм	тийм	тийм	тийм
Баянтээг ХК	тийм	тийм	тийм	тийм	тийм

I. ТӨААН-ийн санхүүгийн тайлан:

Төрийн аудитад хууль дээдлэх, хараат бус, бие даасан байх, шударга ёсыг хангах, мэдээллээр бүрэн хангагдах, ил тод, бодитой байх, төрийн аудитын олон улсын нийтлэг стандартад нийцсэн байх зэрэг зарчмыг баримтална. ОУИТБС-ын Стандартын шаардлагаар ТӨААН-үүд нь өөрийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан эсвэл санхүүгийн тайлан боломжгүй бол санхүүгийн гол үзүүлэлтүүдийг олон нийтэд ил тод болгохыг шаардсан байдаг. Нэгтгэлд хамрагдсан 9 ТӨААН-ээс санхүүгийн тайлангаа шилэн данс болон өөрийн цахим хуудсанд ил тод болгосон байдлыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 47. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайлангийн ил тод байдал

Компанийн нэр	Шилэн данс	Компанийн цахим хуудас
Тавантолгой ХК	үгүй	үгүй
Эрдэнэс таван толгой ХК	тийм	тийм
Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ	тийм	үгүй
Багануур ХК	тийм	тийм
Эрдэнэс Критикал Минералс ТӨҮГ	тийм	үгүй
Цемент шохой ХХК	тийм	үгүй
Баянтээг ХК	тийм	үгүй

II. ТӨААН-ийн аудитын тайлан:**ТӨААН-ийн аудитын тайланг ил тод болгох хууль дүрэм, журам**

Төрийн аудитын тухай хууль нь аудитын тайланг цахим хуудсаараа ил тод болгохыг шаарддаг бөгөөд үндсэн зорилт нь төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг хууль ёсны дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад хяналт тавих, түүнчлэн төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Төрийн аудитын тухай хуульд **2024 оны 01 сарын 12-ны өдөр** дараах өөрчлөлтүүд оржээ.

- ◆ **1 дүгээр зүйл.** Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 дэх заалтын "бичгээр" гэсний дараа ", **эсхүл цахим хэлбэрээр**" гэж нэмсүгэй.
- ◆ **2 дугаар зүйл.** Аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн "бичгээр гэрээ байгуулна. Гэрээ нь үйлчлүүлэгч ба аудитын хуулийн этгээдийн эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарсан өдрөөс хүчин төгөлдөр болно." гэснийг "**бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гэрээ байгуулна. Бичгээр байгуулах гэрээ нь үйлчлүүлэгч ба аудитын хуулийн этгээдийн эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарсан өдрөөс хүчин төгөлдөр болох бөгөөд цахим хэлбэрээр байгуулах гэрээнд цахим гарын үсэг хэрэглэнэ.**" гэж өөрчилсүгэй.

ТӨААН-үүдийн аудитын тайланг ил тод болгох хууль дүрэм, журмын практик хэрэгжилт

Үндэсний Аудитын Газрын цахим хуудсанд 2019 оноос хойш ТӨААН-ийн аудитын тайлан ороогүй байна. Нэгтгэлд хамрагдсан 12 ТӨААН-ийн 9 нь шилэн дансны цахим хуудсанд аудитын тайлангаа оруулсан байна.

Хүснэгт 48. ТӨААН-үүд аудитын тайлангаа ил тод болгосон эсэх

Компанийн нэр	ТАБ-ын цахим хуудас	Шилэн данс	Холбогдох линк (ТАБ)
Тавантолгой ХК	үгүй	үгүй	
Эрдэнэс таван толгой ХК	үгүй	тийм	
Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ	тийм	тийм	https://audit.mn/audit/report_detail/39907
Багануур ХК	үгүй	тийм	
Эрдэнэс Критикал Минералс ТӨҮГ	үгүй	тийм	
Цемент шохой ХК	тийм	тийм	https://audit.mn/audit/report_detail/37793
Баянтээг ХК	тийм	тийм	https://audit.mn/audit/report_detail/36292

4.5.4 ТӨААН-ийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалт, худалдан авалт болон засаглалын зохицуулалт (ОУИТБС Шаардлага 2.6.с)

Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа:

Компанийн тухай хуулийн 16.1-т Компанийн дүрэм нь түүнийг үүсгэн байгуулах үндсэн бичиг баримт юм. Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана. Үүнд:

- ◆ Компанийн бүрэн болон товчилсон оноосон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ;
- ◆ Компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;
- ◆ Компанийн дүрмээр давуу эрхийн хувьцааг зарласан нөхцөлд давуу эрхийн хувьцааны зарласан тоо, түүний эзэмшигчийн эрх;
- ◆ Хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо;
- ◆ Хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн энэ хуулиар тодорхойлсноос бусад бүрэн эрх;
- ◆ Компанийн үйл ажиллагааны чиглэл;
- ◆ Компанийн дүрэмд тусгахаар энэ хуульд заасан бусад зүйл.

Мөн энэ заалтад “Ахмадын сан” байгуулах, мөнгөн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай зүйлийг **2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар** нэмсэн бөгөөд **2025 оны 01 дүгээр**

сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр баталсан байна.
<https://baganuurbine.mn>

Хүснэгт 49. ТӨААН-ийн компанийн дотоод дүрэм, журам ил тод болгосон байдал

Компанийн нэр	Ил тод болгосон эсэх	Холбогдох линк
Тавантолгой ХК	тийм	https://www.tavantolgoi.mn/rules-and-regulations
Эрдэнэс таван толгой ХК	тийм	https://ett.mn/mn/files-by-category/10
Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ	тийм	https://www.erdenetmc.mn/legal
Багануур ХК	тийм	https://baganuurbine.mn
Эрдэнэс Критикал Минералс ТӨҮГ	тийм	https://www.ecmm.mn/as/transparency/22
Цемент шохой ХК	тийм	https://khutulcement.mn/
Баянтээг ХК	үгүй	

ТӨААН-ийн хөрөнгийн зарцуулалтын удирдлагад (үйл ажиллагаа /урсгал/ болон хөрөнгө оруулалтын) хамаарах дүрэм журам, практик үйл ажиллагаа:

ТӨААН-ийн хөрөнгийн зарцуулалтын удирдлага нь Шилэн дансны тухай хууль, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар зохицуулагдана. Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 4 дүгээр зүйл буюу шилэн дансанд төрийн өмчийн хуулийн этгээд, үйлдвэрийн газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компанийн тавих мэдээллийг тодорхойлсон байдаг бөгөөд энэхүү журам 2016 оны 29 дүгээр тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан байна.

Хүснэгт 50. ТӨААН-ийн худалдан авалтын ил тод байдалд хамааралтай хууль, тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлт

ХУУЛЬ	ОГНОО	НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ
Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай	2024 оны 01 сарын 12 өдөр	1 дүгээр зүйл. Шилэн дансны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн "бичгээр" гэсний дараа ", эсхүл цахим хэлбэрээр" гэж нэмсүгэй.

ХУУЛЬ	ОГНОО	НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ
Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2024 оны 01 сарын 12 өдөр	<p>1 дүгээр зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.21 дэх заалтын "суралцаж байгаа" гэсний өмнө "суралцсан болон" гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн "хүсэлтийг бичгээр" гэсний дараа, 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсгийн, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн "бичгээр" гэсний дараа ", эсхүл цахим хэлбэрээр" гэж тус тус нэмсүгэй.</p> <p>2 дугаар зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:</p> <p>3 дугаар зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсгийн "цахим хуудсандаа" гэснийг "бүрэн бүтэн, үнэн зөв байдлыг хангаж цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд" гэж, 8 дугаар зүйлийн 8.10 дахь хэсгийн "цахим хуудсандаа" гэснийг "цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд" гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн "амаар болон бичгээр" гэснийг "амаар, эсхүл бичгээр, эсхүл цахим хэлбэрээр" гэж, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн "ганина" гэснийг "таньж, баталгаажуулна. Тус системээр таньж, баталгаажуулсан мэдээллийг хүн, хуулийн этгээдээс цаасан хэлбэрээр шаардахгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд мэдээлэл хариуцагч цахим хэлбэрээр бүрдүүлнэ." гэж тус тус өөрчилсүгэй.</p> <p>4 дүгээр зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.</p>
Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай	2024 оны 06 сарын 05	<p>1 дүгээр зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай 29.4, 29.5 дахь хэсэг нэмсүгэй:</p> <p>"29.4.Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө энэ хуулийн 29.5-д заасан ангилалд хамаарах системд техник, эдийн засгийн үндэслэлийг хийлгэж ирүүлнэ. 29.5.Техник, эдийн засгийн үндэслэл хийлгэх шаардлагатай нийтийн мэдээллийн системийн ангиллыг цахим хөгжил, харилцаа холбооны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран тогтооно."</p> <p>2 дугаар зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн "нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө" гэсний өмнө "энэ хуулийн 29.4-т зааснаас бусад" гэж нэмсүгэй.</p>

Эх сурвалж: <https://legalinfo.mn/>

ТӨААН-ийн хөрөнгийн зарцуулалтын удирдлагын практик үйл ажиллагаа:

Тайланд хамрагдсан ТӨААН нь хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалтыг шилэн дансны портал сайтад байршуулан олон нийтэд ил тод мэдээлж байна.

Хүснэгт 51. Шилэн дансанд ил тод болгосон эсэх

Компанийн нэр	Ил тод болгосон эсэх	Холбогдох линк
Тавантолгой ХК	үгүй	
Эрдэнэс таван толгой ХК	тийм	https://shilendans.gov.mn/organization/53339?ry=2024&group=5&rfor=103478&rf=1310&rm=1
Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ	тийм	https://shilendans.gov.mn/organization/38753?ry=2024&group=5&rfor=74596&rf=1310&rm=1
Багануур ХК	тийм	https://shilendans.gov.mn/organization/24450?ry=2024&group=5&rfor=207931&rf=1310&rm=1

Компанийн нэр	Ил тод болгосон эсэх	Холбогдох линк
Эрдэнэс Критикал Минералс ТӨҮГ	тийм	https://shilendans.gov.mn/organization/27094?ry=2024&group=5&rfor=63286&rf=1310&rm=1
Цемент шохой ХК	тийм	https://shilendans.gov.mn/organization/52497?ry=2024&rfor=107790&rf=1310&rm=1
Баянтээг ХК	тийм	https://shilendans.gov.mn/organization/65653?ry=2024&group=5&rfor=242163&rf=1310&rm=1

ТӨААН-ийн худалдан авалтад хамаарах дүрэм журам, практик үйл ажиллагаа:

ТӨААН-д Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу худалдан авалтыг явуулна. ТӨААН-үүд уг хуульд нийцүүлэн дотооддоо худалдан авалтын дүрэм журам батлан мөрддөг. Шилэн дансны тухай хуулиар:

- ✓ Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (Хуулийн 6.1.1 заалтын хүрээнд),
- ✓ Худалдан авах ажиллагааны тайлан (Хуулийн 6.1.1, 6.1.2 заалтын хүрээнд)
- ✓ Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг тухай бүр /хэрэв байгаа бол/
- ✓ Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг (Хуулийн 6.3.6, 6.4.3, 6.8.2 заалтын хүрээнд) тухай бүр ил болгох шаардлагатай.

Хүснэгт 52. Худалдан авалтын ил тод байдал

Компанийн нэр	Төлөвлөгөө	Тайлан	Холбогдох линк
Тавантолгой ХК	тийм	тийм	https://shilendans.gov.mn/organization/61990?ry=2024&group=122&rfor=197943&rf=1354&rm=12
Эрдэнэс таван толгой ХК	тийм	тийм	https://shilendans.gov.mn/organization/53339?ry=2024&group=5&rfor=103441&rf=1354&rm=12
Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ	тийм	тийм	https://shilendans.gov.mn/organization/38753?ry=2024&group=5&rfor=74587&rf=1354&rm=12
Багануур ХК	тийм	үгүй	https://shilendans.gov.mn/organization/24450?ry=2024&group=5&rfor=244887&rf=1354&rm=12
Эрдэнэс Критикал Минералс ТӨҮГ	тийм	тийм	https://shilendans.gov.mn/organization/27094?ry=2024&group=5&rfor=70449&rf=1354&rm=12
Цемент шохой ХК	тийм	тийм	https://shilendans.gov.mn/organization/52497?ry=2024&rfor=107724&rf=1354&rm=12
Баянтээг ХК	тийм	тийм	https://shilendans.gov.mn/organization/65653?ry=2024&group=5&rfor=184736&rf=1354&rm=12

Компанийн засаглалтай холбоотой дүрэм журам болон практик үйл ажиллагаа:

- ◆ Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 108 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан "Эрдэнэс Монгол" ХХК-ийн **дүрэмд Төлөөлөн удирдах зөвлөлийг төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч 6 гишүүн, хараат бус 5 гишүүн, нийт 11 гишүүнтэй байхаар тусгасан.** 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит хурлын 3 дугаар тогтоолоор шинээр сонгогдсон төрийн төлөөллийн 6 гишүүн, хараат бус 5 гишүүн, нийт 11 гишүүнтэйгээр Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагаагаа явуулж байна.
- ◆ ТУЗ нь доороо ТУЗ-ын ажлын алба, ажлын алба болон Аудит, эрсдэлийн удирдлагын хороо, засаглал нэр дэвшүүлэх хороо, цалин урамшуулал, гүйцэтгэлийн хороо, эрсдэлийн удирдлагын хороо гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.
- ◆ "Эрдэнэс Монгол" нэгдлийн бүрэлдэхүүн компани, харьяа хуулийн этгээдийг үйл ажиллагааны чиглэлээр нь бүлэглэж, Зэс металлын группэд 5, Түлш, эрчим хүчний группэд 6 аж ахуйн нэгж, Дэд бүтэц, логистикийн группэд 5 компани харьяалагдаж, нийт 15 охин компани, хараат төслийн нэгж тус тус харьяалагдан ажиллаж байна. 15 компани 1 төслийн нэгж тус тус харьяалагдан ажиллаж байна.

4.5.5 Төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөрүүд

ОУИТБС-ын стандартын шаардлагын дагуу төсвийн хөрөнгийн зарцуулалттай адил төстэй төлбөрт төрийн өмчит аж ахуйн нэгжүүд хүлээн зөвшөөрсөн нийгмийн хөрөнгө оруулалт, тухайлбал нийгмийн үйлчилгээ, нийтийн дэд бүтэц, түлшний татаас, засгийн газрын өрийн төлбөр гэх мэт улсын төсвөөс гадуурх зардлууд ордог. Эдгээр зардлуудыг шилэн дансны цахим хуудаснаас үзэх боломжтой бөгөөд холбогдох линкийг доорх хүснэгтэд оруулав.

Хүснэгт 53. ТӨААН-ийн шилэн дансны мэдээлэл

№	Компанийн нэр	Холбогдох линк
1	Тавантолгой ХК	https://shilendans.gov.mn/organization/61990?ry=2024
2	Эрдэнэс тавантолгой ХК	https://shilendans.gov.mn/organization/53339?ry=2024
3	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	https://shilendans.gov.mn/organization/38753?ry=2024
4	Багануур ХК	https://shilendans.gov.mn/organization/24450?ry=2024
5	Эрдэнэс Критикал Минералс ТӨҮГ	https://shilendans.gov.mn/organization/27094?ry=2024
6	Цемент шохой ХХК	https://shilendans.gov.mn/organization/52497?ry=2024
7	Баянтээг ХК	https://shilendans.gov.mn/organization/27756?ry=2024

4.6 ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ БОЛОН ОРЛОГЫН ХУВААРИЛАЛТ

4.6.1 Орлогын хуваарилалт

Сангийн яамны ирүүлсэн мэдээгээр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль болон тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн дагалдах хуулиудад олборлох салбарын хүрээнд хууль тогтоомжийн өөрчлөлт ороогүй байна.

Монгол улсын сангийн яамны ирүүлсэн мэдээгээр олборлох салбартай холбоотой 2024 онд дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

Хүснэгт 54. 2024 оны төсвийн үйл явцын шинэчлэлт

Шаардлага	Өөрчлөлтүүд
<p>Шаардлага 2.1</p> <p>Төсвийн бодлого, 2024 оны төсвийн бодлоготой холбоотой хууль тогтоомжийн өөрчлөлт</p>	<p>Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль болон тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн дагалдах хуулиудад олборлох салбарын хүрээнд дараах бодлогын арга хэмжээг баталж, хэрэгжүүлж байна.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Ашигт малтмал баяжуулах, боловсруулах, нэмүү өртөг шингэсэн ашигт малтмалын баяжмал, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжийн нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг 4 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх зохицуулалтыг оруулсан. <p>Тус зохицуулалт нь Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дугаар зүйлийн 40.6 дахь заалтад туссан бөгөөд 2027 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хүртэл хэрэгжихээр байна.</p>

	Шаардлага	Өөрчлөлтүүд
Шаардлага 5.2	Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16.2-д заасан төсвийн тогтворжуулалтын сангийн эх үүсвэрүүдийг татан төвлөрүүлсэн байдал	Төсвийн тогтворжуулалтын санд 2024 онд 443.9 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн байна.
	Төсвийн орлогын хуваарилалтын зарчим, орон нутгийн хуваарилалтын орлого хуваах тогтолцоо томъёо	Орон нутгийн төсвийн орлогыг тухайн аймгийн онцлогийг харгалзан, орон нутгаас ирүүлсэн санал болон ИТХ-аар тогтоосон хувь хэмжээг тус тус харгалзан тооцдог тул нэгдсэн томъёогоор тооцох боломжгүй юм.
Шаардлага 5.3	Орлого, төсвийн тооцооллын тодотгол	2024 оны батлагдсан төсөвт олон улсын зах зээл дээрх цэвэр зэсийн үнийг тонн тутамд 9,500.0 ам.доллар , нүүрсний үнийг дунджаар тонн тутамд 115.0 ам.доллароор тооцсон. Зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 182.5 ам.доллар байхаар тооцсон болно.
	2024 онд авралын санхүүжилт, идэвхжүүлэх багц, олборлох салбарт, эсхүл төрийн өмчит компанид үзүүлсэн татаасын мэдээлэл	Олборлох салбарт болон тухайн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчит компанид ямар нэг хэлбэрээр татаас олгоогүй болно.
	2024 онд Ирээдүйн өв сангийн хөрөнгийг онцгой нөхцөлд ашигласан эсэх талаарх мэдээлэл	Ирээдүйн өв сангаас 2024 онд ямар нэг зарцуулалт хийгдээгүй болно.

Эх сурвалж: *Монгол Улсын Сангийн Яам*

2024 онд олборлох салбарт шинээр олгосон нийт зээл улсын байгууллагын хувьд 352.7 тэрбум төгрөг бол хувийн байгууллагын хувьд 5,724.1 тэрбум төгрөг байна. Харин төлөгдсөн зээлийн хувьд улсын байгууллага 69.8 тэрбум төгрөг, хувийн байгууллага 4,746.4 тэрбум төгрөг тус тус төлж улсын байгууллагын салбарын нийт зээлийн үлдэгдэл 329.2 тэрбум төгрөг, хувийн байгууллагууд 4,353.1 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Монгол банкны “Улсын байгууллагын зээл” хэмээх ангилал нь улсын төсвийн байгууллагыг бус, харин **олборлох салбарт үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчит аж ахуйн нэгж, үйлдвэрийн газар, компаниудын** зээлүүдийг илэрхийлдэг. Ийм зээлүүд нь улсын төсвөөс шууд санхүүждэггүй бөгөөд **дотоодын банк, санхүүгийн байгууллага болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас арилжааны эсвэл хөнгөлөлттэй нөхцөлөөр** авсан зээлүүд байдаг. Харин “хувийн байгууллагын зээл” нь **олборлох салбарт үйл ажиллагаа эрхэлдэг хувийн өмчит компаниуд, гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд, хувьцаат болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрийн аж ахуйн нэгжүүдэд** олгосон арилжааны зээлүүдийг багтаадаг байна.

Хүснэгт 55. Олборлох салбарын зээллэгийн өөрчлөлтийн мэдээлэл, тэрбум төгрөгөөр

САЛБАР	ОЛГОСОН ЗЭЭЛ		ТӨЛӨГДСӨН ЗЭЭЛ		Зээлийн үлдэгдэл	
	НИЙТ	ТӨГРӨГИЙН	НИЙТ	ТӨГРӨГИЙН		
УЛСЫН БАЙГУУЛЛАГ	Уул уурхай, олборлолт	301.46	28.82	26.40	26.40	313.98
	Боловсруулах үйлдвэрлэл	3.69	3.69	0.95	0.95	3.53
	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	44.60	44.60	39.45	39.45	11.67

САЛБАР		ОЛГОСОН ЗЭЭЛ		ТӨЛӨГДСӨН ЗЭЭЛ		Зээлийн үлдэгдэл
		НИЙТ	ТӨГРӨГИЙН	НИЙТ	ТӨГРӨГИЙН	
	Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	2.96	2.96	2.96	2.96	-
	НИЙТ	352.72	80.08	69.76	69.76	329.17
ХУВИЙН БАЙГУУЛЛАГА	Уул уурхай, олборлолт	3,213.81	2,652.41	2,319.86	2,077.45	2,114.84
	Боловсруулах үйлдвэрлэл	2,351.23	2,113.90	2,318.00	2,100.30	2,067.45
	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	137.92	87.93	86.81	81.23	157.05
	Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	21.19	21.19	21.69	21.69	13.78
	НИЙТ	5,724.14	4,875.43	4,746.36	4,280.67	4,353.11

Эх сурвалж: <https://stat.mongolbank.mn/>

4.6.2 Орон нутгийн төлбөрүүд болон төсөвт төвлөрүүлж бүртгээгүй тохиолдол (Шаардлага 4.6 болон шаардлага 5.1)

Сангийн яамны мэдээллээр 2024 оны төсөвт дараах 15 аймаг батлагдаж санхүүгийн дэмжлэг олгогдсон байна.

Орон нутгийн хөгжлийн сан бол иргэдийн саналаар шийдэж зарцуулах төсөв юм. Тус сан нь засаг захиргааны нэгжүүд өөрсдийн хэрэгцээнд суурилсан хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүд болон бие даан хэрэгжүүлэх ёстой чиг үүргүүдээ санхүүжүүлэх боломж бүрдүүлдгээрээ давуу талтай.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан (ОНХНС)-ийн эх үүсвэрийг дотоодын НӨАТ, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлого, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл зэрэг төсвийн орлогын тодорхой хувиар тооцож бүрдүүлдэг.

Хүснэгт 56. Монгол улсын 2024 оны төсөвт аймгуудад олгохоор батлагдсан санхүүгийн дэмжлэгийн дүн /сая.төг/

№	Аймгийн нэр	Санхүүгийн дэмжлэг
1	Архангай	33,831.9
2	Баян-Өлгий	22,080.6
3	Баянхонгор	34,182.5
4	Булган	10,232.3
5	Говь-Алтай	26,065.0
6	Дундговь	18,195.6
7	Завхан	37,581.9
8	Өвөрхангай	27,680.8
9	Сүхбаатар	13,917.6

№	Аймгийн нэр	Санхүүгийн дэмжлэг
10	Төв	16,840.6
11	Увс	30,877.0
12	Ховд	12,982.1
13	Хөвсгөл	37,957.8
14	Хэнтий	38,777.6
15	Говьсүмбэр	6,836.4
НИЙТ		368,039.7

Эх сурвалж: Монгол Улсын Сангийн Яам

Хүснэгт 57. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд олгох 2024 оны орлогын шилжүүлгийн батлагдсан дүн /сая.төг/

№	Аймгийн нэр	ОНХНС-с ОНХС-д олгох орлогын шилжүүлэг			ОНХНС-с ОНХС-д олгох орлогын шилжүүлэг		Аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн нийт дүн
		ГТНАТ-н 30%	АМНАТ-н 10%	ЖГҮ	АМХТЗ-н 100%	АМАТЗ-н 50%	
1	Архангай	333.5	11,683.9	554.8	0.7	118.0	12,690.9
2	Баян-Өлгий	320.7	11,094.2	235.2	137.4	162.0	11,949.5
3	Баянхонгор	432.9	18,645.3	1,028.5	24.4	1,445.9	21,577.0
4	Булган	298.3	12,755.2	658.9	98.6	417.5	14,228.5
5	Говь-Алтай	451.7	15,621.4	92.9	435.9	755.4	17,357.3
6	Дорноговь	2,313.8	35,417.2	2,444.7	536.6	1,995.8	42,708.1
7	Дорнод	2,336.7	20,009.5	2,133.7	378.9	563.2	25,422.0
8	Дундговь	315.4	12,948.3	972.3	494.1	1,150.3	15,880.4
9	Завхан	355.7	13,468.6	562.4	82.2	231.9	14,700.8
10	Өвөрхангай	355.6	12,777.3	1,075.6	79.7	192.5	14,480.7
11	Өмнөговь	558.9	43,035.2	1,165.1	235.8	2,721.1	47,716.1
12	Сүхбаатар	352.0	15,075.2	2,096.0	275.1	417.4	18,215.7
13	Сэлэнгэ	307.0	25,014.2	1,932.8	28.5	485.9	27,768.4
14	Төв	356.6	24,481.5	2,218.7	179.8	1,130.2	28,366.8
15	Увс	348.1	12,089.5	365.6	75.4	190.4	13,069.0
16	Ховд	354.0	26,904.6	1,807.4	67.5	251.7	29,385.2
17	Хөвсгөл	442.5	15,297.0	937.0	0.4	62.2	16,739.1
18	Хэнтий	352.4	16,219.1	1,279.4	282.2	454.1	18,587.2
19	Дархан-Уул	253.8	18,772.0	1,671.1	0.7	65.7	20,763.3
20	Улаанбаатар	1,394.2	48,735.1	-	-	37.7	50,167.0
21	Орхон	251.3	32,402.1	1,947.5	2.0	107.4	34,710.3
22	Говьсүмбэр	168.6	6,035.0	642.7	12.5	141.5	7,000.3
НИЙТ		12,653.7	448,481.4	25,822.3	3,428.4	13,097.8	503,483.6

Эх сурвалж: Монгол Улсын Сангийн Яам

4.6.3 Орлогын менежмент ба зарцуулалт (Шаардлага 4.1 болон шаардлага 4.7)

Энэхүү тайланд хамрагдах төлбөр, орлогын мэдээллийг компани, төрийн байгууллагууд болон орлогын урсгал, төсөл нэг бүрээр дэлгэрүүлэн тайлагнасан ба төслийн төвшнөөр мөн задалж харуулсан. Төслийн түвшнээр харуулсан дэлгэрэнгүйг Хавсралт 21-с үзнэ үү.

ОҮИТБС-ын стандартад төсөл гэж юу болохыг тодорхойлсон ба стандартад өөрчлөлт орох болсон шалтгаан нь ЗГ төсөл тус бүрээс хэдий хэмжээний орлого авч байгаа талаар ил тод

болгох, заавал ил тод болгох дүрэмд төсөл бүрээр, ОУИТБС-ын зөвлөл нь 2018 он болон түүнээс цааш орлогыг төслөөр нь задлан харуулах шаардлагыг 2017 онд баталсан.

МОУИТБС-ын ОТАХ төсөл, харилцан холбоотой гэрээг дараах байдлаар тодорхойлжээ.

- ✓ Төсөл нь нэг гэрээ, лиценз, концесс эсвэл ижил төстэй эрх зүйн багц гэрээ хэлэлцээрээр зохицуулагдан, төртэй хамаарах төлбөрийн үүрэг хариуцлагын үндсийг бүрдүүлж буй үйл ажиллагааг ойлгоно.
- ✓ Харилцан холбоотой гэрээ нь үйл ажиллагаа болон газар зүйн хувьд уялдаатай гэрээ, лиценз, концесс эсвэл ижил төстэй эрх зүйн багц гэрээ хэлэлцээрүүд эсвэл ЗГ-тай байгуулж, төлбөрийн үүргийг тусгасан, агуулгын хувьд ижил нөхцөл бүхий хамаарах гэрээнүүдийг хэлнэ. Ийм төрлийн гэрээ хэлэлцээрийг нэг гэрээ, хамтарсан аж ахуйн нэгж, бүтээгдэхүүн хуваах гэрээ эсвэл бусад нийтлэг зохицуулах эрх зүйн гэрээ зэргээр ерөнхийлөн зохицуулсан байна.

2024 онд цахим тайлангийн системд **51 компани төслийн түвшний мэдээллийг тайлагнасан бөгөөд 51 төрлийн төсөл 52,352,358,985.50 төгрөгийн хөрөнгө** оруулалтын гүйцэтгэлтэйгээр хэрэгжиж буй үзүүлэлттэй байна.

Төслийн түвшний талаар дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 21-ээс харна уу

ОУИТБС-ын шаардлага 4.1 болон 4.7 Олборлох үйлдвэрлэлээс хүлээн авсан татвар, орлогыг иж бүрнээр нэг талаас ил тод болгох, төсөл бүрээр задлах шаардлагын дагуу Татварын ерөнхий газраас улсын төсвийн тайлант жилийн төлөвлөгөө болон бодитоор хүлээн авсан орлогын харьцуулалтыг ирүүлсэн байна.

Хүснэгт 58. 2024 оны гүйцэтгэл

Улсын төсөв	Гүйцэтгэл
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	3,700,143,708,370.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	222,513,396,293.6
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	4,009,937,673,119.4
Нүүрсний агаарын бохирдлын төлбөр	79,122,005,272.9
Нийт	5,087,876,750,413.8

Эх сурвалж: МУ-ын Татварын Ерөнхий Газар

Системтэйгээр ил тод болгосон байдал:

Олборлох салбараас олсон орлогыг төвлөрүүлж буй сангуудын орлого, зардал, үйл ажиллагааны тухай мэдээллийг ил тод болгох (Шаардлага 5.3.а) шаардлагын дагуу улсын төсөв, аудитын үйл ажиллагааны тухай тайлбар болон төсөв боловсруулах, зарцуулах, төслийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн тухай олон нийт дараах сувгуудаас нээлттэй мэдээлэл авч болно.

Зураг 7. Улсын төсөв, аудитын үйл ажиллагааны нээлттэй мэдээлэл

www.mof.gov.mn

- Сангийн яамны үндсэн цахим хуудас бөгөөд яамны бүтэц, бодлого, чиглэл, төсвийн талаарх мэдээ, мэдээлэл

www.iltod.gov.mn

- Төсвийн тухай цаг үеийн мэдээ, мэдээлэл, жил бүрийн төсвийн мэдээлэл, төсвийн холбогдолтой хууль, тогтоол, заавар журам

www.shilendans.gov.mn

- Бүх төсвийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газруудын төсөв, түүний зарцуулалтын талаарх мэдээ мэдээлэл

www.tusuv-oronnutag.mof.gov.mn

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдийн мэдээлэл

<https://publicinvestment.gov.mn> “Төсвийн хөрөнгө оруулалт” аппликэйшн

- Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үйл ажиллагааны онлайн веб хуудас болон гар утасны “Төсвийн хөрөнгө оруулалт” аппликэйшин

www.e-balance.mof.gov.mn

- Аж ахуйн тайлангийн нэгдсэн систем бөгөөд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой заавар, тушаал зөвлөгөө

www.audit.mn

- Аудитын төлөвлөгөө, тайлан, зөвлөмж

www.tender.gov.mn

- Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем

www.1212.mn

- Үндэсний статистикийн хорооны мэдээллийн нэгдсэн сан

www.worldbank.org/mn/country/mongolia

- Дэлхийн банкны Монгол Улсын талаар мэдээлэл бүхий цахим хуудас

www.imf.org/en/Countries/ResRep/MNG

- Олон улсын валютын сангийн Монгол Улсын талаар мэдээлэл бүхий цахим хуудас

www.adb.org/countries/mongolia/main

- Азийн хөгжлийн банкны Монгол Улсын талаар мэдээлэл бүхий цахим хуудас

www.internationalbudget.org

- Интернэйшнэл Баджет Партнершип ТББ-ын цахим хуудас

https://forum.mn/sudalgaa?category_id=14227

- Нээлттэй нийгэм форумын цахим сангийн Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлоготой холбоотой мэдээллийн сан

<https://budgetwatch.mn/>

- Иргэд төсвөө хянана Иргэний нийгмийн эвслийн цахим хуудас

БУСАД АСУУДАЛ



ТАВДУГААР
БҮЛЭГ

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД АСУУДАЛ

5.1 ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧ, ТҮҮНИЙ ИЛ ТОД БАЙДАЛ (шаардлага 2.5)

- **Эцсийн өмчлөгчид** гэдэг нь аливаа компанийг жинхэнэ эзэмшдэг, удирддаг, эсвэл түүнээс ашиг хүртдэг хүмүүсийг хэлэх ба хууль ёсны хувьцаа эзэмшигчид болон компанийг төлөөлж ажиллаж байгаа албан тушаалтнуудаас ялгаатай юм.
- **Эцсийн өмчлөгч** нь тухайн компанид заавал хувь эзэмшсэн байх шаардлагагүй бөгөөд компанийн шийдвэр гаргалтад оролцож, нөлөөлж, нарийн төвөгтэй өмчлөлийн бүтцийн ард нуугдаж, шууд болон шууд бусаар ашиг хүртэж байдаг.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын олон улсын стандартаар 2020 оны 1 дүгээр сарын 1 гэхэд эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч, тендерт оролцогч компаниудын ашиг хүртэгч эцсийн эзнийг олон нийтэд нээлттэй болгох, холбогдох бүртгэлийн сантай байхыг хэрэгжүүлэгч улс орнууддаа шаардлага болгосон. Үүнээс шалтгаалан эцсийн өмчлөгчийн талаар ОУИТБС-ын Олон улсын хорооноос дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

Хүснэгт 59. ОУИТБС-ын Олон улсын хорооноос хэрэгжүүлсэн эцсийн өмчлөгчийн арга хэмжээ

ОН/САР	АВСАН АРГА ХЭМЖЭЭ
2013 оны 5-р сар	➤ ЭӨ-ийн бүртгэлийг тайлагнахыг шаардах болсон.
2013 оны 10-р сар	➤ ОУИТБС-ын 11 орон ЭӨ-ийн туршилтын төслийг хэрэгжүүлсэн
2016 оны 1-р сар	➤ ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч 29 орон тодорхой хэмжээнд хэрэгжүүлж байна. 9 орон тайландаа энэ мэдээллийг оруулж байна.
2016 оны 2-р сар	➤ ОУИТБС-ын шинэ стандартаар 2020 оны 1-р сарын 1 гэхэд ЭӨ-ийг ил тод болгохыг шаардсан.
2023 он	➤ ОУИТБС-аар ЭӨ-ын асуулгын маягыг шинэчлэх санаачилгаа дэвшүүлж, загвар маягт гаргасан.

2023 онд нийт 795 аж ахуй нэгж эцсийн өмчлөгчийн мэдээллээ тайлагнасан бол энэ жилийн хувьд **14.2 хувиар буурсан үзүүлэлттэй** байна. Тайлант онд ОУИТБС-ын цахим тайлангийн системд нийт 452 аж ахуйн нэгжийн эцсийн өмчлөгчийн мэдээлэл бүртгэгдсэн бөгөөд үүнээс 88 хувь буюу 404 нь хувь хүний түвшинд тайлагнасан байна. Мөн хувь хүний түвшинд авч үзэхэд улс төрд нөлөө бүхий 8 эцсийн өмчлөгч байна.

Олборлох салбарт үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын эцсийн өмчлөгч эздийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 19(б,в)-д харуулсан.

Хүснэгт 60. Тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн эцсийн өмчлөгч

№	Улс орон	Иргэншил	Улс төрд нөлөө бүхий этгээд мөн эсэх	Энэ компанид удирдах албан тушаал хашдаг эсэх
1	Австрали	5	0	3
2	Англи	4	0	0
3	БНХАУ	58	0	32
4	Монгол	297	8	182
5	Сингапур	2	0	1
6	Хонг Конг	2	0	0
7	Япон	3	0	0
8	Бусад	33	0	21
Нийт		404	8	239

Эх сурвалж: <https://ereports.eitimongolia.mn/>

ОУИТБС-ын цахим тайлангийн системд бүртгэгдсэн эцсийн өмчлөгчийн мэдээллийг хуулийн этгээдээр 12 хувь нь буюу 48 аж ахуйн нэгж тайлагнасан байлаа.

Хүснэгт 61. ОУИТБС-ын цахим тайлангийн системд бүртгээгдсэн эцсийн өмчлөгчид

№	Компани	Регистр	Бүртгэлтэй хөрөнгийн бирж	Бүртгэлтэй улс
2024 оны нэгтгэл тайланд орсон компаниуд				
1	Багануур ХК	2008572	Монгол	Монгол
2	Бадрах энерги ХХК	5502977	Арева Монгол ХХК	Монгол
			Мон-Атом ХХК	Монгол
			Компани Француз Де Мин Э Мето САС	Франц
			Орано Майнинг С.А.С.	Франц
			Орано СА	Франц
			Эрдэнэс Монгол ХХК	Монгол
3	Бороогоулд ГХО ХХК	2094533	Канадын хөрөнгийн бирж	Канад
4	Их говь энерги ХХК	5522935	Монголын хөрөнгийн бирж	Монгол
5	Монцемент билдинг материалс ХХК	5106567	-	Монгол
6	ОНТРЭ ГХО ХХК	2705133	Торонто	Канад
7	Оюутолгой ГХО ХХК	2657457	Лондоны хөрөнгийн бирж	ИБУИНВУ
			Австралийн хөрөнгийн бирж	Австрали
8	Саусгоби сэндс ГХО ХХК	5084555	Торонтогийн хөрөнгийн бирж	Канад
			Хонг Конгын хөрөнгийн бирж	БНХАУ
9	Си Эм Кэй Ай ГХО ХХК	5288703	БНСУ	БНСУ
10	Тавантолгой ХК	2016656	Монгол	Монгол
11	Тефисмайннинг ХХК	2807459	ТӨХ II	Монгол
12	Тэн Хун ГХО ХХК	2839717	Монгол	Монгол
13	Хунт-Өгөөж ХХК	2166631	-	Сейшелийн Бүгд Найрамдах Улс
14	Хунт-Өгөөж ХХК	2166631	УБЕГ	Монгол
15	Цүй ханг инвест ГХО ХХК	6342485	Хонг Конг	БНХАУ, Хонг Конг
16	Цэгээн-Үүдэн ХХК	2831686	Бүртгэлгүй	Монгол
17	Шарын гол ХК	2050374	Монголын хөрөнгийн бирж	Монгол
17	Эрдэнэмонгол ГХО ХХК	2718243	Хонг Конгын хөрөнгийн бирж	Хонг Конг
			Торонтогийн хөрөнгийн бирж	Канад
Бусад				
18	Их баян төмөртэй	5221056	Монгол	Монгол
19	Лидер эксплорэйшн	6183077	Торонтогийн хөрөнгийн бирж	Канад
20	Дү руй зи юан майнинг	8376115	-	Монгол
21	Анианресорсиз	2874229	Торонтогийн хөрөнгийн бирж	Канад
22	Хуабэй куане	5586887	Хонг Конг	Хонг Конг
23	Болдфоарда	5095638	-	БНХАУ
24	Эрдэнэс баянбогд	6896197	Улаанбаатар хотын хөгжлийн корпорац	Монгол
25	Хөх талст майнинг	6853366	-	Монгол
26	Баянтэгш импекс	2609436	-	-
27	Ханшашир	2618176	Вэйдү/ Хонг Конг/ ХК	БНХАУ
28	Баяраам	2578077	-	Монгол
29	Их уулын эрдэнэс	5286808	Хонг Конг	Британийн виржиний арлууд улс
30	Модунресурсэс	5508606	Сингапур	Сингапур
31	Ханбогд эксплорэйшн	2715694	Керри Групп Лимитэд	Күүкийн арлууд болон Кайман арлууд

№	Компани	Регистр	Бүртгэлтэй хөрөнгийн бирж	Бүртгэлтэй улс
32	Бумбат	2075652	Мандал Ресурс ХХК	Монгол
33	Хунг юун	6492584	-	БНХАУ
34	Кайнарвольфрам	2844001	Хонг Конг	Британийн виржини арлууд улс
35	Прокуб	5864259	-	-
36	Агитхангай	2597977	-	Монгол
37	Гурвантамга	2091798	Гурвантамга ХХК	Монгол
38	Алтайголд	2877694	-	Монгол
39	АУМ алт	3555763	-	Монгол
40	Эгэмайнинг	5568005	Монкон групп ХХК	Монгол
41	Жунхаовэйеэ	5039681	-	БНХАУ
42	Вестерн монголиан девелопмент	2888696	Керри Групп Лимитэд	Күүкийн арлууд болон Кайман арлууд
43	Гангархаш	5003105	-	Монгол
44	Түмэн ерөөлт	5980178	Түмэн анд майнинг ГХО ХХК	Монгол
45	Миндуотайди	5082986	Монголын Вольфрамын аж үйлдвэрийн групп ХХК	БНХАУ
46	Ловонко	5084024	БАЙЛИТУ	Монгол
47	МОЭНКО	5141583	Хонг Конгын хөрөнгийн бирж	Бермуд
48	Эф Ви Эс Пи	5137977	Хонг Конгын Хөрөнгийн Бирж ХХК	Хонг Конг

Эх сурвалж: <https://ereports.eitimonqolia.mn/>

Мөн Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар 2019 оны 3-р сараас эхлэн эцсийн өмчлөгчдийн талаар зарим мэдээллийг <http://opendata.burtgel.gov.mn> сайтад төвлөрүүлж эхэлсэн бөгөөд уг сайтад одоогийн байдлаар буюу 2025 оны 10 дугаар сарын байдлаар нийт 271,044 хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, бүртгэгдсэн огноо, компанийн хэлбэр (ХХК), компанийн төрөл (ашиг, ашгийн бус), үйл ажиллагааны чиглэл, үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, гишүүний тоо, удирдлагын овог, нэр, албан ёсны хаяг болон үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчдийн талаар мэдээллүүд байна.

5.2 ГЭРЭЭНИЙ ИЛ ТОД БАЙДАЛ

Нээлттэй нийгэм Форум (ННФ), Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам (АҮЭБЯ) болон Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын (ОУИТБС) Ажлын алба хамтран www.iltodgereee.mn сайтыг байгуулсан. Уг санд ашигт малтмал, газрын тос, байгалийн хий, цацраг идэвхт болон түгээмэл тархацтай ашигт малтмал гэх мэт байгалийн баялгийг ашиглахтай холбоотой **Хөрөнгө оруулалтын болон Бүтээгдэхүүн хуваах гэрээ, Концессын гэрээ, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс орон нутгийн захиргаатай байгуулдаг Орон нутгийн гэрээ зэрэг** Монгол улсын эрдэс баялгийн салбарт байгуулагддаг гэрээнүүдийн эх бичвэрийг байршуулдаг. Олборлох салбарт хамаараалтай ил тод байршиж буй хууль эрх зүйн үндсэн заалтуудын жагсаалтыг доор харууллаа.


Хүснэгт 62. Гэрээ, түүний ил тод байдалд холбогдох зүйл заалт

№	Хууль тогтоомжийн нэр	Холбогдох зүйл заалт	Холбоос
Хууль			
1	Монгол Улсын Үндсэн хууль	6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.17 дахь хэсэг	http://legalinfo.mn/law/details/367?lawid=367
2	Ашигт малтмалын тухай хууль	5 дугаар зүйлийн 5.3-5.5 дахь хэсэг, 42 дугаар зүйл	http://legalinfo.mn/law/details/63?lawid=63

№	Хууль тогтоомжийн нэр	Холбогдох зүйл заалт	Холбоос
3	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль	40 дүгээр зүйл	http://legalinfo.mn/law/details/9750?lawid=9750
4	Газрын тосны тухай хууль	12,13,14, 17 дугаар зүйл	http://legalinfo.mn/law/details/10484?lawid=10484
5	Цөмийн энергийн тухай хууль	4 дүгээр бүлэг 29-31 дүгээр зүйл	http://legalinfo.mn/law/details/97?lawid=97
6	Хөрөнгө оруулалтын тухай хууль	20 дугаар зүйл	http://legalinfo.mn/law/details/9491?lawid=9491
7	Концессын тухай хууль		http://legalinfo.mn/law/details/312?lawid=312
8	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	2 дугаар зүйлийн 2.2 дахь заалт, 3 ба 4 дүгээр зүйл.	http://legalinfo.mn/law/details/224?lawid=224
9	Захиргааны ерөнхий хууль	11 , 26-28 дугаар зүйл	http://legalinfo.mn/law/details/11259?lawid=11259
10	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль	бүхэлдээ	http://legalinfo.mn/law/details/374?lawid=374
11	Байгууллагын нууцын тухай хууль	4 ба 6 дугаар зүйл	http://legalinfo.mn/law/details/102?lawid=102
Төрийн бодлого			
12	Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого	3.1.7 ба 3.5.2 дахь заалт	http://legalinfo.mn/law/details/9756?lawid=9756
13	Шилэн дансны тухай хууль	6 дугаар зүйлийн 6.4.8, 6.5.9-6.5.10, 7.1.1 дэх заалт	http://legalinfo.mn/law/details/10497?lawid=10497
Дүрэм журам			
14	Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах журам	бүхэлдээ	http://legalinfo.mn/annex/details/6226?lawid=9803
УИХ-ын тогтоол			
15	Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай		http://legalinfo.mn/law/details/6405?lawid=6405
16	Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай		http://legalinfo.mn/law/details/6631?lawid=6631
17	“Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай” тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		http://legalinfo.mn/law/details/10318?lawid=10318
18	Гацууртын ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээ тогтоох тухай		http://legalinfo.mn/law/details/11651?lawid=11651
Засгийн газрын тогтоол			
19	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай	7 ба 8 дахь заалт	http://legalinfo.mn/law/details/8791?lawid=8791
20	Таван толгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай		http://legalinfo.mn/law/details/10568?lawid=10568

Сүүлийн 4 жилийн хугацаанд ил тод байдлын санаачилгын мэдээллийн санд байршуулсан гэрээний тоо дунджаар 14 хувиар нэмэгдсэн байгаа нь харагдаж байна.

График 13. Мэдээллийн санд байршуулсан гэрээний тоо



Эх сурвалж: <https://www.iltodgeree.mn/>

2025 оны 10-р сарын 01-ний байдлаар энэхүү мэдээллийн санд бүртгэгдсэн 1,363 гэрээний мэдээллийг байршуулсан байна. Мэдээллийн санд байршуулсан нийт гэрээний жагсаалтыг Хавсралт 36-аас үзнэ үү.

Хүснэгт 63. Мэдээллийн санд байршуулсан гэрээ

№	ГЭРЭЭНИЙ ТӨРӨЛ	ТОО
1	Орон нутагтай хамтран ажиллах гэрээ	393
2	Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээ	442
3	Газар ашиглах тухай гэрээ	130
4	Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн гэрээ	64
5	Ус ашиглах тухай гэрээ	88
6	Ашиглалтын өмнөх гэрээ	53
7	Бүтээгдэхүүн хуваах гэрээ	26
8	Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн дагуу хийгдэх гэрээ	23
9	Газрын тосны эрлийн гэрээ	12
10	Орд ашиглах гэрээ	11
11	Тогтвортой байдлын гэрээ	11
12	Бусад	47
13	Концессын гэрээ	4
14	Хөрөнгө оруулалтын гэрээ	8
15	Гэрээний хавсралт	7
16	Бүтээн байгуулалтын гэрээ	7
17	Төрийн өмчит уул уурхайн компанийн худалдан авалтын гэрээ	2
18	Үйлчилгээний гэрээ	3
19	Хамтын ажиллагааны санамж бичиг	4
20	Тодорхойгүй	28
НИЙТ		1,363

Эх сурвалж: <https://www.iltodgeree.mn/>

5.3 ДЭД БҮТЦЭД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ БА БАРТЕРЫН СОЛИЛЦОО (шаардлага 4.3)

Зарим тохиолдолд улс орны байгалийн нөөц баялгийг ашиглах эрх олох зорилгоор олборлох үйлдвэрлэлийн компаниуд мөнгөн бус хэлбэрээр бараа болон үйлчилгээ үзүүлэх (дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх) гэрээг төрийн байгууллагуудтай хийдэг. Эдгээр дэд бүтцийн хөрөнгө оруулалтын жишээнд зам, төмөр зам, цахилгаан станц, сургууль болон эмнэлгүүд багтана.

Тухайн компаниудад ирэх өгөөж нь газрын тос, байгалийн хий эсвэл ашигт малтмалын нөөц бөгөөд газар, эрчим хүч болон усны нөөц ашиглах эрх гэх мэт бусад элементээс бүрддэг. Ийм гэрээг бартерын солилцооны гэрээ эсвэл **“дэд бүтцийг ашигт малтмалаар солилцох гэрээ”** гэж нэрлэдэг.

2024 онд сонгогдсон 110 аж ахуйн нэгж, байгууллагын хүрээнд дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалт ба бартерын солилцооны талаар **6 компани 26 удаагийн 100 сая төгрөгөөс дээш дүнтэй дэд бүтцийн хөрөнгө оруулалт** хийсэн байна.

Дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалт болон бартерын солилцооны талаар дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 33-аас харна уу.

5.4 ТЭЭВЭРЛЭЛТИЙН ОРЛОГО (шаардлага 4.4)

Газрын тос, байгалийн хий, байгалийн баялгийн тээвэрлэлтээс олсон орлого нь материаллаг байгаа үед ЗГ болон Төрийн өмчит аж ахуйн нэгж (ТӨААН)-үүд хүлээн авсан орлогоо толилуулах шаардлагатай байдаг.

ААН-үүдийн тээвэрлэлтийн орлогын мэдээллийг орлого хүлээн авсан аж ахуй нэгжээр дараах хүснэгтэд харуулав. Сонгогдсон 110 аж ахуйн нэгж байгууллагаас **цахим тайлангийн системд тээвэрлэлтийн орлогын мэдээллээ тайлагнасан 6 компани байсан бөгөөд нийт тээвэрлэлтийн орлого 679,552,339,506 төгрөг** байна. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой ААН-үүдийн төлсөн тээвэрлэлтийн төлбөрийн дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 35-аас үзнэ үү.

Хүснэгт 64. ААН-үүдийн тээвэрлэлтийн өндөр орлого хүлээн авсан ТОП 12 компани

№	Тээврийн орлогыг хүлээн авсан аж ахуйн нэгж	Ашигт малтмалын төрөл	Тээвэрлэлтийн хэмжээ /мян.тн/	Хүлээн авсан тээвэрлэлтийн орлого /сая.төгрөг/
1	УБТЗ ХНН	Зэсийн баяжмал	566.9	37,431.8
2	Нормаунт ХХК	Нүүрс	431.1	32,486.7
3	Баян Өгий Зэгст ХХК	Нүүрс	562.2	29,243.7
4	Хонгорбээс транс ХХК	Нүүрс	588.3	21,172.5
5	Кингланд	Баяжмал	271.6	19,595.9
6	Баян Нуур Хөсөг ХХК	Нүүрс	525.7	18,091.5
7	Их Даваа Уул ХХК	Нүүрс	519.2	17,090.6
8	Тэнгэр Анд Тэнгис ХХК	Нүүрс	859.7	16,256.3
9	Мөнгөн Хүлэг Сервис ХХК	Нүүрс	362.3	15,608.6
10	Ээлийн Цагаан Харгуй ХХК	Нүүрс	398.4	14,254.6
11	Баян Ундарга Ложистик ХХК	Нүүрс	261.4	13,495.2
12	Вв Транс ХХК	Нүүрс	387.2	12,872.3

Эх сурвалж: <https://ereports.eitimonqolia.mn/>

Хүснэгт 65. Авто тээвэрээр тээвэрлэсэн экспортын ачааны мэдээ, өссөн дүнгээр

Боомтын нэр	Ачааны нэр төрөл	2022 он		2023 он		2024 он	
		Тээврийн тоо	Жин /тонн/	Тээврийн тоо	Жин /тонн/	Тээврийн тоо	Жин /тонн/
Гашуун-сухайт	Нийт экспорт	150,485	19,491	266,259	36,750	331,317	38,733
	Нүүрс	137,897	18,990	250,564	36,123		
	Зэсийн баяжмал	12,588	501	15,695	628		
Шивээхүрэн	Нийт экспорт	35,810	5,369	151,021	19,107	198,651	24,562
	Нүүрс	35,810	5,369	151,021	19,107		
Замын-Үүд	Нийт экспорт	30,364	550	6,829	696	13,695	864
	Нүүрс	1,303	90	1,789	125		
	Хүдэр	65	1	-	-		
	Жонш	-	-	-	-		
Ханги	Нийт экспорт	41,529	3,051	65,713	5,006	85,714	8,679
	Нүүрс	40,842	3,000	65,604	4,998		
	Төмрийн хүдэр	604	45	-	-		
	Жонш	83	6	109	8		
Бичигт	Нийт экспорт	1,788	112	38,159	2,766	47,894	4,267
	Нүүрс	1,788	112	38,159	2,766		
Бургастай	Нийт экспорт	15,494	866	4,807	206	14,765	631
	Төмрийн хүдэр	15,494	866	4,807	206		
Баянхошуу	Нийт экспорт	9,608	346	16,232	528	13,784	457
	Газрын тос	9,608	346	16,165	525		
	Нүүрс	-	-	67	4		
Боршоо	Нийт экспорт	1,345	1	1,387	-	2,158	-
	Бусад ачаа	1,345	1	1,387	-		
Булган	Нийт экспорт	30,360	2,211	34,526	2,714	48,696	3,537
	Нүүрс	30,360	2,211	34,526	2,714		
Алтанбулаг	Нийт экспорт	11,718	9	11,277	54	13,484	56
	Бусад ачаа	11,718	9	11,277	54		
Цагааннуур	Нийт экспорт	8,022	0	12,769	90	20,082	-
	Бусад ачаа	8,022	0	12,769	90		
Хавирга	Нийт экспорт	-	-	3,069	320	2,243	291
	Нүүрс	-	-	3,069	320		
	Цайрын баяжмал	-	-	-	-		
Сүмбэр	Нийт экспорт	-	-	76	1	-	-
	Төмрийн хүдэр	-	-	76	1	-	-

Эх сурвалж: Зам тээвэр, хөгжлийн яам

2024 онд төмөр замаар тээвэрлэсэн экспортын ачааны хэмжээ 11.0 сая тонн байна.

Хүснэгт 66. Төмөр замаар тээвэрлэсэн экспортын ачааны мэдээ, өссөн дүнгээр

Үзүүлэлт		2022 он		2023 он		2024 он	
		Вагон тоо	Жин /мян.тн/	Вагон тоо	Жин /мян.тн/	Вагон тоо	Жин /мян.тн/
Төмөр замын экспортын ачаа		462,465.0	8,642.5	592,837.0	11,129.2	303,785.0	6,423.2
ОХУ	Алтанбулаг боомт	114,108	220.3	161,017	212.1	84,649	92.1
БНХ АУ	Замын-Үүд боомт	348,357	8,422.2	431,820	10,917.1	219,136	5,373.8
	Нүүрс	25,810	505.2	18,187	1,207.0	19,221	238.4

Үзүүлэлт		2022 он		2023 он		2024 он	
		Вагон тоо	Жин /мян.тн/	Вагон тоо	Жин /мян.тн/	Вагон тоо	Жин /мян.тн/
	Төмрийн хүдэр, түүний баяжмал	55,710	3,925.9	73,868	5,200.9	34,898	2,433.5
	Зэс, молибдены баяжмал	10,698	711.5	4,135	275.4	275	302.2
	Нефть, нефтийн бүтээгдэхүүн	5,630	342.2	7,594	454.3	4,697	285.2
	Жонш, жоншны баяжмал	5,834	391.9	2,644	177.3	4	0.3
	Мөнгөний хүдэр	1,641	104.5	131	5.8	153	8.8
	Цайр	2,271	141.4	1,044	67.1	467	30.2

Эх сурвалж: Зам тээвэр, хөгжлийн яам

Нийт экспортын ачаа 2024 онд экспортын ачаа **11.6 сая тонн болж өмнөх оноос 4.3%-аар** нэмэгдсэн байна.

Хүснэгт 67. Нийт экспортын ачааны мэдээ, өссөн дүнгээр

Үзүүлэлт	2022 он		2023 он		2024 он	
	Тээврийн тоо	Жин /мян.тн/	Тээврийн тоо	Жин /мян.тн/	Тээврийн тоо	Жин /мян.тн/
Нийт экспортын ачаа	798,988	40,647.4	1,204,961	79,374.1	794,821	93,700

Эх сурвалж: Зам тээвэр, хөгжлийн яам

Хэвлэн нийтэлсэн мэдээлэл нь өөр бусад орлогын урсгал, төлбөрийн урсгалын нэгэн адил хэмжээнд задаргаатай байх шаардлагатай (4.7) Олон талт оролцогчдын бүлэг нь тээвэрлэлтийн орлогын тухай мэдээллийн чанар, дээр заасан мэдээллийн баталгаажуулалттай холбоотой журмыг Шаардлага 4.9 дээр заасны дагуу гарган, хэрэгжүүлэх үүргийг хүлээнэ. Санаачилгыг хэрэгжүүлэгч орнууд нь дараах мэдээллийг ил болгоно. Үүнд:

- ✓ Тээвэрлэлтийн зохион байгуулалтын талаарх мэдээлэл, үүнд тээвэрлэж буй бүтээгдэхүүн, тээвэрлэлтийн маршрут, тээвэрлэлтэд оролцож буй компани болон төрийн байгууллага (төрийн өмчит аж ахуйн нэгж мөн хамаарна);
- ✓ Тээвэрлэлтийн татвар, тариф, бусад төлбөр, болон тэдгээрийг тооцох аргачлалын тухай тайлбар;
- ✓ Тарифын хувь хэмжээ болон тээвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээг ил тод болгон тайлагнах;
- ✓ Газрын тос, байгалийн хий болон ашигт малтмалын тээвэрлэлтээс төрийн байгууллага болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн хүлээн авсан орлогыг ил тод болгон тайлагнах.

5.5 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ (шаардлага 6.4)

Монгол Улсад уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн асуудлын зохицуулалтыг Аж үйлдвэр эрдэс, баялгийн яам (АҮЭБЯ) болон тус яамны харьяа Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ), Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам (БОУАӨЯ), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ) зэрэг үндсэн 3 байгууллага хариуцдаг.

- ✓ Уул уурхайн салбар байгаль орчинд хамгийн их доройтол учруулдаг, байгалийн нөхөн сэргээгдэхгүй баялгийг ашигладаг. Монголын ард түмний уламжлалт нүүдлийн мал аж ахуйд сөрөг нөлөө үзүүлдэг. Ийм учраас уул уурхайн байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн ажилд дагаж мөрдөх хууль, журам, стандартыг боловсруулах, хэрэгжүүлэх, баталгаажуулах, хэрэгжилтийг хангах ажилд байгаль

орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байнга анхаарал хандуулж, ажиллаж ирсэн.

- Сонгогдсон 110 аж ахуйн нэгж байгууллагаас **цахим тайлангийн системд 2024 онд техникийн нөхөн сэргээлт 459.21 га, биологийн нөхөн сэргээлтийг 383.56 га талбайд** хийсэн байна.
- 2024 онд нийт **12 аймгийн 595 газар 7760.69 га талбай эвдрэлд өртсөн байна**. Үүнээс уул уурхайн олборлолтоос үүдэн **163 газар 5,404.3 га талбай эвдрэлд орсон** байна.

- ✓ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын эрх олгох тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу олгож байна. 2024 онд газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын эрх бүхий **ААН-үүд нийт техникийн нөхөн сэргээлт 655.9 га талбайд, биологийн нөхөн сэргээлт 486.7 га талбайд** хийсэн байна.


Хүснэгт 68. Газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын эрх олгосон аж ахуйн нэгжүүдийн 2024 оны нэгтгэл

№	ААН-н нэр	Эрх авсан огноо	Эрх олгосон шийдвэрийн дугаар	Эрх дусах огноо
1	Монголын тандан судлаачдын холбоо ТББ	2024-04-29	БОАЖ-ын сайдын 2024.04.29-ний өдрийн А/244 дүгээр тушаал	2029-04-29
2	Өлзий энвайронментал ХХК	2024-04-29	БОАЖ-ын сайдын 2024.04.29-ний өдрийн А/244 дүгээр тушаал	2029-04-29
3	Арвин ачит ХХК	2024-04-29	БОАЖ-ын сайдын 2024.04.29-ний өдрийн А/244 дүгээр тушаал	2029-04-29
4	Тавинлан ХХК	2024-04-29	БОАЖ-ын сайдын 2024.04.29-ний өдрийн А/244 дүгээр тушаал	2029-04-29
5	Эко эрин тохижилт ХХК	2024-04-16	БОАЖ-ын сайдын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/210 дугаар тушаал	2029-04-16
6	ЭБЭГ ХХК	2024-04-16	БОАЖ-ын сайдын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/210 дугаар тушаал	2029-04-16

Эх сурвалж: <https://eic.mn/>

Төрийн сангийн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд 2007 оноос хойш нийтдээ 390 орчим аж ахуй нэгж байгууллагын 47.7 тэрбум төгрөг байршсан байна. 2023 оны эцэст тус данс нь 32.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол 2024 оны эцэст 43.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй болж 11.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн нь өмнөх оноос 31.0 хувиар өссөн дүн байна. Харин тухайн онд тус данснаас зарлага гараагүй байна. Дансны үлдэгдлийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй дараах холбоосоор орж танилцана уу. [Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгаа | МЕСС](#)

График 14. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны үлдэгдэл



Эх сурвалж: БОУАӨЯ

2024 онд ОУИТБС-ын стандартын **шаардлага 6.1-ийн** дагуу нөхөн сэргээлтийн мэдээллийг цахим тайлангийн маягтаар нэгтгэсэн ба дэлгэрэнгүй байдлаар **нийт 55 компани нөхөн сэргээлтийн мэдээлэл оруулсан**. Компаниудын ирүүлсэн нөхөн сэргээлтийн мэдээллээр тусгай дансанд **3,579,204,108 төгрөг төвлөрүүлсэн** байна.

Уг төлбөрийн мэдээлэл болон нөхөн сэргээлт хийсэн талбайн мэдээллийг тайлангийн Хавсралт 22-оос үзнэ үү.

Байгаль орчны нөхөн сэргээлтийн хүрээнд БОУАӨЯ-аас 2024 оны байдлаар **нийт 21 аймгийн 63 сумын, Улаанбаатар хотын 4 дүүрэгт 145 аж ахуйн нэгж 973.22 га талбай ашиглаж, 518.70 га-д** нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг Байгаль орчны статистикийн мэдээллийн сан (eic.mn) холбоосоор авах боломжтой.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон менежментийн төлөвлөгөө:

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ нь хүний эрүүл мэнд, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалах эрхийг хангах зорилгоор байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүйгээр байгалийн нөөцийг ашиглах, үйлдвэр, үйлчилгээ эрхлэх, салбарын хүрээнд баримтлах бодлого болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг урьдчилан тогтоох зорилготой.

Уул уурхайн салбар нь **“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”** 2012-иас ихээхэн хамааралтай. Уг хуулийн дагуу аливаа уул уурхайн төслийг хэрэгжүүлж

эхлэхийн өмнө байгаль орчны төлөв байдлын үнэлгээ (БОТБҮ) хийлгэхийг шаарддаг бөгөөд үйл явцыг л доорх зургаар харууллаа.

Зураг 8. БОТБҮ хийх үйл явц

1

*Төсөл хэрэгжүүлэгч нь төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө **БОТБҮ-г эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.***

2

*БОТБҮ-г үндэслэн БОУАӨЯ болон аймаг, нийслэлийн Байгаль орчны алба **ажлын 14 хоногт багтаан БОННҮ-ний дүгнэлт гаргана.***

3

БОННҮ хийлгэх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гэрээ байгуулан ажиллах бөгөөд мэргэжлийн байгууллага нь БОННҮ болон 5 жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-г боловсруулж хамтад нь БОУАӨЯ-д хүргүүлнэ.

4

*БОННҮ-ний тайланг хүлээн авсан шинжээч **ажлын 18 өдөрт** багтаан үнэлгээний шинжилгээ хийж дүгнэлт гаргана.*

5

БОУАӨЯ-ны БОННҮ-ний мэргэжлийн зөвлөл нь БОННҮ-ний тайлан, түүнд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээчийн болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх талаар эцсийн шийдвэр гаргана.

Дээрх дурдсан БОННҮ-ээс БОМТ болон мониторингийн хөтөлбөр боловсруулдаг бөгөөд эдгээр нь БОННҮ-д багтсан зөвлөмж, дүгнэлтүүдийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байдаг. Уул уурхайн үйл ажиллагаа эхэлсэн тохиолдолд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дараах үе шаттайгаар боловсруулах шаардлагатай байдаг.

Зураг 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үе шат

1

Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн жилийн БОМТ-г Байгаль хамгаалах хууль тогтоомж, БОННУ-ний үр дүн, батлагдсан БОМТ-д үндэслэн ашиглалтын жил бүр шинэчлэн боловсруулна.

2

БОМТ-ний гүйцэтгэл, биелэлтийн тайланг тухайн оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор төсөл хэрэгжиж буй аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлж, төлөвлөгөөний хэрэгжилтийг газар дээр нь шалгуулж ажлын хэсгийн дүгнэлтийг 12 дугаар сарын 1-ний дотор гаргуулна.

3

Ашигт малтмалын орд ашиглаж буй төсөл хэрэгжүүлэгч уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн тухайн оны жилийн мэдээ (маягт БОХ-3)-ний дагуу холбогдох мэдээллийг гаргаж, тухайн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор хүргүүлэх ба уг маягтыг БОМТ-нд заавал хавсаргана.

4

Төсөл хэрэгжүүлэгч нь БОМТ-ний хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг хавсарган дараа жилийн БОМТ-г боловсруулан БОУАӨЯ-нд 12 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ.

5

Төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 101 дүгээр заалтын дагуу БОННУ-ний тайлан, БОМТ-ний хэрэгжилтэд 2 жил тутамд хийлгэсэн байгаль орчны аудитын тайланг тухайн жилийн БОМТ-ний хамт БОУАӨЯ-нд ирүүлнэ.

6

БОУАӨЯ тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээн авч, түүнд дүгнэлтийг үндэслэн биелэлтийг хянаж, дараагийн жилд хэрэгжүүлэх БОМТ-г хянан, батална.

5.6 ЦАХИМ ТАЙЛАГНАЛЫН СИСТЕМ

БОУАӨЯ-аас мэдээлснээр Уул уурхайн олборлолтын төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлан нь **Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар бүлэгт** зааснаар байгаль орчны мэдээллийн сангийн **байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн мэдээллийн хэсэгт хуримтлагддаг** болно.

Үүнийг <https://www.eic.mn/eia/> холбоосоор үзнэ үү.

2024 оны байдлаар батлагдсан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний **нийт 7,875 тайлан** байгаагаас **уул уурхайн чиглэлээр 1,835 тайлан хийгдсэн** байна. Улмаар өнгөрсөн онд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний 184 тайлан хийгдсэн байна.

- Мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдал нэмэгдэх;
- Мэдээллийг цаг алдалгүй, шуурхай авах;
- Өөр өөр эх үүсвэрийн мэдээллийг нэг дороос авах;
- Лицензийн байршил, харьцуулсан үзүүлэлтийн мэдээллийг кадастрын зураглалаас харах;
- Уул уурхайн хайгуул олборлолт, газрын тосны үйлдвэрлэл борлуулалт, туршилтын талаарх нэгдсэн мэдээллийн сангаас хайлт, шүүлт хийж мэдээлэл авах боломжтой.

Зураг 10. Цахим тайлагналын системийг боловсруулахдаа баримталсан зарчмууд

Нээлттэй ба үнэ төлбөргүй мэдээлэл
<ul style="list-style-type: none"> • Мэдээллийг интернетээр нийтлэх, ингэснээр олон нийтэд үнэ төлбөргүй мэдээллийг хүртээх боломжтой.
Олон нийт хандах боломжтой байх
<ul style="list-style-type: none"> • Компьютер ба цахимд суурилсан хэрэгслүүдийг ашиглан мэдээлэлд хандах боломжтой буюу оролцогч талууд өөрсдийн хэрэгцээт мэдээллийг бүх төрлөөр харж боломжтой • Хэрэглэгч өөрийн хүссэнээр дагуу мэдээллийг МОУИТБС-ын өгөгдлийн сангаас шууд татан авч, төрөл бүрийн байдлаар задлан шинжлэх хэрэглэх боломжтой.


Одоогоор <http://eitimongolia.mn/> цахим хуудсаар олон нийт, иргэдэд Монгол Улсын ОУИТБС-ын нэгтгэлийн тайлангуудыг хавсралтуудын хамт үнэ төлбөргүйгээр хүргэхээс гадна уул уурхайн салбарт өрнөж буй үйл ажиллагааны талаар дараах гол статистик тойм мэдээллүүдийг толилуулж байна.

**ЦАХИМ
ХУУДАСНААС
АВАХ
МЭДЭЭЛЭЛ**

- Олгогдсон тусгай зөвшөөрлийн статистик мэдээлэл
- Тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний статистик мэдээлэл
- Хайгуулын ажлын статистик мэдээлэл
- Бүтээгдэхүүн борлуулалтын статистик мэдээлэл
- Татвар төлбөрийн статистик мэдээлэл
- Хандив дэмжлэгийн статистик мэдээлэл
- Тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний мэдээлэл
- Хайгуулын ажлын мэдээлэл
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
- Байгаль орчны нөхөн сэргээлтийн статистик мэдээлэл
- Эдийн засагт оруулсан хувь нэмэрийн талаарх статистик мэдээлэл
- Нутгийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд байгуулсан гэрээ
- Ил тод, нээлттэй компаниуд
- Ашиг хүртэгч эздийн ил тод байдал
- Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ
- Бенефициар эзэд

Эх сурвалж: <https://www.eitimongolia.mn/>

График 15. ОУИТБС-ын Цахим тайлангийн системийн гарын авлага



Эх сурвалж: ОУИТБС-ын Цахим тайлангийн системийн гарын авлага

5.7 АШИГЛАСАН УСНЫ МЭДЭЭЛЭЛ

Ашигласан усны мэдээллийг цахим тайлангийн маягтаар нэгтгэдэг ба 2024 онд нийт **1,598,707,532.28 метр.куб** ус ашиглахаар гэрээ хийснээс **51,820,775.28 метр.куб** буюу гэрээлсэн усны **3.2 хувийг** ашигласан байна. Мөн сонгогдсон 110 компанийн хувьд ус ашигласны төлбөр **61,806,645,197.0 төгрөг төвлөрүүлсэн.**

Хүснэгт 69. Ус ашиглалт

УТГА	ХЭМЖЭЭ
Гэрээнд заасан ашиглах усны хэмжээ (метр куб)	1,598,707,532.3
Ашигласан нийт усны хэмжээ (метр куб)	51,820,775.3
Ашигласан гадаргын усны хэмжээ (метр куб)	1,023,235.0
Ашигласан газрын доорх усны хэмжээ (метр куб)	50,342,435.9
Гэрээнд зааснаас дутуу ашигласан усны хэмжээ (м3)	1,552,148,053.1
Ус ашигласны төлбөр (төгрөг)	61,806,645,197.0
Ус бохирдуулсны төлбөр (төгрөг)	887,255,559.5

Эх сурвалж: <https://www.eitimongolia.mn/>

2024 онд тайланд хамрагдсан нийт 110 компаниас ус ашигласны төлбөр хамгийн өндөр төлсөн **10 компани нийт 60,199,499,280.0 төгрөгийн төлбөр төлсөн буюу нийт төлбөрийн 97 хувийг** бүрдүүлж байна. Усны төлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 24а, б-ээс харна уу.

Хүснэгт 70. 2024 онд ус ашигласны төлбөр төлсөн ТОП 10 компани, сая төгрөгөөр

КОМПАНИЙН НЭР	УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨР	Дүнд эзлэх хувь
1 Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	30,232.9	48.9%
2 Оюутолгой ГХО ХХК	22,124.6	35.8%
3 Энержиресурс ХХК	4,693.1	7.6%
4 Цайртминерал ГХО ХХК	652,711	1.1%
5 Си Өү Эй Эл ХХК	629,638	1.0%
6 Хан алтай ресурс ХХК	549,179	0.9%
7 Шарын гол ХК	465,081	0.8%
8 Саусгоби сэндс ГХО ХХК	429,582	0.7%
9 Наран мандал энтерпрайзес ГХО ХХК	236,427	0.4%
10 Цагаан-Өвөлжөө ХХК	186,315	0.3%
НИЙТ	60,199.5	97%

Эх сурвалж: <https://www.eitimongolia.mn/>

5.8 ХОГ ХАЯГДЛЫН МЭДЭЭЛЭЛ

2024 онд **37 компани нийт 1,531.6 сая төгрөгийг хог, хаягдлын төлбөрт төвлөрүүлсэн** байна.

Энэхүү төлбөр нь Улаанбаатар хот болон 14 аймагт төвлөрсөн бөгөөд хог хаягдлын хэмжээ болон төлбөрийн мэдээллийг Хавсралт 25-аас дэлгэрэнгүй харна уу.

Хүснэгт 71. Хог хаягдлын мэдээлэл, м3

Үйлдвэрээс гарсан хог хаягдал	49,143	Энгийн	39,655
		Аюултай	9,487
Устгасан хог хаягдал	23,963	Аюултай	9,487
		Шатаасан	1,569
		Хими, физикийн аргаар	-

		Бусад	5,677
Мэргэжлийн ААН-д шилжүүлсэн хог хаягдал	25,134	Энгийн	19,100
		Аюултай	6,035

Эх сурвалж: <https://www.eitimonqolia.mn/>

Цахим тайлангийн системд ирүүлсэн мэдээллээс хамгийн өндөр төлбөр төлсөн 10 компанийн мэдээллийг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 72. Хог хаягдлын өндөр төлбөр төлсөн 10 компани, мян.төгрөгөөр

№	КОМПАНИЙН НЭР	АЙМАГ	ТӨЛСӨН ТӨЛБӨР
1	Энержиресурс ХХК	Өмнөговь	768,851.9
2	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	Орхон	522,796
3	Эрдэнэс Таван толгой ХК	Өмнөговь	116,608
4	Хунт-Өгөөж ХХК	Өмнөговь	26,400
5	МАК Цемент ХХК	Дундговь, Дорноговь	18,813.6
6	Платинумланд ХХК	Булган	8,000
7	Саусгоби сэндс ГХО ХХК	Өмнөговь	6,066
8	Олон ихт баян ХХК	Дорноговь	6,000
9	Сора интернэшнл ХХК	Дорноговь	6,000
10	Эрдэнэмонгол ГХО ХХК	Баянхонгор	6,000

Эх сурвалж: <https://www.eitimonqolia.mn/>

5.9 ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРУУЛАЛТ БА ТӨСЛИЙН ЗАРДАЛ (шаардлага 3.4 болон шаардлага 4.10)


5.9.1 Оюутолгой ГХО ХХК-ийн хүлэмжийн хийн ялгаруулалтын тухай

Оюу Толгой ХХК нь 2012 оноос эхлэн сар бүр хүлэмжийн хийн ялгарлыг хэмжиж, Rio Tinto-ийн S&E Survey веб хуудаст бүртгэдэг. Оюу Толгойн **Scope 1** хүлэмжийн хийн ялгарлын гол эх үүсвэр нь **уурхайн дизель тоног төхөөрөмжүүдийн түлшний хэрэглээ** болон **төвлөрсөн дулааны станцын (СНР) нүүрсний хэрэглээ** зэрэг юм. Харин **Scope 2** хүлэмжийн хийн ялгарлыг **БНХАУ-ын Өвөр Монголын Эрчим хүчний сүлжээнээс (ИМРС) худалдан авсан эрчим хүч бүрдүүлдэг**. Сүүлийн жилүүдэд ИМРС сүлжээний сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүд нэмэгдэж, **сүлжээний 60 хувь нь нүүрс, 40 хувь нь сэргээгдэх эрчим хүчний** эх үүсвэрээс бүрдэж байна.

2024 онд Оюу Толгойн уурхайн нийт хүлэмжийн хийн ялгарлын хэмжээ **1.2 сая тонн CO₂ (eq)** байсан бөгөөд үүний **0.35 сая тонн нь Scope 1, 0.85 сая тонн нь Scope 2-т** хамаарч байна. Компанийн абсолют хүлэмжийн хийн ялгарал нь доорх хэрэглээнээс үүдэлтэй:

- 71 хувь нь цахилгаан эрчим хүчний хэрэглээнээс (Scope 2)
- 20 хувь нь дизель түлшний хэрэглээнээс (Scope 1)
- 8 хувь нь нүүрсний хэрэглээнээс (Scope 1)

Зураг 11. 2024 оны хүлэмжийн хийн 1, 2-р хүрээний ялгарал



2023 оны эхнээс эхлэн Rio Tinto компанийн зүгээс Оюу Толгой компанийн өөрийн эзэмшилд ногдох хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор **нийт цахилгааны хэрэглээний 66 хувьтай** тэнцэх хэмжээний Сэргээгдэх Эрчим Хүчний Сертификат (СЭХС, REC) Хятад улсаас худалдан авах замаар Оюу Толгойн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж байна.

2024 оны хувьд **нийт 977 Гига Ватт цаг** эрчим хүчтэй тэнцэх хэмжээний СЭХС худалдан авч, ашигласан бөгөөд энэ нь компанийн нийт хүлэмжийн хийн **ялгарлыг 48 хувиар буюу 0.62 сая тонн CO₂(eq) хүртэл бууруулаад байна.**

